

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 15-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр, Мягмар гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 6
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	7 – 95
1.	<i>Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./</i>	8 – 16
2.	<i>Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийг хүлээн авсантай холбогдуулсан, анхны хэлэлцүүлэг/</i>	16 – 32
3.	<i>Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн саналыг хэлэлцэх, үргэлжлэл/</i>	32 – 40
4.	<i>Цахим орчин дахь өсвөр үеийнхний үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт, сэтгэл санааны хүчирхийлэл, түүний хор уришгийн талаарх Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсролын сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонсох</i>	40 – 95

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 04 дүгээр сарын 15-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 59.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 45 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баасанжаргал, Д.Ганбат, У.Отгонбаяр,
Да.Цогтбаатар;
Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Х.Баттулга, Л.Мөнхбаатар, С.Одонтуяа;
Эмнэлгийн чөлөөтэй: Э.Бат-Амгалан.

Нэг.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын референт Б.Золбоо, Монополын эсрэг газрын дарга Б.Билгүүн, мөн газрын Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах, зар сурталчилгааны газрын дарга Ц.Тэрбиш, Харилцаа холбооны зохицуулах хорооны ажлын албаны дарга А.Лувсан-Очир, мөн хорооны Зохицуулалтын газрын дарга Т.Батболд, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал С.Гантулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Бат.Баярмаа, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.9-д заасны дагуу ажлын хэсгийн саналыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Х.Тэмүүжин, Б.Заяабал, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Ажлын хэсгээс гаргасан саналаар санал хураалт явуулав.

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5-д заасны дагуу Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн холбогдох зүйлийн хүрээнд хууль зүйн дүгнэлт гаргуулах шаардлагатай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 6

Бүгд: 13

53.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, О.Номинчимэг, Л.Соронзонболд, Х.Тэмүүжин, С.Эрдэнэболд нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 92.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулахаас өмнө дээрх хуулийн төслийн талаар холбогдох байгууллагуудын саналыг авах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 2

Бүгд: 13

84.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 15 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийг хүлээн авсантай холбогдуулсан, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, П.Сайнзориг, Х.Тэмүүжин, Л.Соронзонболд нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир хариулж, тайлбар хийв.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс гаргасан, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга"-ийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн “Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэснийг хассугай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн саналыг хэлэлцэх, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингээс гаргасан саналыг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, П.Сайнзориг нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин хэлэлцэж буй асуудлын санал хураалтыг хойшлуулъя гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 16 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Цахим орчин дахь өсвөр үеийнхний үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт, сэтгэл санааны хүчирхийлэл, түүний хор уршгийн талаарх Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсролын сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, сайдын зөвлөх Д.Гантулга, мөн яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Г.Энхтөр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Л.Нямгэрэл, Шүүх шинжилгээний ерөнхий газрын Шүүх анагаах ухааны шинжилгээний газрын дарга А.Амгаланболд, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл боловсруулах хэлтсийн дарга Д.Жанчивдорж, Цагдаагийн ерөнхий газрын Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтсийн дарга Б.Мөнхбат, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Од, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Л.Нямдорж, Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын бодлого хэрэгжүүлэх газрын дарга Т.Батболд мөн хорооны Ажлын албаны дарга А.Лувсан-Очир, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын дарга Б.Баярсайхан, Гэр бүлийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Цогтбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Цахим орчин дахь өсвөр үеийнхний үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт, сэтгэл санааны хүчирхийлэл, түүний хор уршгийн талаарх мэдээллийг Боловсролын сайд П.Наранбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Цахим хөгжил, инновац, харилцаа

холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Од, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул нар танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, М.Нарантуяа-Нара, С.Эрдэнэболд, Ц.Сандаг-Очир, П.Сайнзориг, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Од, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын дарга Б.Баярсайхан, Цагдаагийн ерөнхий газрын Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтсийн дарга Б.Мөнхбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, А.Ариунзаяа, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Цахим орчин дахь өсвөр үеийнхний үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт, сэтгэл санааны хүчирхийлэл, түүний хор уршгийн талаарх Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсролын сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 18 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 4 цаг 00 минут үргэлжилж, 22 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 59.1 хувийн ирцтэйгээр 18 цаг 45 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
14 цаг 45 минут

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаан эхэлж байна.

Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн байгаа тул Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. /алх цохив/

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Хуралдаанд Дамдины Цогтбаатар, Жуковын Алдаржавхлан, Батжаргалын Заяабал, Мөнхтөрийн Нарантуяа-Нараа, Одсүрэнгийн Номинчимэг, Бөхчулууны Пүрэвдорж, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Баттөмөрийн Энхбаяр, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн гишүүд ирцэд бүртгүүлсэн байна. Тэгээд ийм ирцтэйгээр хурал эхэлж байна. Ирц 59.1 хувь.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. /алх цохив/

Өнөөдөр хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудал 4 асуудал байж байгаа.

Нэг.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд.

Засгийн газар 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг. Санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллоо Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэх юм.

Хоёр.Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийг хүлээн авсантай холбогдуулан боловсруулсан. Анхны хэлэлцүүлэг.

Гурав. Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн саналыг хэлэлцэх асуудал байгаа.

Дөрөв. Уахим орчин дахь өсвөр үеийнхний үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт, сэтгэл санааны хүчирхийлэл, түүний хор уршгийн талаар Боловсролын сайд яамны мэдээлэл мэдээллийг хийнэ.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам Төрийн нарийн бичгийнхээ түвшинд оролцож мэдээлэл өгнө.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн оролцоно. Сайд нар нь хөдөө, орон нутагт ажилтай явж байгаа. Гэхдээ гол оруулж байгаа яам нь Боловсролын сайд байгаа учраас Боловсролын сайдыг байлцуулаад бусад яамны Төрийн нарийн бичгүүд оролцоод энэ 4 дэх асуудлаа хэлэлцэнэ.

Ингээд хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүд байна уу? Нэрээ өгнө үү. Алга байна.

Х.Тэмүүжин гишүүнээр тасаллаа. Байхгүй юу. Тэгвэл Х.Тэмүүжин гишүүний нэрийг эндээс хасъя. Хэлэлцэх асуудлаар үг хэлэх гишүүн алга байна. Хэлэлцэх асуудлыг баталлаа.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг,
Санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./

Нэгдүгээр асуудал. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр нэгдсэн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороодод шилжүүлсэн.

Хууль зүйн байнгын хороо хуулийн төслүүдийг 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцсэн бөгөөд гишүүдийн саналаар ажлын хэсэг байгуулан ажиллахаар болсон.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг гурван гишүүнтэй байгуулж, ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нар томилогдон ажиллаж байна.

Хууль зүйн байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд уг хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж, санал, дүгнэлт гарган Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэх ёстой.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.9-д заасны дагуу ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Г.Уянгахишиг танилцуулна.

Г.Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Ажлын хэсэг Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг төсөлтэй хамт боловсруулсан Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хууль, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль, бусад дагалдах хуулиудын төслийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслөөс бусад хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороодод шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хороо нь дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж ажиллах нь зүйтэй гэж шийдвэрлэж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, П.Сайнзориг нарын гишүүдээс бүрдсэн ажлын хэсгийг байгуулсан.

Ажлын хэсэг 2025 оны 04 дүгээр сарын 11 болон 14-ний өдрүүдэд тус тус хуралдаж, хууль санаачлагч болон хуулийн төслийг боловсруулахад оролцсон ажлын хэсгээс зарим тодруулгыг авсан болно.

Ажлын хэсэг дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:

Нэгдүгээрт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Байнгын хорооны хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг явуулахаас өмнө хууль зүйн дүгнэлтийг дараах хүрээнд гаргуулах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

1.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд төлбөр, тааваар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно гэсэн агуулгатай 20 дахь заалтыг Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйл буюу зөвшөөрөл олгох, сунгах, шинээр бий болгоход баримтлах зарчим, хэрэгжүүлэх хүрээ гэсэн зүйлд нэмэхээр хуулийн төсөлд тусгасан нь хууль зүйн техник болон хууль хоорондын нийцлийг хангаж байгаа эсэх, тодорхой үйл ажиллагааг эрхлэхийг хориглох зохицуулалтад уг хуулийн зорилтод нийцэж байгаа эсэх талаар.

2.Тодорхой салбарын хуулиар, эсвэл бие даасан аль нэг хуулиар хориглоогүй аливаа харилцааг Эрүүгийн хуульд гэмт хэрэгт тооцохоор нэмж хуульчлах нь эрх зүйн хувьд сөрөг үр дагавартай бөгөөд гэмт хэрэг тооцох үйлдлийг бүрэн тодорхойлж зохицуулаагүй байдал нь аливаа этгээдийг хэлмэгдүүлэх, эрүүгийн хариуцлага хүлээлгэх, эсвэл ял завшуулах эрсдэлийг үүсгэж болзошгүй байна.

Иймд Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл нь хууль зүйн техник, хууль эрх зүйн хувьд зөрчилтэй эсэх, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд боломжит хувилбарын талаар тус тус хууль зүйн дүгнэлт гаргуулах.

Хоёрдугаарт, Эрүүгийн хуульд нэмэлт оруулснаар шинээр гэмт хэргийг зүйлчлэл бий болгож байгаа тул Хүний эрхийн Үндэсний Комисс, Улсын дээд шүүх болон Улсын ерөнхий прокуророос хуулийн төсөлтэй холбогдуулан санал авах зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

Гуравдугаарт, дээр дурдсан хууль зүйн дүгнэлт, холбогдох байгууллагуудын саналыг авсны үндсэн дээр Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдэд тусгагдсан асуудлаар хуулийн техникийн засварыг хийх, зарим нэр томъёог оновчтой болгох, хууль хоорондын нийцлийг хангах зэрэг асуудлаар зарчмын зөрүүтэй саналуудыг боловсруулан ажиллах саналтай байна.

Д.Цогтбаатар: Г.Уянгахишиг гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хуралдаанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын референт Б.Золбоо, Монополын эсрэг газрын дарга Б.Билгүүн, Монополын эсрэг газрын Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах, зар сурталчилгааны газрын дарга Ц.Тэрбиш, Харилцаа холбооны зохицуулах хорооны ажлын албаны дарга А.Лувсан-Очир, Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын газрын дарга Т.Батболд, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Дотоод хэргийн их сургуулийн захирал, доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа С.Гантулга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг өнөөдрийн хуралдаанд оролцож байна. Бүгдээрээ ирсэн байгаа юу? Тийм ээ.

Ингээд хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцууллаа.

Ажлын хэсгийн саналтай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Б.Заяабал гишүүнээр тасаллаа. Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье. Үг хэлэх, асуулт асуух хоёр хамт шүү. Би сая тэгж зарласан. Тийм.

Б.Энхбаяр: Ажлын хэсгээс боловсруулсан саналыг дэмжиж байна. Хууль зүйн дүгнэлт гаргуулъя гэдэг зарчмын саналыг дэмжиж байна.

Тэгэхдээ Хууль зүйн байнгын хороо энэ асуудалтай холбоотойгоор нэг зүйлийг анхааруулж хэлмээр байна. Яагаад гэхээр Засгийн газраас Зөвшөөрлийн хууль дагалдуулж Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг парламентын Байнгын хороо гүйцээж ажиллах ийм нөхцөл байдал үүсэж байгаа нь харамсалтай.

Тэр байтугай энэ хуулийг хэлэлцэх эсэх асуудал Хууль зүйн байнгын хороогоор ороогүй. Эрүүгийн хуулийн өөрчлөлт ярьж байгаа шүү дээ.

Тэгээд сая Г.Уянгахишиг гишүүн хэлж байна. Эрүүгийн хуулийн өөрчлөлт Улсын Их Хуралд оруулж ирж байгаа атлаа Улсын дээд шүүх, прокурор, Хүний эрхийн комисс, Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбооноос санал аваагүй.

Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр Эрүүгийн хууль, Зөрчлийн хуулийн асуудлаар байнгын ажлын хэсэг байгаа. Энэ ажлын хэсэг дээрээ яриагүй.

Хууль зүй, дотоод хэргийн яамны санал байхгүй. Энэ одоо юу болж байгаа вэ?

Эрүүгийн хуулийг дуртай яам нь хийдэг болчихсон юм уу?

Хууль зүйн яам бодлогоо баримаар байна. Эрүүгийн хууль оруулж ирж байж Хууль зүйн яам энэ чинь гол эрүүгийн ял шийтгэлийн бодлогоо хариуцаж

байгаа яам нь боловсруулдаггүй. Зүгээр үзэл баримтлал батлаад хаячихдаг. Хэзээ ийм байсан юм.

Эрүүгийн хуулийн өөрчлөлт байна шүү дээ. Хууль зүйн яамаар орохгүйгээр орж ирж байсан түүх би мэдэхгүй байна.

Улсын дээд шүүх, прокурорын байгууллагуудын саналыг авахгүйгээр оруулж ирсэн түүх бас мэдэхгүй байна.

Шүүхийн хууль дээр бид биччихсэн шүү дээ. Эрүү, эрүүгийн процессын хууль дээр Монгол Улсын Дээд шүүхийн саналыг заавал авна гэдэг бүр хуулийн заалт байгаа. Шүүхийн хууль дээр. Энэ хуулийн заалт зөрчигдөж байгаа байхгүй юу. Тэгээд бодлогоо жоохон базаж ажилламаар байна.

Байнгын хороон дээр Хууль зүйн сайдыг байлгаж баймаар байна. Шинэ хуулиар чинь манай Хууль зүйн байнгын хороо Хууль зүйн сайдгүйгээр хууль зүйн бодлого яриад суугаад байгаа байхгүй юу. Хууль зүйн сайдад анхааруулмаар байна. Салбарынхаа бодлогыг барьж ажилла гэж.

Д.Цогтбаатар: Х.Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Миний хэлэх гэж байсан үгийг бараг хэлчихлээ.

Энэ хууль нь дагаж өргөн барихдаа Эрүүгийн хууль өргөн барьчихсан байгаа.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын бичиг байна. Хууль тогтоомжийн хуулийн 19.¹ дүгээр зүйлийн 19^{1.1} дэх хэсэгт зааснаар Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна гэсэн үг байгаа байхгүй юу.

Эрүүгийн хууль дээр Хууль зүйн яам хэлбэр дүрс харж суух ерөөсөө үүрэггүй. Ялын бодлогоо юуг гэмт хэрэг. Энэ чинь Монгол Улсын иргэнийг шийтгэх гэж байна шүү дээ. Яллах гэж байна. Эрх чөлөөг нь хязгаарлах гэж байна.

Яагаад ийм үйлдлийг гэмт хэрэг гэж үзэх гэж байгаа юм, ямар ял илүү зохимжтой юм гэдэг Хууль зүйн яамных нь өөрийнх нь дүгнэлт байх ёстой байхгүй. Энд. Тэр нь байхгүй байна. Нэгдүгээрт.

Яах гэж Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль зөвхөн Хууль зүйн яамны эрхлэх асуудлын хүрээнд иргэнийг шийтгэх ямар нэгэн шийтгэлийг Хууль зүйн яамны шүүлтүүргүйгээр Улсын Их Хурал руу өргөж болохгүй гэдэг энэ зарчим орж ирсэн гол шалтгаан энэ шүү дээ.

Нөгөө “гуя дагуулаад хүзүү” гэдэг шиг биччихсэн. Монгол Улсын иргэнийг яллаж шийтгэх бодлого энэ юмны хормой доор явж байж ерөөсөө болохгүй.

Засгийн газрын ажлыг Улсын Их Хурал хийж болохгүй. Өмнөөс нь. Засгийн газар дутуу ажилласан бол буцаад үүнийг нь шидэх ёстой шүү дээ. Засгийн газар тэндээ ажиллах ёстой. Зардал мөнгө, хүн нөөц бүх юм нь тэнд байж байгаа. Тэр ажлаа хийхгүй бид “толгойг нь илээд, за яах вэ” гээд энд Улсын Их Хурлын гишүүдийн махыг идэж болохгүй.

Г.Уянгахишиг ганцаараа эрүүгийн бодлогыг тодорхойлоод энд засах гээд сууж байж болохгүй шүү дээ.

Хоёрт нь, дахиад жоохон зохимжгүй байгаа юм нь Зөвшөөрлийн тухай хуульд хориглох заалт бичээд, Зөвшөөрлийн хууль нь тэр нь байх уу, байхгүй гээд тусдаа яригдах байх. Гэхдээ Эрүүгийн хуульд “гэмт хэрэг” гэж бичих гэж байгаа бол энэ харилцааг зохицуулсан ерөнхий хууль нь гарах ёстой шүү дээ. Өмнө нь. Тэгээд тэр хуулиасаа аль нь Зөрчил рүү, аль нь Эрүүгийн хууль руу “гэмт хэрэг” болж орж ирж байгаа юм гэдэг концепц нь маш тодорхой байх ёстой.

Гэтэл өмнөх ерөнхий хууль нь байхгүй. Үндсэн харилцаагаа зохицуулж байгаа хууль байхгүй. Зүгээр шууд Эрүүгийн хуульд нь бичиж байна.

Эрүүгийн хуульд гэмт хэргийг шууд бичих ганцхан тохиолдол байгаа. Үндсэн хуульд байгаа хууль. Түүнээс бусад тохиолдолд үндсэн зохицуулалтынх нь хууль гарч ирж байж дараа нь тэр зохицуулалтаасаа

- ▶ энэ хэсэг нь Эрүүгийн хуулиар хамгаалагдана,
- ▶ энэ хэсэг нь Зөрчлийн хуулиар тодорхойлогдоно,
- ▶ энэ хэсэг нь ямар нэгэн ял шийтгэлгүйгээр зохицуулалтын шинжтэй байна гэдэг хэмжээ хязгаар гарч ирэх ёстой байхгүй юу.

Дээр нь одоо байгаа зүйл, заалттай давхардсан утга агуулгууд байгаад байна шүү дээ. Шүүхийн хэрэглээнд тэгээд алийг нь хэрэглэх юм? Ийм нэг маргаанууд байна. Тэгээд нөгөө.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Б.Заяабал гишүүний микрофоныг өгье.

Б.Заяабал: Тэгэхээр бас л яг адилхан зарчмын саналууд бол адилхан байгаа гэдгийг нэгдүгээрт хэлье.

Тэгээд Эрүүгийн хууль дээр төлбөр таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэхийг хориглох тухай оруулж ирж байгаа.

Энэ дээр хувь хүн, аж ахуйн нэгж өөрийн бизнесээ сурталчлах зорилгоор интернэтээр азтан LIVE, дэлгүүр, лангуунууд, хөгжөөнт тоглоом, худалдан авалтын урамшуулал, сугалаа гэх мэт маркетинг сурталчилгааны чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг. Урамшуулалд эрх бэлэн мөнгө гэх мэтчилэн олгодог. Энэ хуулиар хоригдож байна уу, хоригдохгүй байна уу гэдэг нь тодорхойгүй л байгаад байна л даа. Өөрөөр хэлбэл Эрүүгийн хуулийн орж ирж байгаа заалтууд чинь аягүй тодорхойгүй юмнууд орж ирж байна. Яах аргагүй холбогдох байгууллагуудын санал аваагүйтэй холбоотой байдаг юм байна даа л гэж ойлгоод сууж байна.

20.18.1 дээр бас байгаа юм. Би өмнө чуулган дээр хэлэлцэх эсэхийг шийдэх гээд асууж байсан.

Энгийн иргэд гэртээ тоглох, найз нөхдийндөө тоглох, албан газар дээрээ тоглох, малчид нэгнийдээ цуглаад тоглох ийм үед яах вэ гэж асуусан. Энэ хамаарахгүй гэж хэлээд байгаа юм.

Хууль дээрээ гэж оруулж ирсэн бэ гэхээр олон нийтийн газар, эсвэл цахим сүлжээ ашиглан төлбөр, таавар, бооцоот тоглоом гээд оруулаад ирчихсэн байгаа юм.

Тэгэхээр эндээс хараад үзэхээр “олон нийтийн газар” л байвал болохгүй, бусад газар байвал болно гэж ойлгогдоод байгаа юм.

Гэтэл дагаж өргөн барьсан тэр татварын хуулиуд дээрээ аваад үзэхээр аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон хувь хүний орлогын албан татвар дээр ерөөсөө энэ төрлийн орлого олохыг тайлагнуулахгүй. Энэ төрлийн орлого олох нь угаасаа тайлагнах ямар нэгэн тийм боломжгүй учраас энэ нь өөрөө хууль бус гээд оруулаад ирчхээд байгаа юм.

Дээрээс нь энэ хоёр орлогын албан татварын хууль дээр байгаа төлбөрт, бооцоот таавар, тоглоомоос олсон орлогоо тайлагнах боломжгүй болчихоор Монгол Улсын иргэн хүн гадаадад казинод тоглоод орлого олж болохгүй болчихоод байгаа юм.

Тэгээд хэрвээ орлогыг нь зөвшөөрч байгаа юм бол буцаад энэ татварын хуулиудаараа эдгээр орлогуудыгаа тайлагнах эрх нь нээлттэй байх ёстой шүү дээ. Гэтэл хувь хүний орлогын албан татвар болон аж ахуйн нэгжийн орлогын албан татвар дээр үүнийг нь аль алийг нь хорьчихсон.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар дээр тухайн аж ахуйн нэгж энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлж орлого олох тусдаа, энэ төрлийн үйл ажиллагаанд оролцож хонжвор хожих орлого тусдаа. Ингээд тус тусдаа энэ чинь татвар төлөх хувь хэмжээ нь өөр, тайлагнал нь өөр байхгүй юу.

Гэтэл энэ хуулиар хоёуланг нь хорьчихож байгаа юм. Ямар ч төрлийн төлбөрт таавар, бооцоот мөрийтэй тоглоомоос орлого олж болохгүй гээд хорьчихоор чинь ерөөсөө Монгол Улсын иргэн Монголдоо төдийгүй гадаадад, найз нөхдийндөө, ахуйн гэх юм уу даа, нэгнийдээ цуглаад тоглох энэ бүх олсон орлогоо тодорхойлох боломжгүй болчихоор угаасаа хууль бус болчихоод байгаа юм.

Д.Цогтбаатар: Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Би цөөхөн зүйл хэлээдэхье.

Манай Байнгын хорооны гишүүдийн ерөнхий хандлага, уур амьсгалыг ажлын хэсгийнхэн өөрсдөө сонсож ойлгож байгаа байх. Би ч гэсэн Байнгын хорооны гишүүдтэйгээ санал нэг байна. Эрүүгийн хуулийг хууль дагуулж оруулж ирж өөрчилнө гэдэг өөрөө ноцтой үр дагавартай. Тэгээд хамгийн гол нь гишүүддээ харин хандаад хэлэхэд Хууль зүйн яам нь дэмжээгүй юм билээ шүү дээ. Дэмжээгүй гэсэн мэдээ надад одоо орж ирж байна. Тийм. Харин тийм.

Тэгэхээр надад тийм ер нь л зөвшөөрөөгүй гэсэн мэдээ тэгвэл өгөөд байгаа юм.

Тэгэхээр энэ дээр Хууль тогтоомжийн хууль, одоо бид нөгөө нэмэлт, өөрчлөлт оруулж ирж байгаагийн ач холбогдол яг энэ дээр гарч ирж байгаа юм. Юу гэвэл одоо яг энэ дээр чинь Хүний эрхийн комиссын. Зөвшөөрөөгүй бол ерөөсөө орж ирж болохгүй. Яг үнэн. Б.Энхбаяр сайдын хэлж байгаа нь үнэн байгаа юм.

Тэгэхээр Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу заавал Хүний эрхийн комисс, шүүх, прокуророос энэ хүний эрхэд халдаж байгаа ийм хуулиуд дээр үнэлгээ хийж, санал авсан байна. Тэгэхгүйгээр ерөөсөө хууль хэлэлцэх босгыг давахгүй гэж бид оруулж ирээд байгаа чинь Хууль тогтоомжийн хуульд оруулж байгаа өөрчлөлтийн ач холбогдол яг энэ дээр гарч ирж байгаа байхгүй юу.

Яагаад гэвэл манай гишүүд яг үүнийг ярьж байна шүү дээ. Энэ байхгүй байгаа учраас энэ дээр дараа нь эрх зүйн гарах үр дагаврыг бид тооцож хэлж чадахгүй байна гээд. Тэгээд би ажлын хэсгийн саналуудтай санал нэг байна. Энд хууль зүйн дүгнэлт гаргая гэсэн саналууд орж ирж байна.

Одоо би хоёр асуудлаар санал хураалт явуулна. Ажлын хэсгийн оруулж ирж байгаа саналын дагуу. Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан ажлын хэсгийн хоёр саналаар саналд хураана гэж сая хэллээ.

Нэгд.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34.5-д заасны дагуу Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн холбогдох зүйлийн хүрээнд хууль зүйн

дүгнэлт гаргуулах шаардлагатай гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

53.8 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд О.Номинчимэг гишүүн, Л.Соронзонболд гишүүн, Х.Тэмүүжин гишүүнийг дэмжсэн гэж бүртгээрэй. Ж.Алдаржавхлан гишүүн бас дэмжсэн. С.Эрдэнэболд гишүүн дэмжсэн гэж бүртгэж аваарай.

Хоёр дахь асуудлаар санал хураалт явуулъя.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулахаас өмнө дээрх хуулийн төслийн талаар холбогдох байгууллагуудын саналыг авах нь зүйтэй гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

84.6 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд ажлын хэсгийн санал дэмжигдсэн тул Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн холбогдох зүйлийн хүрээнд хууль зүйн дүгнэлт гаргуулах тухай Байнгын хорооны шийдвэрийг Улсын Их Хурлын Тамгын газарт хүргүүлж, мөн хуулийн төслийн талаарх саналыг холбогдох байгууллагуудаас авах нь зүйтэй гэж шийдвэрлэлээ.

Ажлын хэсэгт баярлалаа.

Дараагийн асуудалдаа оръё.

**Хоёр.Монгол Улсын шүүхийн тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**
/Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийг
хүлээн авсантай холбогдуулсан,
анхны хэлэлцүүлэг/

Хоёрдугаар асуудал. Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Анхны хэлэлцүүлэг байгаа.

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийг хүлээн авсантай холбогдуулан боловсруулсан санал орж ирж байгаа.

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84.3-д заасны дагуу боловсруулсан Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Ц.Сандаг-Очир танилцуулна.

Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийг Монгол Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 06 дугаар тогтоолоор Монгол Улсын шүүхийн тухай хуулийн холбогдох заалтад өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.

Ажлын хэсэгт ажлын хэсгийн ахлагчаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, ажлын хэсгийн гишүүдэд Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Б.Заяабал, М.Нарантуяа-Нара, Л.Соронзонболд нар ажиллаж байгаа бөгөөд ажлын хэсэг 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр хуралдаж, Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан шүүхийн бие даасан шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль зүй, эдийн засаг, нийгэм болоод бусад баталгааг бүрдүүлэх үүднээс холбогдох бусад хуульд нийцүүлэн хуулийн төслийг боловсрууллаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтээр Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн өндөр насны тэтгэвэр тогтоолгоно гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж дүгнэсэн бөгөөд хуулийн мөн хэсгийн шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаар 60 нас байх ба 55 насанд хүрсэн, эсхүл шүүгчээр нийт 25 жил ажилласан шүүгч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно гэсэн зохицуулалтын талаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл хэсэгт тухайлан дурдаагүй байна.

Ажлын хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.3, 84.5 дахь хэсэгт заасны дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгохтой холбогдох харилцааг Төрийн албаны тухай

хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэг, нийгмийн даатгалын сангаас олгох Тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгтэй нийцүүлэн шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаар нь 65 нас байх ба холбогдох хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн бол тэтгэвэр тогтоолгож болох. Мөн одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн зохицуулалтын дагуу нас харгалзахгүйгээр шүүгчээр 25 жил ажилласан шүүгч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгож болох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа.

Мөн Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хуулийн нэр томъёог хоёрдмол утгагүй товч тодорхой илэрхийлэх нийтлэг шаардлагын хүрээнд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.7 дахь хэсэгт холбогдох өөрчлөлтийг тусгасан болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Д.Цогтбаатар: Ц.Сандаг-Очир даргад баярлалаа.

Ажлын хэсгийн танилцуулга болон хуулийн төслийг Та бүхэнд тараасан байгаа.

Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Б.Энхбаяр гишүүнээр тасаллаа. Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Энэ заалт дээр Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Үндсэн хуулийн цэц дээр хуулиа хамгаалж оролцож байсан.

Цэцийн шийдвэрийг Улсын Их Хурал хүлээж авсан. Тэгэхдээ цэцийн шийдвэр 47.6.2 дахь өгүүлбэр дээр л Үндсэн хууль зөрчсөн гэсэн болохоос биш тэтгэвэрт гарах насны дээд хязгаар 60 нас байгааг Үндсэн хууль зөрчсөн гэж үзээгүй санагдаад байх юм.

Үүнийг нь ажлын хэсэг 60 байгааг нь 65 болгоё гэдэг санал оруулж ирж байгаа юм байна. Нэгдүгээр өөрчлөлт нь.

Тэгэхээр би үүнийг нэгдүгээрт ажлын хэсгээс тодруулж асууж байгаа юм. Яагаад цэцийн Үндсэн хууль зөрчөөгүй гэж шийдсэн 60 насыг нь 65 болгочхож байгаа вэ гэсэн асуулт байгаа юм.

Хоёрдугаарт, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа шүүхийн хуулийн 47.6 дээр холбогдох хуульд заасан гэдэг нөхцөл заасан хэсэг нэмж байгаа юм байна. Энэ холбогдох хуульд заасан гэдэг хэсгийг нэмж байгаагийн утга нь эрэгтэй, эмэгтэй насны ялгаа байгаа учраас “холбогдох хуульд заасан” гэдэг нэг өгүүлбэрээр 55, 60-ыг хэлж багцлах зорилгоор ингэжхэв үү? Яагаад ийм өгүүлбэр нэмчхэв?

“Холбогдох хуульд заасан” гэдэг бол ерөөсөө л энэ хууль л даа. Тэтгэвэрт гарах насыг 47.6-гаар л хэлж өгөөд байгаа юм. Өөр хууль эшлээд байгаагийн утга билээ? Өөр өөр эшлээд явчихаар өөр нэг хуульд нэг нас өөрчлөгдөхөөр шүүгчийн нас бас өөрчлөгдөөд байна гэсэн логик гарах гээд байх шиг байх юм.

Би энэ хууль дээрээ л ойлгомжтой байвал ямар байдаг юм бол доо гэсэн ийм заалт байна.

Гуравдугаарт, нас харгалзахгүйгээр гэдгийг яагаад оруулж ирсэн юм бол? Шүүгчээр 25 жил ажилласан шүүгч гээд одоо үйлчилж байгаа хуулиараа байхаар яагаад болохгүй, энэ “нас харгалзахгүйгээр” гэдэг нөхцөлийг яагаад заагаад оруулаад ирсэн юм бол?

Ер нь 47.6-гийнхаа тэр цэцийн дүгнэлтэд байгаа зөрчсөн гэж дүгнэлт гаргасан хоёр дахь өгүүлбэрээ хүчингүй болгоход л тэгээд болох юм биш үү.

Хүчингүй болгосоноороо байгаад л. Тэгээд 47.6-гийнхаа “Үндсэн хууль зөрчөөгүй” гэж үзсэн эхний өгүүлбэр нь хүчин төгөлдөр байж байхад л бид цэцийн шийдвэрийн нөхцөл байдал хангагдаад болох юм биш үү гэсэн ийм асуулт байна.

Д.Цогтбаатар: Би ажлын хэсгээ танилцуулаагүй өнгөрөөд явчихсан байна. Ажлын хэсэгт Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Л.Энхбилэг нар оролцож байна.

Ажлын хэсгээс хариулъя. Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Нэмбэл Шүүхийн ерөнхий зөвлөлөөс хариулна биз.

Б.Энхбаяр гишүүний асуултад хариулъя.

Яг зөв асуулт асууж байна. Бид ажлын хэсэг дээр яриад яг Үндсэн хуулийн зөрчсөн тэр 47.6-гийн хоёр дахь өгүүлбэрийг авбал аваад болохоор байгаа юм.

Гэхдээ хэрвээ тэр өгүүлбэрийг хүчингүй болголоо гэхэд зөрчилтэй бас асуудал дутуу үлдэх гээд байгаа юм. 60 насаараа.

Гэтэл Төрийн албаны хуулиараа төрийн албаны насны дээд хязгаар 65 гэж байгаа.

Тэгэхээр бас ийм маргаантай дутуу асуудал үүсээд байгаа учраас, бид Хууль тогтоомжийн тухай хуулиараа нэгэнт Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж авсантай холбогдуулаад шүүхийн тухай хуулийн 47.6-г нэг мөр нэмэлт, өөрчлөлт оруулж байгаатай холбогдуулаад холбогдох хуульд буюу төрийн албаны тухай хуульд нийцүүлээд насны дээд хязгаар буюу 65 нас байх, 60-ыг 65 гэж оруулж ирсэн. Ингээд нэмэлт, өөрчлөлтөөр хийчихье гэж ажлын хэсэг дээр ярьсан юм аа. Ярьсан юм.

Шүүхийн тухай хуулийн 47.6, 47.7 хоёр одоо мөрдөгдөж байгаа хууль.

47.7 өөрөө бас их утга агуулгын зөрүүтэй ийм хууль байгаа юм. Уг нь шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах харилцааг 47.6-гаар зохицуулж байгаа юм. Зохицуулж байгаа юм. Гэтэл 47.7 дээрээ шүүгчийн тэтгэвэртэй холбогдсон харилцааг “холбогдох хуулиар” гээд. Ингээд үндсэндээ бараг 47.6-г үгүйсгэсэн маягийн. “Тэтгэвэртэй холбогдсон харилцааг холбогдох хуулиар” гээд.

Тэгэхээр “холбогдох хууль” нь болохоор Хөдөлмөрийн хууль, Нийгмийн даатгалаас олгох тэтгэврийн тухай хууль, Төрийн албаны хууль гээд энэ хуулиудаар зохицуулах юм шиг.

Ингээд Шүүхийн тухай хуулиараа шүүгчийн тэтгэвэрт гарах харилцааг зохицуулаад байгаа юм уу, аль эсвэл холбогдох хуулиар нь зохицуулах юм уу гэдэг ийм хоёрдмол утгатай 47.7 чинь байгаад байгаа юм.

Тэгэхээр бид 60 насыг нь 65 болгоод. Одоо мөрдөгдөж байгаа тэр Үндсэн хууль зөрчсөн гэдэг заалт чинь эрэгтэй, эмэгтэй ялгахгүйгээр 55 нас хүрсэн гэсэн байгаа юм.

Гэтэл 4 хүүхэдтэй эмэгтэй шүүгч Төрийн албаны хуулиар тэтгэвэрт гарах болзол боломж байгаа байхгүй юу. Нээгдчихсэн.

Гэтэл Шүүхийн тухай хуулийн 47.6-аар заавал 55-тай л байх ёстой гэдэг. Ингээд хуульчилчихсан байгаа юм.

Тэгэхээр бид “холбогдох хуулиар” гэж оруулж ирж байгаа нь тэр Хөдөлмөрийн хуулиа, Төрийн албаны хуулиа.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээгээд хариулъя.

Ц.Сандаг-Очир: Тийм учраас холбогдох хуулиар гээд оруулаад ирчхээр тэр нөхцөл шаардсан тэр боломж нь нээгдчих юм байна гэж үзэж, тэгээд 4 хүүхэдтэй 50 настай шүүгч гарах бололцоо, боломжийг нь олгож. Өнгөрсөн

хугацаанд гэхэд 2 шүүгч яг энэ нөхцөлөөр тэтгэвэрт гарсан байх жишээтэй байна. Ийм кэйс байна.

Тийм учраас бид ингэж зааж өгч, тэр тодорхой нөхцөлийг нь зааж өгсөн юм гэдгийг хэлье.

Д.Цогтбаатар: П.Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Би Б.Энхбаяр гишүүнийхтэй төстэй.

Үндсэн хуулийн цэцээс гарсан холбогдох шийдвэрийг Улсын Их Хурал хүлээж аваад энэ хүрээндээ л хуульд өөрчлөлт оруулах ёстой.

Гэтэл энэ хүлээж авсан хэмжээ хязгаараасаа яваад 60-ыг 65 болгоно гээд байгаа байхгүй юу. Тэгвэл яг Ц.Сандаг-Очир гишүүний хэлж байгаагаар 47.4-ийг ярих ёстой л доо. Шүүгчээр ажиллаж байхдаа хөдөлмөрийн чадвараа алдвал 70 хувиар өгч байгаа шүү дээ. Аль ч мэргэжилтнүүдэд, аль ч төрийн албан хаагчид ийм байдлаар өгөхгүй байгаа. Үгүй ээ, энэ чинь тэгвэл нөгөө бусад хуультайгаа зөрчилдөж байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид хэд уг нь онцлог онцлогоор нь Шүүхийн тухай хууль нэгдүгээрт үйлчилнэ, харилцааг нь бол энэгүй түлхүү зохицуулна гэж байсан болохоос биш яг үүнийг далимдуулаад ингээд шүүхийн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд заагаагүй ийм байдлаар хуулийг өөрчлөөд Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг хүлээж авч байна гэж ярьж болох юм уу. Энэ чинь аймаар том жишиг тогтоно байна шүү дээ.

Ер нь цэцийн шийдвэрийг хүлээж авч байхдаа бас нэг зөрчилтэй юм харагдаад байна гэнгүүтээ ямар нэгэн байдлаар үзэл баримтлал тодорхойлогдоогүй, судалгаа хийгдээгүй ийм зүйлүүдийг дагаж засна гэдэг. Энэ бол одоо манай Хууль зүйн байнгын хороон дээр цааш цаашдаа тэгвэл цэцийн шийдвэрийг хүлээж аваад ингээд засчихъя гээд л явах нь байна шүү дээ.

Тэгэхээр энэ жишгээ бодоод би зүгээр болж байна уу, үгүй юу.

60 насыг үнэхээр 65 болгох ёстой гэвэл бид хэд тусдаа хууль тогтоомжийн хуульд заасны дагуу хууль санаачлах ёстой юм биш үү? Би үүнийг л ажлын хэсгээс асуух гэж байгаа юм.

Үзэл баримтлалаа тодорхойлоод, ийм ийм үндэслэл байгаа учраас гээд. Тэгээд нэг мөр. Д.Цогтбаатар дарга хэлж байсан даа. Зөвхөн шүүхийн хууль биш прокурорын хууль, өөр аль хуулиуд дээр байгаа юм. Нийтлэг хууль зүйн салбар дээр нэг жишгийг нь тогтоогоод 65 болох бол

үүнийгээ бие даасан үзэл баримтлалаа тодорхойлоод явах нь зүйтэй юм биш үү.

Тэгэхээр цэцийн шийдвэрээ хүлээж аваад зүгээр хоёр дахь өгүүлбэрээ хасаад өнгөрөхгүйгүй бол бид Хууль зүйн байнгын хороо цаашдаа зөвтгөж болохгүй тийм жишиг тогтоочих вий дээ гэдэг ийм болгоомжлол байна.

Үнэхээр тэр Төрийн албаны хуультай зөрчилдөх зүйлүүд ч юм уу, бусад хуулиудтай зөрчилдөх, шүүгчийн онцлогтой нь хамаагүй ээ, зөрчилдөж байгаа гэж үзэх юм бол тэр 47.4-д ч байгаа ч гэсэн 70 хувиар нөхөх, хөдөлмөрийн чадвараа алдсаны, тэтгэвэр тогтоолгоод хэдэн хувиар ч авч байгаа билээ. Энэ чинь. Тэд нарыг нь засъя л даа. Тэрийг чинь бусад жирийн албан хаагчид үзэхгүй байгаа шүү дээ.

Яагаад шүүгчээр ажиллаж байгаа хүмүүс чинь ийм өндрөөр тэтгэврээ тогтоолгоод, бид ийм багаар тогтоолгодог юм бэ гээд барьцаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр хэдүүлээ жишээ авч ярихдаа нэгийг нь үгүйсгээд нөгөөдхийг нь зөв болгож байгаа юм шиг яваад энэ буруу жишиг рүү явах гэж байна.

Тийм учраас Үндсэн хуулийн цэцийнхээ дүгнэлтийн хүрээнд хүлээж аваад. Харин тэр 60-ыг 65 болгох гэж байгаа бол тусдаа үзэл баримтлалаа, хуулиа санаачлаад, хэлэлцүүлээд, хуулийн дагуу явъя л гэдэг санал байна.

Энэ дээр тэгээд ажлын хэсэг ямар.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: П.Сайнзориг гишүүн ээ, би дэгийн тухай хуулийн 84.3-ыг танд уншиж өгье.

Хууль тогтоол Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэсэн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн бол ажлын 15 өдрийн дотор тухайн болон холбогдох бусад хууль, шийдвэрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулна гэж байгаа юм.

Тэгэхээр яг энэ 47.6, 47.7-д оруулж байгаа өөрчлөлтөөр цэцийн дүгнэлтийг хүлээж авсантай холбогдуулаад нэмэлт, өөрчлөлт оруулж болох дэгийн тухай хуулиараа зохицуулагдсан байгаа.

Бид Та бүхний ярьж байгаа асуудлыг ажлын хэсэг дээрээ ярьсан. Энэ зүгээр хоёр дахь өгүүлбэрийг хүлээж аваад хүчингүй болгох шиг амархан юм байхгүй.

Тэгэхээр цаана нь ахиад л шүүгчтэй холбоотой төрийн албаны чинь насны дээд хязгаар нь 65 гээд заачихсан байж байхад одоо бид үүгээр нь орхичихоор 60 гээд бас л дутуу үлдчхээд байгаа юм.

Тийм учраас нэгмөсөн нэмэлт, өөрчлөлт оруулаад, дүгнэлтийг нь хүлээж авсантай холбогдуулаад энэ зөрчлийг нь засаад явчихъя гэж байгаа юм.

Таны ярьсан асуудлыг бас бид өчигдөр ажлын хэсэг дээр ярьсан.

Прокурорын тухай хууль, шүүхийн тухай хууль, өмгөөллийн тухай хууль гээд маш олон хуулиудад тэтгэвэрт гарах харилцааг ер нь нэгдсэн байдлаар насны хязгаарын хувьд шийдэх юм уу, эсвэл салбар салбарынхаа хуулиудаар зохицуулж явах юм уу гэдэг асуудлыг цаашдаа нэг мөр ярих л ёстой юм билээ.

Тэгэхгүй янз бүрийн. Тэтгэврийн насны дээд хязгаар нь 65 гээд Төрийн албаны хуульдаа заасан хэрнээ салбарын хуулиуд дээрээ болохоор ингээд.

Сая дөнгөж долоо хоногийн өмнө бид прокурорын даргыг томиллоо шүү дээ. Улираан. Гэтэл тэнд бас л прокурорын тухай хууль зөрчигдөх асуудал үүсэж байгаа байхгүй юу. Хуульдаа 60 гэсэн байна. Гэтэл 61-тэй хүнийг бид оруулж ирсэн.

Тэгэхээр цаашдаа шүүх, прокурор нарын тэтгэвэрт гарах насны асуудлыг цогц байдлаар авч үзэж эргэж харахгүй бол салбар салбарын хуулиудаараа зохицуулагдаад явахаар тэтгэвэрт гарах насны асуудал маргаантай байдал хэвээр үргэлжлээд л явах юм байна л гэж би хувьдаа харж байгаа. Ажлын хэсэг дээр ингэж ярьсан.

Бас нэмж тайлбарлаж болно шүү. Манай ажлын хэсгээс, Шүүхийн ерөнхий зөвлөл.

Д.Цогтбаатар: Тодруулъя. П.Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Баярлалаа. Хариулт авлаа.

Тэгэхдээ Ц.Сандаг-Очир гишүүний уншиж байгаа заалтыг харвал “зохих нэмэлт, өөрчлөлтийг” л гэж байгаа юм. Хүрээ хязгаарыг нь тавиад өгчихсөн байхгүй юу. “Хөндөгдсөн хэмжээнд” гэсэн үг.

Түүнээс биш энд нэг зөрчил байгаа юм. Засчихъя гээд сайн санааны үүднээс ч юм шиг. Тэгэхдээ эргээд зорилго нь зөв байж болно. Тэгэхдээ арга нь

буруу буюу бие даасан судалгаатай, хэлэлцүүлэгтэй, хууль тогтоомжийн хуулийн дагуу олон нийтээс санал авч байж зарим зүйлийг хөндөх ёстой. Би тантай санал нэг байна. Нэг мөсөн жигдлээд явах. Яг аль хуулиараа нэг талдаа гарч зохицуулах энэ асуудлаа бодлогын хүрээнд шийдэх ёстой.

Тэгэхдээ өнөөдрийн яг энэ яригдаж байгаа зүйл бол зарчмын хувьд энэ шүү. Зохих нэмэлт, өөрчлөлт буюу Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд дурдагдсан Үндсэн хууль зөрчсөн тэр хэмжээнд, Улсын Их Хурал хүлээж авсан тэр хэмжээнд асуудлын ярих ёстой.

Түүнээс биш энд нэг ийм жижиг юм байж болзошгүй юм байна гээд огтоосоо цэцийн дүгнэлтэд дурдагдаагүй юмыг тэр шийдвэрийг хүлээж авах байдал дээрээ хөндөж өөрчилж болохгүй. Энэ том зарчмын юм явчхаад байгаа байхгүй юу.

Дараа нь маш олон хуулиудыг ингэж явна шүү. Тэгээд сүүлдээ дийлдэхээ байна. Болно гэдэг. Энэ зөвхөн шүүгч нартай холбоотой биш. Маш олон бүх хуулиуд дээр ийм жишгүүд гарна. Бид хэд дуртай заалтаа дуртай агуулгаар нь өөрчлөх бололцоог бүрдүүлэх юм биш биз дээ гэдэг л ийм болгоомжлол байгаад байгаа учраас Байнгын хорооны гишүүддээ энэ зүйлийг нь анхаараач ээ л гэдэг зүйлийг хэлээд байгаа юм.

Д.Цогтбаатар: Х.Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: П.Сайнзориг гишүүн сая хэлчих шиг боллоо.

Цэцийн дүгнэлт маш тодорхой. 55 настай холбоотой хэсэг байсан. Тэгээд 65 гэхээр цэцийн дүгнэлтээс өргөтгөж байгаа юм. Бид цэцийн дүгнэлтийг хүлээж аваад түүнтэй холбогдуулж засвар хийх биш концепцынхоо хувьд энэ хууль дээр ямар шийдэл хийх вэ гэдэг дараагийн өөр хувилбар гаргаж ирж байна гэсэн үг.

Хуулийн текст дотор жоохон учир дутагдалтай юм байна. Тэр “холбогдох хуульд заасан” гээд. Тэтгэврийн ерөнхий хууль байгаа. Тэтгэврийн ерөнхий хуулиас тусдаа хуулиар зохицуулахын тулд прокурор, шүүхийн тухай хууль дээр бичиж байгаа.

Түүнээс биш холбогдох хууль гээд тэтгэврийнхээ хуулийг заах байсан бол энд энэ зүйл байх огт шаардлагагүй. Тэр хуулийнхаа 65 насыг татаж аваад л хэрэглэхинэ.

Тэгэхээр хууль зүйн техникийн хувьд стандарт бус буруу техник орж ирж байна энд.

Ер нь прокурор, шүүх дээр, төрийн албаны хуулиас тусдаа ийм жишиг юм уу, эсвэл тусдаа стандарт тэтгэврийн насан дээр тогтоох уу, үгүй юу гэдэг тусдаа үзэл баримтлал байх.

Тэр тусдаа үзэл баримтлалыг яг л хууль хэлэлцдэг журмаараа оруулж ирээд шийдсэн нь илүү зөв байх аа. Тэгэхгүй бол үнэнийг хэлэхэд Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг цэцийн дүгнэлтэд дурдсан эсэхээр Улсын Их Хурал хүлээж авчхаад цэцийн нэрийг бариад Хууль зүйн байнгын хороо арай өргөтгөсөн, дүгнэлтэд дурдаагүй шийдвэрийг гаргах нь би зохимжгүй гэж бодож байна.

Яагаад зохимжгүй гэж бодож байна вэ гэхээр анх энэ хуулийн концепцыг дэмжээд, батлаад, шийдсэн тэр Улсын Их Хурал, тэр мандатын бүрэн эрхийг бид цэцийн нэр барьж байгаад энд эвдэх гэж байгаа байхгүй юу. Тэрийг эвдье гэж бодож байгаа бол яг хууль өргөн барьдаг журмаар нь өргөн бариад, хэлэлцээд, тэгж явсан нь дараа дараагийн парламентын уламжлалд хэрэгтэй.

Тэгэхгүй огт хамаагүй цэцийн шийдвэрийг эш татаад дурын хууль руугаа ордог хууль тогтоох практик тогтоочихвол Монгол Улсын хувьд зөв биш практик болно шүү. Хууль тогтоох үйл явцад. Тэрийг би хэлэхийг хүссэн юм.

“Холбогдох хуульд” гэдэг энэ үгийг энэ зүйл, заалт дээр оруулж ирж болохгүй шүү. Төрийн албаны хууль дээр “хуульд өөрөөр заагаагүй бол” гэдэг үгтэй.

Хуульд яагаад өөрөөр заагаагүй вэ гэхээр тэр хуульд тусгай зохицуулалттай учраас. Шаардлагатай тусгай зохицуулалт.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Асуулт, үг хамт юм чинь та үг хэлбэл хэлчих хэлчих.

Д.Цогтбаатар: Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Сая Х.Тэмүүжин, П.Сайнзориг нарын гишүүд хэлчихлээ.

Бид Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд заагдсан Үндсэн хууль зөрчсөн тэр хүрээнд л Хууль зүйн байнгын хороо холбогдох өөрчлөлтийг хийнэ.

Үндсэн хууль зөрчөөгүй гээд гаргачихсан тэр заалтыг нь Хууль зүйн байнгын хороо хөндөх ийм хууль зүйн боломж байхгүй. Нөгөө “нисдэг бор морийг нь идээд ир гээд явуулсан чинь нисдэггүй бор морийг нь идчихсэн” нэг үлгэр байдаг шүү дээ. Тэгээд түүн шиг байж болохгүй.

Тийм учраас Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзсэн 47.6-гийн эхний өгүүлбэрийг Хууль зүйн байнгын хороо цэцийн шийдвэрийг даваад шууд хөндөх би хууль зүйн боломж байхгүй байна гэж нэгдүгээрт харж байгаа.

Хоёрдугаарт, энэ бол зарчмын өөрчлөлт хөндөх гэж байна.

Сая гишүүд хэлж байна. Шүүхийн хуулийг гаргахдаа бид бусад хуулиудаас, төрийн албан хаагчдаас онцлог нийгмийн баталгаа, эдийн засгийн баталгаа, хязгаарлалтуудыг нь бүгд онцлог байгаа. Өөр өөр.

Тэр байтугай би шүүхийн хууль батлагдаж байх үед хэлж байсан. Монголд хайр сэтгэлийг хуульчилсан ганцхан хууль байгаа. Энэ шүүхийн хууль. Шүүгч хүнийг хэргийн оролцогчидтой одоо бараг эр эмийн харилцаанд орж болохгүй шүү гэдэг хязгаарлалт ганцхан шүүхийн хуульд байгаа. Монгол Улсад. Тэр утгаар нь би үүнийг хэлж байсан юм. Ганцхан шүүхийн хууль дээр л энэ хайрыг хуульчилсан шүү. Шүүгчдийн асуудал дээр ийм хязгаарлалт тавьсан. Өөрөөр хэлбэл ийм онцлог учраас зөвхөн энэ хуулиар зохицуулсан тийм онцлог харилцаануудтай юм.

Тийм учраас би энэ “холбогдох хуульд заасан” гэдэг тэр нөхцөл байж болохгүй гэж үзэж байгаа.

2020 оны 3 сард Хууль зүйн байнгын хороо Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль дээр гарсан цэцийн дүгнэлтийг далимдуулж шүүхээс хэргийг буцаадаг өөрчлөлтийг хийж байсан юм. Энэ бол хуулийн хулгай байсан юм. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн цэцийн хөндөөгүй заалтыг далимдуулж хийж байсан практик байгаа. Байгаа шүү. Өмнө нь ийм тохиолдол гарч байсан юм.

Үүнийг миний бие тухайн үед хэлж байсан. Энэ хуулийн хулгай явчихлаа. Хууль зүйн байнгын хороо цэцийн гаргаагүй зүйл, заалтыг хөндөөд, далимдуулаад өөрчлөөд явчихсан.

Тийм учраас ийм жишгийг Хууль зүйн байнгын хороо цаашдаа гаргахгүй байх дээр анхаарах ёстой гэж үзэж байна.

Д.Цогтбаатар: Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Энэ чинь бүр одоо хуулийн хулгай хийгээд явчихсан юм шиг юм ярих гэж байна.

Хөндөгдөж байгаа заалт чинь шүүхийн тухай хуулийн 47.6. 47.6 хоёр өгүүлбэрээс бүрдэж байгаа. Хоёр дахь өгүүлбэр нь зөрчсөн байна гэж дүгнэлт гаргасан.

Тэгэхээр 47.6 өөрөө хөндөгдөж байгаа заалт. Тэгээд хөндөгдөж байгаа заалт дээр нь нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа. Түүнээс огт хамааралгүй

заалтыг хөндөж оруулж ирээд өөрчлөх гэж байгаа асуудал огт биш гэдгийг Та бүхэн хараарай.

Түрүүн П.Сайнзориг гишүүн асууж байсан. Зохих нэмэлт, өөрчлөлтийг гэж байна. Тухайн болон холбогдох бусад хууль гэж байна шүү. Тухайн хуульд нь. Нөгөө талаар ахиад холбогдох хуульд нь зохих нэмэлт, өөрчлөлтийг оруулна гэж байна шүү дээ. Дэгийн тухай хуулиараа. Тэгээд хуульчлаад өгчихсөн байна. Дэгийн тухай хууль.

Тэгэхээр бид 47.6 дотроо л ярьж байгаа. 47.6-гийнхаа нэг дэх өгүүлбэрийн Төрийн албаны хуультай зөрчилдөж байгаа насны дээд хязгаарыг нь нэгмөсөн энэ нэмэлт, өөрчлөлтөөр нь засаад явуулчихъя гэдэг ийм л асуудлыг ярьсан.

Тэгэхээр 47.6 чинь өөрөө хөндөгдөж байгаа гэвэл хөндөгдөж байгаа.

Тийм учраас хагас дутуу зүгээр цэцийн дүгнэлтийг хүлээж аваад тэр хоёр дахь өгүүлбэрийг нь хасаад оруулаад ирэхээр цаана нь бас дутуу хуулийн зөрчил үүсэхээр байсан юм.

Тийм учраас хүлээн авсантай холбогдуулаад дүгнэлтийг 47.6 дээрээ зөрчилтэй байгаа насны дээд хязгаарт нь оруулаад нэгмөсөн 65 гээд хуульчлаад өгчихье гэдэг ийм л асуудлыг бид өнөөдөр оруулж ирсэн юм.

Түүнээс огт холбоо хамааралгүй хуулийн заалтууд дээр өөрчлөлт оруулж байгаа асуудал байхгүй шүү гэдгээ хэлье.

Д.Цогтбаатар: Гишүүд ээ, энэ дээр нэг юмыг хэдүүлээ бодох ёстой.

Энэ заалтыг бүхэлд нь дурдахаас гадна Үндсэн хуулийн цэцийн үндэслэл хэсэг дээр ч, нөгөө талаасаа бид хэлэлцэж байхдаа ч гэсэн нэг зүйлийг ярьж байсан.

Төрийн албаны хуульд заагаад өгчихсөн байгаа энэ ерөнхий заалтыг энд ялгаварлаад өөрчилчихсөн байна гэдэг. Ингэж байж бид хүлээж авсан.

Улсын Их Хурал хуулиа өөрчлөх бүрэн эрх бол Үндсэн хуулийн цэцэд биш Улсын Их Хуралд бид нарт өөрт байгаа байхгүй юу. Тэгээд энэ 47.6 чинь өөрөө бүх л агуулгаараа. Түүнээс биш үг, үсгээрээ биш тэр бүх л агуулгаараа энд хөндөгдөөд, энэ чинь тэр Төрийн албаны ерөнхий хуулийн заалттайгаа зөрчилдөөд байна гээд Үндсэн хуулийн цэц бид нарт аягүй ойлгомжтой заачихсан байгаад байгаа.

Тэгэхээр ажлын хэсэг энэ дээрээ сууж байгаад энэ бүх өнцгөөс нь харж байгаад би оруулж ирсэн байна гэж харж байгаа. Тэгэхдээ тэр үндэслэл хэсэг

дээр нь бид энд ярихдаа энэ чинь, бид энд зөндөө яриа биз дээ. Гэхдээ тэнд контекст нь ер нь бусад хуулиудтайгаа хүний эрхийн асуудалтайгаа зөрчилдөөд байна, ялгаварлан гадуурхсан нөхцөл байдал үүсээд байна л гэж байгаа шүү дээ. Тийм тийм.

Бид нарын хувьд одоо энд жишээлбэл “зохих” гээд ярихад ч гэсэн “зохих” гэдэг нь яг үүнтэйгээ холбогдсон зохих саналыг оруулж ирж байна шүү дээ. Энэ хүмүүс үзээд.

Бид тэгэхээр “зохих” гэдэг нь зөвхөн түүндээ холбогдож байна уу, үгүй юу. Энд Шүүхийн ерөнхий зөвлөлийнхөн нь өөрсдөө сууж байгаад үүнтэйгээ энэ Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг үндэслээд үүнийгээ оруулж ирье гээд саналаа оруулж ирж байна шүү дээ.

47.6 бүхэлдээ. Ц.Сандаг-Очир гишүүний хэлж байгаа үнэн шүү дээ. Бүхэлдээ хөндөгдсөн шүү дээ.

Би Л.Соронзонболд гишүүний микрофоныг өгье.

Л.Соронзонболд: Энэ дээр нэг ийм асуудал байгаа юм.

Шүүгч гэж хүн Монгол Улсын бусад иргэдтэй л адилхан тэтгэвэрт гарах боломжтой байх ёстой.

Тэгэхээр өнөөдрийн Төрийн албаны тухай хуулиараа 65 хүртэл хүн ажиллах боломжтой байгаа. 50-тай гарч болно, 50 тавтай гарч болно, 60-тай гарах боломжтой. Тэгээд энэ боломжуудыг нь олгох ёстой гэдгээр нь манай ажлын хэсэг ийм санал гаргасан.

Тэгэхээр үүнийг Үндсэн хуулийн цэцээс ирсэн нь ингээд хуулийн тодорхой хэмжээний асуудал үүсгээд байна гээд яриад байгаа гишүүд нөгөө талаас нь бодож үзвэл бас бид нарын тавьж байгаа санал үндэслэлтэй л гэж бодож байна.

Д.Цогтбаатар: Би энэ дээр ингэж бодож байна.

Одоо 55 дээр ийм зөрчил гарсан. 60, 65 дээр чинь ахиад гараад л ирнэ шүү дээ. Аягүй ойлгомжтой байгаа байхгүй юу.

Х.Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: Цэцийн 2025 оны 02 сарын 14-ний 02 тоот дүгнэлт. Энэ дээр аягүй тод биччихсэн байгаа юм.

55 насанд хүрснээр тэтгэвэр тогтоолгох буюу шууд тэтгэвэрт гарах үр дагаврыг үүсгэсэн нь Үндсэн хууль зөрчсөн гээд биччихсэн байгаа байхгүй юу. 55 нас гэдгийг нь.

60-ыг нь ерөөсөө хөндөөгүй.

Ажлын хэсэг санаачилга гаргаад хэрвээ үүнийг өргөтгөөд ажиллая гэвэл болох вэ гэхээр яг үүнтэй адилхан зохицуулалт нь прокурорын тухай хууль дээр байж байгаа. Дахиад яг ийм. Нөгөө прокурорын дээд нас хүрээгүй мөртлөө 55 насаар тэтгэвэрт гарах гээд.

Тэгэхээр цэцийн шийдвэрийг дагуу ижил зохицуулалтуудыг засах бол ажлын хэсэг дээр эрх нь байгаа.

Харин энэ хууль дээр байгаа цэцийн шийдвэр хөндөөгүй байгаа 60 насыг хөндөх гэж байгаа бол цэцийн шийдвэрийн нэр ашиглаж хөндөж ерөөсөө болохгүй. Яагаад гэвэл цэц өөрөө тийм шийдвэр гаргаагүй учраас. Бид цэцийн шийдвэрийг зохиох гээд байна шүү дээ.

Үнэхээр бодлогын хувьд энэ өөрөө шударга биш байна. Төрийн албаны хуулийнхаа 65-аар шүүх байна уу, прокурор байна уу бүгдээрээ адилхан байх ёстой, тусгайлсан зохицуулалт шаардлагагүй гэж үзэж байгаа бол яг хууль өргөн барьдаг журмынх нь дагуу өргөн бариад шийдэх ёстой. Би ч гэсэн магадгүй гэж бодож байна.

Гэхдээ процессын хувьд цэцийн нэр ашиглаж энэ дээр хууль өөрчилж болохгүй. Цэц өөрөө яг тийм дүгнэлт гаргаагүй байна.

Бүр ингэж бичсэн байгаа шүү. Шүүгчийг тэтгэвэрт гарах насны дээд хязгаар хүртэл нь хугацаагүй томилох зарчмыг алдагдуулсан байна. Шүүгчийн тэтгэвэрт гарах насны дээд хязгаар хүртэл гэж цэц 60 насыг ойлгосон байгаа байхгүй юу. Энэ дүгнэлт дээр.

Тэр хүртэл ажиллах эрхийг нь хязгаарласан байна гэж дүгнэсэн байгаа байхгүй юу. Түүнээс Төрийн албаны хуулийн 65-ыг ерөөсөө яриагүй энд.

Д.Цогтбаатар: Тийм. Одоо энэ дээр чинь би юу хараад байна гэхээр энэ эргээд л өөрөө яг ялгаварлан гадуурхсан, бусад хуультайгаа зөрчилдсөн болоод л орж ирнэ.

Бид тэгэхээр энэ хуулийн нөхцөлийг нь сайжруулаад батлах боломж бол байж байна шүү дээ.

Тэгэхээр юу ч гэсэн ингэе. Ажлын хэсгийн би оруулж ирсэн саналаар хэдүүлээ санал хураалт явуулъя.

Би аль хэдийн тийм чиглэл өгчхөөд байгаа шүү дээ. Гол проблем нь энэ чинь нөгөө хугацаатай, бид хугацаандаа багтаж үүнийг нь хийхгүй бол. Түүнээс бусад ердийн хууль шигээ оруулж ирэхээр ямар ч асуудалгүй. Бусад тэр байгууллагууд, агентлагууд нь тэгж оруулж ирнэ л биз.

Энд бид цагт шахагдчихаад байгаад л асуудал байгаад байна шүү дээ. Энэ чинь хугацаа нь хэд билээ.

Тэгвэл ингэе. Саяын энэ ярьж байгаа асуудлуудтай холбогдуулаад нэгэнт ирц бүрдчихсэн байгаа учраас сая ажлын хэсэг дотроо энэ томьёоллоо эргэж гишүүдийн ярьсныг тусгаж харъя гээд шийдэж байна.

Тэгээд ажлын хэсэг өөрийнхөө тэгвэл шинэчилсэн томьёоллын уншаад микрофонд танилцуулчих.

Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Манай ажлын хэсэг хуралдаад сая Байнгын хорооны хуралдаан дээр гишүүдээс гарсан саналуудыг нэгтгэж үзээд.

Яах вэ, өчигдөр бид ажлын хэсэг дээр яриад хоёр хувилбар ярьсан юм. Тэгээд нэгэнт өөрчлөлт оруулж байгаа бол Төрийн албаны хуулийн зөрчилтэй байгаа заалтуудаа нэгмөсөн хөндөөд, засаад, нийцүүлээд явчихъя гээд хоёр дахь хувилбарыг авсан.

Тэгтэл сая Байнгын хорооны гишүүдийн гарсан бол санал хөндөөгүй заалтыг хөндсөн байна гэдэг асуудлуудыг ярьж байх шиг байна. Ингэлээ гээд зарим нэг зөрчлийн асуудлууд шийдэгдэхгүй үлдэж байгаа гэдгийг Та бүхэн анзаарна биз.

Ингээд манай ажлын хэсэг Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 1 дүгээр зүйл, Монгол Улсын шүүхийн тухай хууль шинэчилсэн найруулгын 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн хаалтанд шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно гэснийг хассугай гэсэн нэг зүйлтэй ийм нэмэлт, өөрчлөлт.

Д.Цогтбаатар: Тэгвэл ажлын хэсгийн сая уншиж танилцуулсан саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

84.6 хувиар санал дэмжигдлээ.

Энэ асуудалтай холбогдуулаад би хэдэн зүйл хэлнэ.

Ц.Сандаг-Очир гишүүний сая хэлж байсан юмнуудыг анхаарч үзэх ёстой.

Тэгэхээр ажлын хэсэгт байгаа Шүүхийн ерөнхий зөвлөлийнхөн ч гэсэн анхаараад надтай эргэлт зөвлөлдөж болно. Яг холбогдох Төрийн албаны хуультайгаа нийцүүлээд энэ хуулийнхаа төслийг шинэчлээд яаралтай оруулж ирэх хэрэгтэй.

Үүнтэй холбогдуулан би бас Хууль зүйн байнгын хорооныхоо ажлын албанд үүрэг өгч байна.

Холбогдох бусад байгууллагуудад энэ хуулиа яаралтай жигдэлж оруулж ирэх саналыг холбогдох байгууллагууд руу явуулах ёстой.

Тэгээд төрийн албаны хуультайгаа бусад салбарын хууль нь өөрөө нийцэж байх ёстой. Тэгэхгүй бол ахиад Үндсэн хуулийн цэц дээр маргаан үүсээд, энэ яг тэр агуулгаараа ахиад зөрчигдлөө гэж орж ирнэ. Тэр нь ойлгомжтой. Хэнд ч эрүүл ухаанаар бодоход ойлгомжтой байна.

Тэгэхээр энэ ажлуудаа холбогдох газрууд яаралтай хийгээрэй гэж би хэлээд энэ асуудлыг хаая.

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84.3-д заасны дагуу боловсруулсан Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулна.

Дараагийн асуудалдаа оръё.

Гуравдугаар асуудал.

Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай асуудлыг хэлэлцэнэ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингээс 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Улсын Их Хурлын даргад өргөн барьсан санал байгаа.

Түрүүний хоёрдугаар асуудалтай холбогдуулаад нэг санал хураалт орхигдсон байна. Бид яг хэлэлцүүлгийн дундаасаа явж байгаа учраас энд бид нарын юунд нэлээн хэдэн өөрчлөлт орсон.

Тэгээд нэг юм орхигдсон байна шүү. Хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

76.9 хувиар санал дэмжигдлээ.

П.Сайнзориг гишүүнийг дэмжсэнд бүртгэж аваарай.

Ингээд гуравдугаар асуудал руугаа үргэлжлүүлээд ороод явъя.

Гурав.Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай
/Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн саналыг хэлэлцэх,
үргэлжлэл/

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингээс Улсын Их Хурлын даргад 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг ирүүлснийг Хууль зүйн байнгын хороо 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцэж эхэлсэн бөгөөд Байнгын хорооны гишүүдийн саналаар хойшлуулсан байгаа.

Уг асуудлыг одоо хэлэлцье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан санал гаргасан гишүүнээс асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Х.Тэмүүжин гишүүний гаргасан санал байгаа. Б.Энхбаяр гишүүнээр, П.Сайнзориг гишүүнээр тасаллаа. Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Үг, асуулт хамт байгаа шүү. Энэ дээр.

Б.Энхбаяр: Би өмнөх хуралдаан дээр бас хэлж байсан юм.

Энэ бол Үндсэн хуулийн цэцэд Улсын Их Хурал Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар хүсэлт гаргах гэж байгаа анхны тохиолдол. Шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойших 33 жилийн түүхэнд шүү. Анхны тохиолдол.

Тэр утгаараа бидний энэ асуудлыг өргөн барьж байгаа, хэлэлцэж байгаа агуулга анхны кэйс болох гээд байна.

Тийм учраас би нухацтай хандаад байгаа юм. Энэ яг Х.Тэмүүжин гишүүний өргөн барьсан эрх зүйн үндэслэлээрээ шууд тэр чигээрээ Их Хурал руу ороод явчих юм уу? Энэ дотроос нь гурван үндэслэл бичсэн байна л даа.

Энэ гурван үндэслэлийн би нэгтэй нь санал нийлээд хоёртой нь санал нийлэхгүй яах юм? Яаж хэлэлцэх юм? Бид нар ер нь.

Би энэ асуудал дээр санал гаргах боломжтой юм уу, боломжгүй юм уу? Хажуугийн санал. Бүхэлд нь. Одоо жишээлбэл энэ дотор үндэслэлийг нь илүү өргөтгөө гэвэл яах юм.

Тийм учраас би энэ дээр ажлын хэсэг гаргаж хэлэлцье гээд байсан нь учиртай. Хэрэв ажлын хэсэг гаргах дээр тулбал би ахалья гээд шууд хэлсэн нь бас ийм учиртай.

Жишээлбэл, П.Сайнзориг гишүүн үүнийг хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр шийдэх бололцоотой гэж хэлж байсан. Яг ийм төрлийн агуулгатай харилцаа жишээлбэл өмнө нь байгаа. Тэр л шийдвэрт яаж нөлөөлөх вэ? Энэ санал, хүсэлт. Тухайлбал Эрдэнэт үйлдвэрийн 49 хувийг төрд авахтай холбоотой Улсын Их Хурлаас гаргасан тогтоол Үндсэн хуулийн цэц дээр хянагдсан. Түүнд Үндсэн хуулийн 3 эцсийн шийдвэр гарчхаад байгаа.

Нэгдүгээрт, Үндсэн хуулийн цэц тэр шийдвэрийг Үндсэн хууль зөрчөөгүй гэж шийдвэрлэсэн. Энэ бол эцсийн шийдвэр.

Өөрөөр хэлбэл цэцийн шийдвэр нь ч эцсийн шийдвэр, Улсын Их Хурлын шийдвэр нь ч эцсийн шийдвэр. Гэтэл Монгол Улсын Дээд шүүх мөн дахиад түүнтэй зөрөлдөхүйц эцсийн шийдвэр гаргачхаад байгаа.

Өөрөөр хэлбэл үүнтэй ойролцоо маргаан. Шүүхээр явчихсан маргаан шүү. Улсын Их Хурлын шийдвэртэй, цэцээр орчихсон. Тэгсэн мөртлөө Улсын дээд шүүхийн бас эцсийн шийдвэртэй холбоотой.

Энэ маргаанд энэ жишээлбэл яаж нөлөөлөх вэ гэдгийг үзмээр байна.

Яагаад гэхээр Улсын Их Хурал хүсэлт гаргах гээд байна шүү дээ. Кэйс гаргаж. Үүнтэй ойролцоо төрлийн.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээгээд Б.Энхбаяр гишүүн ярьчих.

Яагаад гэвэл наадах чинь бид ул суурьтай ярих ёстой. Үнэн үнэн.

Б.Энхбаяр: Үүнтэй ойролцоо төрлийн кэйс маргаанууд байна уу, үгүй юу гэдгийг үзмээр байна.

Ойролцоо төрлийн. Жишээлбэл, тодорхой хуулийн зүйл, заалтаар хандаж байна шүү дээ. Улсын Их Хурал. Энэ өөрөө нэг ийм товчлол яваад байгаа байхгүй юу. Улсын Их Хурал цэцэд хүсэлт гаргасан тохиолдолд цэц маргаан

үүсэх үү, үгүй юу гэдгийг хэлэлцдэггүй. Шууд их суудлаар хэлэлцэнэ. Тэгээд шууд эцсийн шийдвэр гарна.

Тэгэхээр үүнтэй холбоотой цаашдынх нь улс төр, эрх зүйн үр дагаврыг нь бас мэдмээр байна. Өөрөөр хэлбэл энэ тодорхой хуулийн зүйл, заалтаар Үндсэн хуулийн цэцээр эцсийн шийдвэр гаргуулах гэж байгаа бол цаашид бусад өөр явж байгаа хэрэг маргаан, учрал тохиолдолд.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Х.Тэмүүжин гишүүн хариулах уу?

Х.Тэмүүжин: Нэг их ухаантай царайлаад ийм бичиг бичээд байгаа юм ерөөсөө би биш. Нэг арга зам л байна гэдэг нь үүнийг хэлж байгаа юм.

Үндсэн хуулийн цэцэд Улсын Их Хурал хүсэлт гаргаад, тэр хүсэлттэй холбогдуулаад Үндсэн хуулийн цэц шийдвэр гарвал өмнө нь гаргасан байгаа магадлалаа эргэн харах боломж нь байгаа юм. Ганцхан боломж. Энд бид хуулиа засчхаж болно. Яг тэр хэсгийг. Энд хууль өөрчлөгдсөн гээд Үндсэн хуулийн цэц магадлалаа эргэн харах ямар ч эрхгүй. Авч үзэх шаардлага байхгүй. Магадлал нь түүгээрээ хэвээрээ үлдэнэ.

Магадлалынх нь дагуу явж байгаа нөгөө шүүх дээр байгаа маргаан цаашаа хуулийнхаа дагуу маргаан болоод л үргэлжилнэ.

Эрх мэдэл хуваарилалт, парламентат ёс, Үндсэн хуулийн байгуулал гэх мэтчилэн энэ зүйл л жоохон эвдэгдэх байх. Буруу практик нь.

Ийш тийшээгээ татаад сунгаад л, түүнтэй ингэж байна, улс төрийн нөхцөл байдал нь ямар байна гээд. Үзэж болно шүү дээ. Тэр чинь нээлттэй шүү дээ.

Хөндлөнгөөс санал оруулж болох уу, үгүй юу. Тэр чинь нээлттэй шүү дээ. Яагаад гэвэл энэ чинь Улсын Их Хурлын шийдвэр болж цэц рүү явах гэж байгаа болохоос биш нэг хүний санаачилга ерөөсөө биш байхгүй юу.

Ажлын хэсэг байгуулна уу, хөндлөнгөөс саналаа оруулна уу. Тэр бүхэн өөрөө процессынхоо хувьд нээлттэй.

Зүгээр юу нь жоохон болгоомж төрүүлээд байна вэ гэхээр анх удаагаа Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцэд санал явуулах гээд байгаа юм. Хүсэлдээ.

Өмнө нь явж байсан практик байхгүй учраас эхний кэйс өөрөө ямар байх вэ гэдэг л, одоо түүн дээр жоохон болгоомж гэдэг юм уу, эсвэл жоохон хардалт явж байж магадгүй. Тийм.

Юм болгон дээр ингээд л нэг тийм цэцэрхээд л, ухаан зараад л байж болно. Гэхдээ бидний нэг парламентын гишүүн, Улсын Их Хурлын гишүүнийхээ хувьд бас нэг сэтгэлтэй хамгаалах ёстой нэг юм чинь энэ парламентат ёс шүү, Үндсэн хуулийн байгуулал шүү.

Эрх мэдэл хуваарилалтын хамгийн чухал зарчим нь парламентын засаглал бүхий Үндсэн хуулийн энэ амин сүнс болсон Улсын Их Хурлын гишүүд Үндсэн хуульд тангараг өргөж байгаа шүү дээ. Үндсэн хуульд үнэнч байна гээд. Тэр зам чинь шүү л гэдгийг хэлж байгаа юм.

Бүх юмыг улс төржүүлж болно, бүх юмыг хардаж болно. Тийм. Гэхдээ ердийн шүүхэд дуудагддаг парламенттай байх юм бол энд парламентын засаглал байх ямар ч шаардлагагүй шүү дээ. Төрийн эрх барих дээд байгууллага, хууль тогтоогч, Монгол Улсын гадаад, дотоод бүх асуудлыг авч хэлэлцэгч Үндсэн хуулиар тодорхойлсон энэ бүх эрх мэдэл чинь зүгээр л байхгүй болчихож байгаа шүү дээ.

Тэгээд байхгүй болж байгаа тогтолцооныхоо гажиг, энэ эвдрэлийг засах уу, үгүй юу л гэдэг л юм байгаа юм.

Д.Цогтбаатар: П.Сайнзориг гишүүний микрофоныг өгье. П.Сайнзориг гишүүний микрофон.

П.Сайнзориг: Баярлалаа. Би яах вэ, Х.Тэмүүжин гишүүнд нэг зүйлийг санал болгох гээд л байгаа юм.

Үүнийгээ зүгээр хууль тогтоомжийн хуульд заасны дагуу Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуультай холбогдох заалтыг нь хасах, хүчингүй болгох хуулиа санаачлаад Захиргааны ерөнхий хуулийн үйлчлэх хүрээн дээр, магадгүй Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн бас хэргийн харьяалал, шүүхийн харьяалал дээр тодруулах зүйлүүд байвал холбогдох заалтыг нь тусгая.

Өөрөөр хэлэх юм бол Улсын Их Хурлын томилгооны шийдвэртэй холбоотойгоор ч шүүхэд үүнийг авч хэлэлцэхгүй гээд шийдвэр юмнуудаа тодорхой болгочихмоор байна. Үүгээр юм ч шийдэхгүй.

Энэ ойлгомжгүй байдал дахиад сунжраад процесс явна.

Хоёрдугаарт, энэ зүйл дээр хууль тогтоомжийн хуулиараа тэр санаачлаад явангуутаа дагаж мөрдөх журмын гэдэг юм уу, шилжилтийн үеийн зохицуулалт дээрээ одоо яг Х.Тэмүүжин гишүүний яриад гээд байгаа тэр нөхцөл байдлуудыг нь гаргалгааг нь ингэнэ шүү гээд шийддэг шүү дээ. Бид хэд шүүхийн хууль дээр хүртэл ярьдаг байхгүй юу. Ийм төрлийн маргаанууд анхан шатын шүүх дээр явж байвал энэ маргаануудыг давж заалдах шатын шүүхээс цаашдаа хэлэлцэж

эхлэх юм бол энэ маргаануудыг шилжүүлээрэй ч гэдэг юм уу, ийм зүйлүүд байдаг.

Тэгэхээр хууль тогтоомжийн зөрчлөөс үүсэж байгаа энэ үр дагавартай зүйлүүдийг яг л Захиргааны ерөнхий хуулийн үйлчлэх хүрэн дээр, 3 дугаар зүйл дээр өөрчлөлтийг нь оруулчихмаар байна.

Цэц маргаан хянан шийдвэрлэх хууль дээр өөрчлөлтийг нь оруулаад үүнийгээ шилжилтийн хувийн зохицуулалт энэ тэрийг хийгээд явчихвал энэ зүйл арилчих юм байна л гэсэн зүйлийг харж байгаа юм.

Б.Энхбаяр гишүүн сая дурдчихлаа. Миний асуух гээд байгаа юм болохоор энэ бичгийн бүхэлд нь санал нийлж болохгүй байгаад байгаа байхгүй юу. Одоо яг ингээд биччихээд байгаа юм. Нарийвчилсан зохицуулсан хууль, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг практикт хэрэглэнэ. Хууль хэрэглээний үндсэн зарчим мөн гээд аймаар том том дүгнэлтүүдтэй.

Хувийн эрх зүй дээр энэ зарчим үйлчилдэг боловч нийтийн эрх зүй дээр ерөөсөө сүүлд үү, үгүй гэдгээр үйлчилж болдоггүй. Энэ чинь өөрөө Эрүүгийн хуулийн зарчмыг ч гэсэн тодорхойлох гээд байна шүү дээ.

Тэгэхээр бид хэд зарим зүйл дээр сүүлд баталсан хууль эсэхээс нь үл хамаараад эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг хэрэглэдэг нийтийн эрх зүйн зарчим байдаг байхгүй юу. Үүнийгээ хүртэл үгүйсгээд Улсын Их Хурал өөрөө ийм том дүгнэлттэй ийм зүйл яваад жишиг тогтоох гээд байна. Энэ бас эрх зүйн үр дагавар үүсгэн. Би нэг их цэцэрхээгүй шүү. Одоо бас таны хариултыг хэлчихье. Одоо яг нэг юм болохоор ингэж хэлэх гэж байна.

Тэгэхээр ийм зүйлүүдтэй нь жишээ нь санал нийлж болохгүй байгаад байгаа юм л даа.

Тэгэхээр үүнийг гишүүдэд зөвөөр хүлээж аваад. Хэдүүлээ энэ хууль хоорондын заалтын үр дагаврын асуудлыг засдаг аргаар нь засаж болохгүй юм уу. Тэгээд ерөнхийдөө эрх зүйн байдлыг дээрдүүлдэг, нийтийн эрх зүйн энэ салбар эрх зүйн зарчмыг та жишээ нь энэ албан бичгээр үгүйсгэхэж байгаа байхгүй юу. Хамгийн сүүлд баталсан хуулиар нь явдаг зарчимтай юм энэ тэр гээд.

Тэгээд би яах вэ зүгээр CHALLENGE_[сорилт, эсэргүүцэл] хийх гээд байгаа юм биш. Зөв биз дээ. Ийм зүйлүүдээ хэдүүлээ ярилцаж байж бас ингээд яахгүй бол энэ бүхэлд нь яаж чадахгүй.

Одоо энэ албан бичгээс чинь хасъя гэж санал хураалгаж болохгүй.

Д.Цогтбаатар: Х.Тэмүүжин гишүүн хариулъя.

Х.Тэмүүжин: П.Сайнзориг гишүүний сүүлийн үг. Бас ингэж худлаа хэлж болохгүй шүү.

Эрүүгийн хуулийг буцаан хийлгэх зарчим зөвхөн Эрүүгийн хуульд үйлчилнэ.

Захиргааны буюу нийтийн болон Эрүүгийн хуулиас бусад хууль дээр сүүлд үйлчилсэн зарчим хуульд үйлчилнэ шүү дээ. Яах юм, тэгээд татварыг сүүлд хуулийг нь өөрчилчхөөд татварын байцаагчид өмнөх тэр хуулийнх нь тэр заалт нь бас одоо юу гэдэг юм үйлчилж байгаа гэж хэлэх юм уу. Үгүй шүү дээ. Хэрвээ өмнө нь шинэ зохицуулалт шинэ зохицуулалт гараад хуучин зохицуулалт нь сул үлдэж байгаа бол энэ хууль тогтоогчийн алдаа байхгүй юу. Хууль хэрэгжүүлэгчийн алдаа биш шүү дээ. Хууль хэрэгжүүлэгчид сонголт үлдээж болохгүй шүү дээ. Зөвхөн Эрүүгийн хууль дээр шүүгчид шүүхийн хэрэглээн дээр ял шийтгэлийн бодлого дээр хөнгөрүүлснийг нь эдэлнэ, хэрэглэнэ. Эрүүгийн хуулийн зарчим шүү. Нийтийн эрх зүйн гэж наадхыгаа томруулж болохгүй.

Алтернатив дабл стандарт үүсгэх хууль гаргачихсан байгаа бол тэр бол хууль тогтоогчийн алдаа. Нийтийн эрх зүй дээр хуульд нэг мөр л үйлчлэх ёстой тийм зарчим байгаа шүү.

Хуулийг засна, засна. Би ерөөсөө хуулийг засахгүй гэж ерөөсөө хэлэхгүй байгаа шүү дээ. Энэ шүүх дээр маргаан яваад шүүхийн процессын хуулиараа хугацаа тавиад тавьсан хугацаагаараа Улсын Их Хурал руу бичиг явуулаад шүүх хуралдаанаа хиймээр байна гээд цаг нь тулчихсан байгаа.

Энэ ард нь байгаа хуулийг боловсронгуй болгох чиглэлийн юмнуудаа бид хийх ёстой. Хууль тогтоомжийнхоо хуулийнхаа дагуу хугацаагаараа саналаа хуулийн байгууллагуудаасаа, эрх бүхий байгууллагуудаас саналыг нь аваад сошиал платформ дээрээ тавиад, хэлэлцүүлгээ өрнүүлээд, тэгээд хуулиа өргөн бариад гээд. Тэр процесс явна шүү дээ. Үүгээр бүх юмыг хаах гэж байгаа биш.

Зүгээр цэцийн шийдвэртэй зайлшгүй явна гээд тулгалт хийчихсэн байгаа тэр нөхцөл байдлаасаа бид яаж гарах вэ л гэдэг нэг хувилбар нь.

Д.Цогтбаатар: П.Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Яах вэ энэ хууль тогтоомжийг засъя гэдэг дээр санал нэгтэй байгаа юм байна.

Тэгэхдээ Х.Тэмүүжин сайд аа, бусдыг та худлаа ярьж байна гэж хэлж болохгүй. Таны энэ бичиг дээр байна шүү дээ ямар ч салбарын эрх зүйг ялгаагүй. Энэ байна шүү дээ, сүүлд баталсан хуулийг заавал дарж мөрдөнө

гэдэг зүйл байдаггүй юм аа. Энэ тухайн шинэ хуулийг батлахдаа өмнө нь үүсэж байсан харилцааг яах вэ гэдэг шилжилтийн үеийн зохицуулалт буюу дагаж мөрдөх журмын хуулиараа зохицуулна. Шинэ хуулиа баррих уу, хуучнаар барих уу, эсвэл тодорхой цаг хугацаанд SPECIAL зохицуулалт хийгээд явах уу гэдэг зүйлийг зарчмын хувьд ярьдаг болохоос биш одоо таны албан бичиг дээр байгаа шиг хамгийн сүүлд батлагдсан хуулийг дагаж мөрддөг юм гээд. Энэ бол хууль хэрэглээний үндсэн зарчим бөгөөд зөрчилтэй зохицуулалтын хийдлийг харин үндсэн үүссэн юм гээд. Ийм том том дүгнэлтүүдтэй орж ирчхээд байгаа нь та бас өөрөө худлаа яриад байгаа байхгүй юу.

Тэгэхээр хэдүүлээ хаана хаанаа л зарим зүйлүүдээ ингээд хүлээн зөвшөөрөөд явахын оронд шууд микрофон авангуутаа чи худлаа ярьж байна гээд байх юм. Эрүүгийн хууль дээр. Би Эрүүгийн хуулийг больчихъё гэлээ. Тэгэхдээ шинэ хууль дээр ч хүртэл энэ дагаж мөрдөх.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан гишүүд үг хэлж, асуулт асууж дууслаа.

Би нэг асуулт асуугаадахъя. Х.Тэмүүжин гишүүн ээ, энэ чинь ингэж байна шүү дээ. Гишүүд маань хуулиа зохицуулаад өөрчлөөд явах гарц байна гээд байгаа.

Таны хэлж байгааг би ойлгохдоо хууль тэртээ тэргүй ойлгомжтой. Өөрчлөх хэрэгтэй болчхож байна. Тэглээ гээд өнөөдөр үүсчихсэн эрх зүйн нөхцөл байдал чинь засагдахгүй. Улсын Их Хурал захиргааны шүүх дээр дуудагдаж очих гээд л байгаад л асуудал байгаа биз дээ.

Хууль бид даж амжаад өөрчилчихсэн байсан ч энэ чинь буцаж үйлчлэхгүй учраас өмнө байгаа кэйс чинь үргэлжлээд, ингээд Улсын Их Хурал захиргааны шүүх дээр баахан нотлох баримт, одоо шаардсан. Тэгж очих гээд байна гэж би ойлгож байгаа. Зөв үү? Цэцийн шийдвэр хүчин төгөлдөр байгаад байгаа. Аан..., за за.

Тэгэхээр энэ дээр цэцийн өөрөөр хэлбэл шийдвэр бид хууль гаргалаа гээд хууль цэцийн шийдвэр чинь өөрчлөгдөхгүй тэр хэвдээ үлдэх гээд байгаа нь бидний хувьд асуудал үүсгээд байна шүү дээ. Та тэрийг шийдэх гээд байна гэж би ойлгож байгаа. Зөв үү?

Х.Тэмүүжин гишүүний хариултыг авчихлаа. Өөрийнхөө асуултад. Хөөе. Би асуулт асууж болно шүү дээ. Би хариултаа авах эрхтэй шүү дээ. Та нар маань миний асуултад хариулуулахгүй. Хариулчихлаа. Би хариултаа аваад болчихлоо.

Нэг юм байна. Энэ дээр чинь Х.Тэмүүжин гишүүний хувьд анхны юм болох гэж байна гээд бид сандраад байж хэрэггүй гэж би бодож байна.

Энэ чинь дэгийн тухай хуулиараа 88.1 дээр Улсын Их Хурлын гишүүн ийм санал Их Хурлын даргад гаргаад, тэгээд зөвшөөрөх юм бол, дэмжлэг авах юм бол цэцэд хандах эрх угаасаа энэ чинь хуулийн дагуу байж байгаа байхгүй юу. Энэ хэзээ нэгэн цагт Х.Тэмүүжин гишүүн биш гэхэд өөр нэг Дорж гэдэг гишүүн хэзээ нэгэн цагт хэрэглэх нөхцөл гарах нь л байна. Гарч болзошгүй гэж үзээд хууль тогтоогч эхнээсээ энэ цонх, үүд хаалгыг нээж өгсөн л байна шүү дээ.

Тэгэхээр үүнийг Х.Тэмүүжин гишүүний хувьд ашиглаад явах эрхээ өөрөө эдлээд Их Хурлын даргаас зөвшөөрөл, дэмжлэгээ аваад энэ 88.1-ийн дагуу оруулж ирсэн байгаа учраас энэ дээр ямар нэгэн юу гэдэг юм эрх зүйн зөрчил бол энд байхгүй. Энэ зарчмаар оролдоод үзэх ийм үүд хаалга чинь нээлттэй л байна шүү дээ.

Тэгэхээр энэ үүднээсээ Х.Тэмүүжин гишүүн оруулж ирж байна гэж бид ойлгож байна.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 88.1-д заасны дагуу санал хураалт явуулъя.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан аль ч шүүх хэргийг авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллын тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллын тогтоож, холбогдох шүүхэд шилжүүлнэ гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтыг зөрчсөн гэх үндэслэлтэй талаар Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг дэмжье гэсэн томъёоллоор.

Одоо энэ чинь нөгөө 14 хоног гээд энэ 81-ийн, таны өөрөө үндэслэл болгоод оруулж ирж байгаа заалтаар чинь 14 хоног гээд заачихсан байгаад байна л даа.

Тэгвэл ингээ. Энэ асуудлыг би санал хураахыг хойшлууллаа.

Маргааш сая энэ гишүүдийн ярьж байгаа санаа сэтгэл зовниж байгаа энэ асуудлууд дээр нь Х.Тэмүүжин гишүүн холбогдох гишүүдтэй яриад, энэ асуудлаа маргааш оруулж ирэхийг бод.

Би маргааш хурал хуралдуулах саналыг Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлд тавиад үүнийг шийдүүлэх чиглэлээр ажиллая.

Тэгээд энэ дээр өөрөөр хэлбэл саналынхаа үндэслэлүүдийг сайжруулах чиглэлийг өгөөд, энэ асуудлын санал хураахыг дараагийн хурал хүртэл хойшлууллаа. /алх цохив/

Х.Тэмүүжин гишүүн ээ, ингэх юм байна. Та горимын санал өөрөө гаргаад хойшлуулъя гээд. Бид ийм чиглэл өгчихлөө шүү дээ. Тэгээд санал хураагаад явъя.

Х.Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Хэлэлцэж байгаа асуудлын санал хураалтыг хойшлуулж өгөхийг хүсэж байна.

Д.Цогтбаатар: Х.Тэмүүжин гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулъя. Хойшлуулъя гэсэн томъёоллоор. Хойшлуулах саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

69.2 хувиар санал дэмжигдлээ.

Дөрөв.Цахим орчин дахь өсвөр үеийнхний үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт, сэтгэл санааны хүчирхийлэл, түүний хор уршгийн талаарх Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсролын сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонсох

Дөрөв дэх асуудалдаа оръё.

Цахим орчин дахь өсвөр үеийнхний үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт, сэтгэл санааны хүчирхийлэл, түүний хор уршгийн талаарх боловсролын сайдын мэдээллийг сонсьё.

Энэ мэдээллийг хамтарч Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цахим хөгжлийн сайд хамтарч боловсруулсан байгаа.

Ингээд цахим орчин дахь үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт, сэтгэл санааны хүчирхийлэл, түүний хор уршгийн талаар Боловсролын сайдын мэдээллийг сайд өөрөө танилцуулна.

П.Наранбаяр сайд. 8 дугаар микрофоныг өгье.

П.Наранбаяр: Хууль зүйн байнгын хорооны эрхэм дарга Д.Цогтбаатар гишүүн, эрхэм гишүүд ээ,

Нийгмийн сүлжээ сошиал медиа гэдэг. Энд хүүхдийн оролцоог зохицуулах тухай асуудлыг өнөөдөр Та бүхэнд танилцуулахаар ирлээ.

Тэгэхээр энэ асуудал өөрөө Та бүхэн мэдэж байгаа. Өнөөдөр нийгмийн сүлжээнд асуудлууд их байна. Улс орнууд үүнийгээ хууль эрх зүйн хүрээнд оруулж ирж томъёолдог. Үүнийгээ зохицуулдаг болсон. Манайд энэ нь одоогоор байхгүй байгаад байгаа учраас энэ асуудлыг зохицуулах шаардлагатай гэж үзэж байна.

Тэгэхээр зэрэг Хууль зүй, дотоод хэргийн яам, Цахим хөгжил, инновац харилцаа холбооны яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсролын яам гэсэн ийм 4 яам хамтарсан хуулийн үзэл баримтлалыг боловсруулах зорилготой ажлын хэсгийг байгуулж байгаа.

Түүний өмнө Боловсролын яам өөр дээрээ ажлын хэсэг байгуулаад. Та бүхэн мэдэж байгаа. 2024 оны эцсээр Австрали Улсад маш том хууль гаргасан. Үүнийг судлах, олон улсын нөхцөл байдлыг судлах зорилгоор бид үндсэн судалгааг хийж үзсэн.

Тэгээд үүнийхээ зарим нэгэн үр дүнг Та бүхэнд танилцуулна.

Мөн Хууль зүйн яамнаас өнөөдөр энэ цахим орчинд хүүхдийн эрх хэрхэн зөрчигдөж, хүүхэд ямар аюултай байдалд байгаа талаар Та бүхэнд мэдээлэл хүргэнэ.

Мэдээж энэ олон талтай. Мэдээж ололттой тал байгааг үгүйсгэхгүй. Гэхдээ ямар нэгэн байдлаар бид үүнийг зохицуулж эхлэх ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа юм

Тэгэхээр Боловсролын яамнаас яамдтай хамтраад ярьж байгаа энэ үзэл баримтлал дотроо бид нэгдүгээрт 16-аас доош насны хүүхдийг нийгмийн сүлжээ буюу сошиал медиагийн платформд бүртгэхийг хязгаарлах, зарим талаар нь хориглох, улмаар хүүхдийн эрүүл мэнд, оюун санаа, хүмүүжил, төлөвшилд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, гэмт хэрэг, зөрчил, халдлагад өртөхөөс сэргийлэх, цахим орчны эрсдэлт нөхцөлд оруулахаас урьдчилан сэргийлэх ийм зорилготой байгаа.

Энэ дээр нэгдүгээрт нь нийгмийн сүлжээний платформ. Түүний эрхлэгчийг бид тодорхойлно.

Нийгмийн сүлжээ эрхлэгчдийг хэрэглэгчийн насыг баталгаажуулах ийм технологийг ашиглаж эхэлнэ.

Өнөөдөр хүүхэд өөрийгөө хэдэн настай ч гэсэн хамаагүй хэлээд чөлөөтэй орж болж байгаа. Янз янзын ADMIN-аар яваад орчихдог. Тэгээд бидний хийсэн судалгаагаар харж байхад нэгээс дээш илүү хаягтай хүүхэд хэдэн хувьтай байлаа. Нэгээс дээш илүү хаягтай хүүхэд 60-аас дээш хувьтай байсан.

Тэгэхээр бид энэ хувийн мэдээлэл цуглуулах, хамгаалах болон тэдгээрийн хүлээлгэх үүрэг, хариуцлагатай холбоотой зохицуулалтыг тодорхой болгоод, хуулиар тогтоосон хуулийг зөрчсөн тохиолдолд сүлжээ эрхлэгчдэд ногдуулах хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар. Хууль зүйн шаардлагын тухайд Монгол Улсын Үндсэн хууль болон нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хангах, эрхийг зөрчихөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүргийнхээ дагуу Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 01 сарын 17-ны өдөр Хүүхэд хамгааллын тухай хуулийг шинэчлэн найруулж баталсан байгаа.

Энэ хуулийн 25 дугаар зүйлээр хэвлэл мэдээлэл өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгаалалттай холбоотой харилцааг зохицуулж байгаа боловч цахим орчинд хүүхдийн эрхийг хэрхэн хамгаалах, цахим гэмт хэргээс, тухайлбал цахим орчин дахь бэлгийн хүчирхийлэл, зүй бус зар сурталчилгаа, хуурамч мэдээ, мэдээллээс хүүхдийг хамгаалах, сөрөг агуулгатай контентын хандлагыг хязгаарлах, арилгах талаарх эрх зүйн харилцааг цогцоор нь тусгайлан зохицуулаагүй.

Мөн түүнчлэн тодорхой насны хязгаарлалттайгаар нийгмийн сүлжээний платформуудыг ашиглах талаараа хуульд зохицуулалт тусгагдаагүй байна.

Тийм учраас цахим орчинд хүүхдийн аюулгүй байдлын талаар үндэсний суурь судалгааг бид харж үзсэн.

Энэ дээр 7-гоос 12 настай хүүхдийн 50 хувь нь. Энэ 2020 онд хийгдсэн судалгаа. 13-аас 18 настнуудын 77 хувь нь Facebook хэрэглэдэг 87 хувь нь ямар нэгэн хэлбэрийн цахим халдлагад өртсөн байна гэж.

Цахим орчинд хүүхдийн эсрэг гэмт хэргийн шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам гэсэн 2021 оны судалгаагаар өсвөр үеийнхний 92 хувь нь интернэт хэрэглэдэг бөгөөд хүүхдэд учрах эрсдэлд хамгийн их нөлөөтэй хүчин зүйлээр интернэт орчныг тодорхойлсон.

Мөн судалгаанд оролцсон хүүхдүүдийн 14.6 хувь нь цахим орчинд хүчирхийлсэн, басамжилсан, садар самуун агуулгатай үйлдэл хийхийг шаардсан ийм өртөлтөд орж байсан гэсэн судалгааны дүн гарсан байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос хийсэн цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдал ба зохицуулалт судалгаанд дурдсанаар 13-аас 18 насны нийт судалгаанд оролцогчдын 71 хувь нь өдөр бүр цахим орчинд давтамжтай нэвтэрдэг. Үүний 96 хувь нь Facebook, 89 хувь нь Facebook messenger ашигладаг.

13-аас 18 насны хүүхдүүдийн гэртээ интернэтэд орохдоо аав, ээжийн эзгүйд орох хандлага нь хамгийн өндөр буюу 89 хувь байна гэсэн ийм тоон мэдээнүүд байна.

Судалгаагааргаар хүүхдүүдийн 87 хувь нь цахим орчны халдахад өртөж байсан. Тэдгээр хүүхдүүдийн 59 хувь нь эцэг, эхдээ хэлдэггүй.

Мөн хүүхдүүдийн 67 хувь нь нэгээс олон хаягтай. Илүү хаягаараа 61 хувь нь бусадтай чатлах, 36 хувь нь эцэг, эхийн хяналтгүй сошиал медиа буюу нийгмийн сүлжээг ашиглах зорилготой байдаг гэсэн судалгааны дүн гарсан байна.

Олон улсын туршлагын тухайд түрүүн би дурдсанчлан Австралийн Засгийн газраас өргөн бариад 2024 оны 11 дүгээр сард Цахим аюулгүй байдлын тухай хуульдаа нэмэлт, өөрчлөлтийг оруулж, 16-аас доош насны хүүхдийг нийгмийн сүлжээнд нэвтрэхийг бүрэн хориглосон хуулийн төсөл нь батлагдсан.

Энэ нь энэ оны 12 дугаар сараас хэрэгжиж эхэлнэ. Австрали Улсын хүүхдүүдийн 80 хувь нь **YouTube**, **TikTok**, **Instagram**, **Snapchat** зэрэг платформыг ашиглаж байсан.

Энэ дээр ямар нэгэн шүүлтүүргүйгээр мэдээ мэдээллийг авах гэмт хэргийн хохирогч болж байгаа гэсэн ийм байдалтай байна.

Мөн Франц Улс гэхэд 15-аас доош насны хэрэглэгч нийгмийн сүлжээнд нэвтрэхэд заавал эцэг, эхийн зөвшөөрлийг шаарддаг болгосон. Мөн Америкийн Нэгдсэн Улс, Япон, Итали, Солонгос, Швед, Оросын Холбооны Улс, Их Британи, Бүгд Найрамдах Хятад Ард Улс зэрэг орнуудад хүүхдийн эрхийг хамгаалах талаар бодлогоо тодорхойлж холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлэн ажиллаж байгаа ийм нөхцөл байдалд байна.

Тэгэхээр Та бүхэн мэдэж байгаа. Зөвхөн **SNS**_[social networking service] буюу нийгмийн сүлжээний асуудлын хажуугаар дэлгэцийн донтолт гэж нэг айхтар зүйл нүүрлэхээд байж байна. Энэ болгонтой бид нүүр тулж байна. Энэ бодитой үнэнийг хараад энэ дээр бид цаашдаа хуулийн үзэл баримтлалыг боловсруулаад ингээд явах шаардлагатай гэж харж байна.

Ингээд 4 яамны дунд үзэл баримтлалыг ярилцах ажлын хэсгийг байгуулна.

Та бүхэнд өнөөдөр танилцуулга хэлбэрээр өнөөгийн бодитой байдлыг хэлэх зорилгоор ирсэн. Тэгээд бид цаашдаа энэ хуулийг ердийн горимоор нь хэлэлцүүлээд ер нь нийгмийн оролцоо доороос дээш чиглэсэн хэлэлцүүлгүүдийг маш сайн хийж, нийгмийн ойлголцолд хүрнэ гэсэн бодолтой байгаа.

Ингээд танилцуулж дууслаа. Манай ажлын хэсэгт орсон мэргэжлийн улсууд энд ирчихсэн байгаа. Тэгээд та бүхний асууж тодруулах зүйлд хариулахад бэлэн байна.

Д.Цогтбаатар: П.Наранбаяр сайдад баярлалаа.

Одоо хоёр дахь танилцуулгыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар хийнэ. 4 дүгээр микрофон өгье.

Н.Мягмар: Байнгын хорооны дарга, гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Цахим орчин дахь өсвөр үеийнхний үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтын талаар дараах агуулгаар мэдээллийг танилцуулъя.

Нэгдүгээрт, энэ төрлийн гэмт хэрэгтэй холбоотой статистик мэдээлэл.

Хоёрт нь, цахим орчны нөхцөл байдал.

Гуравт нь, цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлсэн ажил. Мөн санал асуулга.

Тав, зургаад нь дүгнэлт санал гэсэн ийм агуулгаар танилцуулъя.

Цагдаагийн байгууллагын судалгаагаар сүүлийн 5 жилд буюу 2020-2025 оны эхний 3 сард нийт 146 мянга 476 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 10 мянга 164 буюу 6.9 хувийг хүүхэд хохирсон гэмт хэрэг эзэлж байна.

Үүнээс цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг 40 мянга 900 байгаагаас нийт 459 хүүхэд өртөж хохирсон. Жилийн дундаж өсөлт нь 62.2 хувьтай байна гэсэн судалгаа байна.

Мөн сүүлийн 5 жилийн энэхүү хугацаанд үе тэнгийн дээрэлхэлттэй холбоотой 350 гомдол, мэдээлэл бүртгэгдсэнээс 29 буюу 8.3 хувь нь цахим орчинд үйлдэгдсэн байна.

Дээрх гомдол мэдээллийн 311 буюу 88.9 хувь нь нийслэлд 39 буюу 11.1 хувь нь орон нутагт бүртгэгдсэн статистик мэдээлэл байна.

Нийслэлд бүртгэгдсэн үе тэнгийн дээрэлхэлттэй холбоотой гомдол, мэдээлэл олон гарсан буюу жишээ нь тухайлбал Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт 10, Баянзүрх дүүргийн 3 болон 16 дугаар хороодод 5-аас 10 буюу хамгийн их ингэж нийслэлийн нутаг дэвсгэрт бүртгэгдсэн байна.

Орон нутагт үе тэнгийн дээрэлхэлттэй холбоотой гомдол мэдээлэл Орхон аймаг, Орхон аймгийн Баян-Өндөр, Сэлэнгэ аймгийн Мандал суманд 4-өөс 8 буюу хамгийн ихээр бүртгэгдсэн мэдээлэл байна.

Цахим орчны нөхцөл байдлын талаар танилцуулахад манай улсын нийт хүн амын 1.2 сая нь өсвөр насныхан бөгөөд тэдний 74 хувь нь цахим хэрэглээнд идэвхтэй байдаг байна. Үүнээс цахим орчинд идэвхтэй байгаа хүүхдүүдийн 55 хувь нь эмэгтэй, 45 хувь нь эрэгтэй.

YouTube хуудас хэрэглэдэг 2.5 сая иргэн байдгаас 70 хувь нь өсвөр насныхан байна гэсэн судалгаа гарсан.

Мөн хуурамч хаяг байгаа нь энэ цахим дээрэлхэлтийн нэг хэрэгсэл болж тэдний сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж, гэмт хэрэгт өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Өсвөр үеийнхний үе тэнгийн дээрэлхэлт, сэтгэл санааны хүчирхийлэлтэй холбоотой мэдээлэл нийтлэгдсэн тухай бүр цагдаагийн байгууллагаас хариу арга хэмжээ авч, харьяа нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсээр шалгуулж устгуулах хүсэлтийг Харилцаа холбооны зохицуулах хороонд албан бичгээр хүргүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна.

Өнгөрсөн онд бага насны хүүхдэд учирч болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор **Facebook** олон нийтийн сүлжээнд садар самууныг сурталчилсан, хүүхдийг садар самуунд уруу татсан гэмт хэргийн шинжтэй үйлдэл гаргасан 196 цахим хуудас болон групп хаягийг тогтоон устгуулахаар Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлсэн байна.

Цагдаагийн байгууллагаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар дурдвал 2024 оны 04 дүгээр сарын 08-наас 26-ны өдрийн хооронд улсын хэмжээнд “Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй” мэдээлэл сурталчилгааны аяныг зохион байгуулсан.

Үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, иргэд олон нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, эцэг эхчүүдээс хүүхдэдээ тавих хараа хяналт,

анхаарал халамжийг сайжруулах чиглэлээр Боловсролын ерөнхий газар, багш сурган хүмүүжүүлэгч, мэргэжилтэн, судлаач болон цахим INFLUENCER буюу нөлөөлөгч нарын дэмжлэгтэйгээр иргэд олон нийтэд хүргэсэн байна.

Тухайлбал, ухуулга сурталчилгааны чиглэлээр нийтдээ 30 төрлийн 50 мянган ширхэг зурагт хуудас хэвлүүлж байршуулах, мэдээлэл авах зорилгоор 237 хайрцаг, 118 төрлийн **QR code**-ийг байршуулж, 8 видео шторк бэлтгэсэн.

Урлаг, спортын олны танил 120 орчим хүнийг аянд оролцуулсан байна.

Мөн үүрэн холбооны операторууд болох Мобиком, Скайтел, Юнител, Жи Мобайл үүрэн холбооны операторуудтай хамтран сэрэмжлүүлэг мессежийг 2 сая 636 мянга 600 хэрэглэгчид илгээсэн байна.

Мөн e-Mongolia, e-Barimt зэрэг цахим платформд 2.1 сая бичвэрийг байршуулсан арга хэмжээ авчээ.

Түүнчлэн FM радио олон нийтийн сүлжээний хэрэгслүүд болох “Их Монгол 99.7”, “Дэлхийн монголчууд 88.3”, 105.5, 107, 104.5 зэрэг 23 FM радиогоор сэрэмжлүүлэг мэдээг 7230 удаа эфирт цацсан бол 292 мэдээ мэдээлэл, контентыг 16.7 сая цахим орчинд хүн үзэж, 159 мянга 209 хүн үүнийг бусадтай share-лэх буюу like дарах ийм байдал судалгаа гарчээ.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах чиглэлээр тухайлбал, Монгол Үндэсний олон нийтийн радио, телевиз, MN25 дугаар суваг, TV5, TV9, Монгол-HD зэрэг 25 телевиз, 68 сайтад нийтдээ 44 мэдээ, сурвалжилга, 49 ярилцлага, 40 хэвлэлийн мэдээ, сурвалжилга бэлтгэн иргэд, олон нийтэд түгээсэн байна.

“Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй” арга хэмжээний хүрээнд насанд хүрээгүй хүнээс үйлдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 9.5 хувь буурсан эерэг үзүүлэлт гарсан судалгаатай байна.

Мөн энэ аяны үрээр цагдаагийн байгууллагаас санал асуулга зохион байгуулсан байна. Тухайлбал, энэ оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс 02 дугаар сарын 27-ны өдрийн хооронд сүүлийн жилүүдэд сурагчдын дунд ихээр үйлдэгдэх болсон үе тэнгийн дээрэлхлэлт, цахим орчны ялгаварлан гадуурхалтын бодит статистик мэдээлэл цуглуулах зорилгоор ерөнхий боловсролын 530 сургуулийн 99 мянга 118 сурагчаас санал асуулгыг авсан.

Судалгаанд оролцсон нийт сурагчдын 54 мянга 138 буюу 54.6 хувь нь нийслэлийн сурагчид, 44 мянга 979 буюу 45.4 хувь нь орон нутагт суралцдаг сурагчид хамрагдсан байна.

Эдгээрийн 57.3 хувь нь эмэгтэй, 42.7 хувь нь эрэгтэй сурагч нар судалгаанд хамрагджээ.

Судалгаанд оролцсон хүүхдүүдийн цахим орчинд хэрэглэж буй платформын 54 мянга 924 буюу

- 55.4 хувь нь **Facebook**,
- 31.2 хувь нь **Instagram**,
- 10.3 хувь нь **YouTube**,
- 7 хувь нь **TikTok**

ашигладаг гэж ийм хариулт өгсөн байна.

- Цахим орчны ялгаварлан гадуурхалтад өртөж байсан талаар санал асуулгаар тодруулахад 90.1 хувь нь “үгүй”, 9.9 хувь нь “өртөж байсан” гэж хариулсан. Үүнээс:

- 3461 сурагчид нь гүтгэсэн, доромжилсон агуулгатай мэдээлэлд өртсөн;
- 2345 нь худал мэдээлэлд өртөж байсан;
- 1118 нь зураг, бичлэг, мэдээлэл нь ашиглагдсан;
- 847 нь ангийн групп чатаас хасагдсан;
- 1417 нь групп чатдаа бичсэн сэтгэгдэлд хариу өгөхгүй байсан

гэдгээр ялгаварлан гадуурхалтад өртөж байсан гэдгээ илэрхийлсэн байна.

- Үе тэнгийн дээрэлхэлтэд та өртөж байсан уу? Хэрэв тийм ямар хэлбэрээр өртөгдөж байсан бэ? гэсэн асуултад судалгаанд оролцсон сурагчдын 84 хувь нь “үгүй”, 16 хувь нь “өртөж байсан” гэж хариулсан. Үүнээс:

- 3187 нь буюу 19.5 хувь нь “бие махбодын”,
- 11 мянга 701 буюу 71.6 хувь нь “аман байдлаар”,
- 1439 буюу 8.8 хувь нь “цахим орчинд үе тэнгийн дээрэлхэлтэд өртөж байсан” гэж хариулсан байна.

- Та болон таны үе тэнгийнхэн чинь хамгийн ихээр гэмт хэрэг зөрчилд өртөж хохирдог газар аль вэ гэсэн асуултад

- 51.9 хувь нь “сургуулийн орчинд”,
 - 6.8 хувь нь “орон сууцын орц, хонгил”,
 - 7.1 хувь нь “тоглоомын талбай”,
 - 3.4 хувь нь “авто зам”,
 - 7.5 хувь нь “олон нийтийн газар”,
-

► 1.6 хувь нь “автобусны буудал” дээр энэ төрлийн гэмт хэрэг зөрчилд өртдөг гэж саяын аяны хүрээнд зохион байгуулсан судалгаанд сурагч нар хариулсан байна.

Дүгнэлтийн хувьд сүүлийн 5 жилийн хугацаанд цахим орчинд үйлдэгдсэн 40 мянга 900 гэмт хэргийн улмаас нийт 459 хүүхэд өртөж хохирсон бөгөөд жилийн дундаж өсөлт нь 62.2 хувьтай байна.

Мөн цаг хугацаанд үе тэнгийн дээрэлхэлттэй холбоотой 350 гомдол, мэдээлэл бүртгэгдсэнээс 29 нь буюу 8.3 хувь нь цахим орчинд үйлдэгдсэн гэсэн ийм гомдол мэдээлэл ирүүлжээ.

Гэр бүл, нийгмийн орчин нь өсвөр насныхны сэтгэл зүй, зан үйлд нөлөөлж, үе тэнгийн дээрэлхэл, мөн цахим орчны хяналтгүй зүй бус хэрэглээ нь одоогийн нөхцөл байдалд хүргэж байна гэж дүгнэж байна.

Тийм учраас энэ үе тэнгийн дээрэлхэлтийг зөвхөн хүүхдийн асуудал гэж үзэхгүй. Нийгмийн бүтцийн сул талын илрэл.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Н.Мягмар даргад баярлалаа. Ярьж дуусчихсан уу? Дуусгая, дуусгая. Хамгийн сүүлд дүгнэлт саналаа хэлээд гялс дуусгачих.

Ер нь дараагийнх нь байна шүү дээ. Саяын энэ минутад. Бид 10 минут хангалттай өгч байна шүү. Тэрэндээ багтаж танилцуулгаа хийгээрэй. 4 дүгээр микрофон.

Н.Мягмар: Тэгэхээр дүгнэлтийн хувьд энэ хүүхдийн асуудал гэж үзэхгүйгээр нийгмийн бүтцийн сул тал илэрлээ гэж ойлгож, урт хугацааны төлөвлөгөөтэйгөөр хандах нь чухал байна гэдэг ерөнхий дүгнэлтийг хийж байгаа.

Тэгээд эндээс гадаад улс орны нэвтрүүлж байгаа зарим туршлагуудыг манай цагдаагийн байгууллагаас судалж, энэ төрлийн, ялангуяа боловсролын чиглэлийн байгууллагууд маань нэвтрүүлэх нь зүйтэй байна гэж үзэж байгаа юм.

Үүнд Финланд Улсын Боловсрол, соёлын яамны санхүүжилтээр хэрэгжүүлдэг “**KiVa**” [antibullying program] гэсэн хөтөлбөр байгаа.

Тнэ хөтөлбөр нь үндсэндээ 3 үндсэн элемент дээр суурилдаг ийм хөтөлбөр байгаа. Энэ хөтөлбөрийн талаар танилцуулга нь тараагдсан байгаа учраас ингээд товчилъя.

Хоёрт нь, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар, тэр дундаа Боловсролын яамны дэргэдэх Тусгай хэрэгцээт боловсролын төвөөс санхүүжүүлж үндэсний хэмжээнд хэрэгжүүлдэг санаачилга буюу **PBIS** [Positive Behavioral Interventions and Supports] буюу “Эерэг зан үйлийн хөндлөнгийн оролцоо ба дэмжлэг” гэсэн санаачилга байгаа. Энэ маань:

- ▶ зан үйлийн өөрчлөлт,
- ▶ сургалтын чанарт үзүүлсэн нөлөө,
- ▶ өргөн цар хүрээтэй нэвтрэлт

гэдэг энэ 3 агуулгаараа Америкийн Нэгдсэн Улс даяар дэмжигдэж сургалтын байгууллагад нэвтэрч байгаа ийм хөтөлбөр байна.

Гуравт нь, сэтгэл зүйн дэмжлэг, зөвлөгөө өгөх тогтолцооны асуудлаар Австралийн **KIDS HELPLINE** гэсэн шугам, мөн Америкийн Нэгдсэн Улсын **StopBullying.gov** гэсэн цахим платформоор сурагч нарт өсвөр насныханд энэ тулгарч байгаа асуудлаар нь зөвлөгөө, дэмжлэг үзүүлдэг ийм сайн туршлагууд энэ боловсролын салбарт нэвтэрсэн байгаа.

Тэгээд эдгээр сайн туршлагуудыг нь судалж нэвтрүүлэх ийм шаардлагатай гэсэн саналыг илэрхийлж байгаа юм. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Н.Мягмар даргад баярлалаа.

Гурав дахь илтгэгч Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Од.

Хэддүгээр микрофон дээр байна. 1 дүгээр микрофон.

П.Алтан-Од: Хууль зүйн байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ, энэ өдрийн амрыг эрье.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбарын хувьд цахим орчинд хүүхэд хамгаалал бодлогын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Нэгдүгээрт, Монгол Улсын хэмжээнд нийт 705 хүүхэд, 651 эцэг эхээс судалгаа авч цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаар үндэсний суурь судалгааны тайланг боловсруулж, хэвлүүлж түгээсэн.

Хоёрдугаарт, цахим орчинд хүүхэд хамгааллын ажлын хүрээнд дараах технологийн арга хэмжээг авч ажиллаж байна.

BLACKLIST буюу хар жагсаалтад Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчсөн контентыг нийтэлсэн тохиолдолд эрх бүхий байгууллагын шийдвэр, дүгнэлтээр цахим сайтыг хар жагсаалтад оруулж DNS /The Domain Name System/ системийн бүртгэлээр Монгол Улсын нутаг дэвсгэрээс хандах хандалтыг хязгаарлах технологийн арга хэмжээ авч байна.

“Альфа Бет” компанийн хамтын ажиллагааны хүрээнд YouTube, Google зэрэг платформ дахь хүүхдэд сөрөг нөлөөтэй, хүүхдийн эрхийг зөрчсөн контентыг хязгаарлах устгах хүсэлтийг уламжлан шийдвэрлүүлэх чиглэлээр шуурхай ажиллаж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн дэмжлэгээр цахим орчин дахь бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогч хүүхдийн зураг, бичлэгийг цахим орчноос устгах, хязгаарлах **The Internet Watch Foundation** системийг **EKids.mn** сайтын нэмэлт хэлбэрээр нэвтрүүлсэн.

Дараагийн дугаарт нь **Meta** компанитай байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд GREEN CHANNEL буюу шууд харилцах ногоон сувгаар дамжуулан хүүхдэд сөрөг нөлөөтэй, хүүхдийн эрхийг зөрчсөн агуулгатай контент, мэдээллийг устгах, хязгаарлах технологийн арга хэмжээг авч ажиллаж байна.

Сургалт, нөлөөллийн хүрээнд дараах ажлуудыг хийж хэрэгжүүлж байна.

Олон улсын Цахилгаан холбооны байгууллагаас цахим орчин дахь хүүхэд хамгааллын чиглэлээр гаргасан зөвлөмжүүдийг монгол хэл рүү орчуулж, хэвлүүлж, холбогдох байгууллага, хүмүүст түгээсэн.

Google Family Link эцэг, эхийн хяналтын программ зааварчилгаа нэвтрүүлсэн.

Нууцлалын болон аюулгүйн тохиргоо хийх зааварчилгааг Facebook, Instagram, Google, TikTok зэрэг өсвөр насныхны өргөн хэрэглэдэг платформууд дээр нэвтрүүлсэн.

Зөрчилтэй контент мэдээлэх зааварчилгаа Facebook, Instagram, Google, TikTok зэрэг дээр зааварчилгааг нэвтрүүлсэн байгаа.

Сургалт, зөвлөгөөний чиглэлээр “Цахим орчин дахь хүүхэд хамгаалал” үндэсний хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хамтарч зохион байгуулсан.

“Жишиг 10 сургууль” арга хэмжээний хүрээнд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран хүүхэд, багш нарт зориулсан сургалтыг зохион байгуулсан.

“Цахим орчин дахь хүүхэд хамгаалал” сэдэвт сургалтыг танхимаар болон цахимаар 21 аймаг, нийслэлийн хэмжээнд зохион байгуулсан.

Нөлөөллийн арга хэмжээний хүрээнд EKids цахим хуудсыг хөгжүүлж мэдээллийг байнга шинэчилж явж байна.

Цахим орчин нь хүүхэд хамгааллын PAGE-ийг ажиллуулж байгаа.

Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын суурь судалгааг 2020 оноос хойш хийж хэрэгжүүлж байна.

Цахим соёл, цахим орчин, хүүхдийн эрх, “Найз байя” хүүхдийн дугаарын бүртгэл, “Цахим ур чадвар” үндэсний аян, цахим өдөрлөг зэрэг үндэсний аян, өдөрлөгүүдийг он дараалан зохион байгуулж байна.

Цахим орчинд хүүхэд хамгааллын асуудал хууль эрх зүйн чиглэлээр олгогдсон журмуудын хэрэгжилтийг хангах хүрээнд хүүхдийг хортой болон хориотой контентоос сэргийлэх 3 сайдын хамтарсан журмыг 2025 оны 03 сарын 18-ны өдөр баталсан.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас саналуудыг авч манай яам төслийг боловсруулаад, батлаад хэрэгжүүлэн ажиллаж байна.

Цаашид орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг, түүний ажиллах журмыг боловсруулж батлуулахаар Засгийн газарт хүргүүлсэн. Цаашид орон тооны бус зөвлөл маань 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр цахим орчинд хүүхдэд хортой болоод хориотой контентын агуулга дээр хяналт тавих чиг үүрэг бүхий зөвлөл, ажлын алба ажиллана.

Санал зөвлөмжийн хувьд 2026 оны улсын төсөв дээр тодорхой хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх замаар хэрэгжилтийг хангаж ажиллах санал бид Сангийн яам руу хүргүүлсэн ажиллаж байгаа.

Танилцуулга дууслаа. Баярлалаа.

Д.Цогтбаатар: П.Алтан-Од даргад баярлалаа. Одоо сүүлийн танилцуулгыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул танилцуулна. 9 дүгээр микрофон.

Л.Мөнхзул: Хууль зүйн байнгын хорооны дарга болон эрхэм гишүүдэд өдрийн мэнд дэвшүүлье.

Өнөөгийн нөхцөл байдлын талаар хэдэн тоо баримт дурдъя.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хувьд цахим орчин дахь хүүхэд хамгааллын талаарх дуудлага мэдээллийг хүүхдийн тусламжийн 108 утсаар хүлээн авч байна.

Мөн шаардлагатай зөвлөгөө мэдээллийг өгөхөөс гадна холбон зуучлах үйлчилгээг үзүүлж байгаа. 108 тусгай дугаарт ирсэн хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй дуудлагыг 102 утсанд шилжүүлдэг. Харин хүүхдийн эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдлын талаарх яаралтай дуудлагыг 103, амиа хорлох, ахуй, осол гэмтэл, өндрөөс унах зэрэг дуудлагыг 101, 105 дугаарт яаралтай шилжүүлэн хамтран ажилладаг.

108 утсанд 2021-2023 онд ирсэн цахим орчны дарамт, хүчирхийллийн 99 дуудлагыг Цагдаагийн ерөнхий газрын Цахим гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст шилжүүлсэн.

2024 оноос эхлээд ийм төрлийн дуудлагыг кибер гэмт хэрэгтэй тэмцэх газарт цахим хаягаар нь шилжүүлэх үүрэгтэй болсон. Энэ чиглэлээр 38 дуудлагыг шилжүүлсэн байна. Цахим дарамт 2022 онд 83 байсан бол 2023 онд 448 байсан байна. 2025 оны нэгдүгээр улирлын байдлаар 28 тоо бүртгэгдсэн байна.

Харин цахим орчны зохисгүй хэрэглээтэй холбогдолтой дуудлага 2022 онд 15 ирсэн бол 2023 онд 93, 2022 онд яг албан ёсоор бүртгэгдсэн нь 14 гэж буурсан үзүүлэлттэй байна. Гэхдээ 2025 оны нэгдүгээр улирлын байдлаар 65 гэсэн өссөн үзүүлэлттэй дуудлагын тоо ирсэн байна.

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд үе тэнгийн хүчирхийлэлтэй холбогдолтой дуудлага маш их ирдэг. Тухайлан дурдвал 2023 онд 637 дуудлага ирсэн бол 2024 онд 1052 дуудлага ирсэн байна. 2025 оны байдлаар гэхэд нэгдүгээр улирлын байдлаар 193 дуудлагыг бүртгэж, орон нутгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, хэлтэст шилжүүлж хувийн хэрэг, кэйс нээж шаардлагатай кэйсийг хааж, кэйс дээрээ харьж ажиллаж байна.

Бодлого зохицуулалтын хүрээнд өнгөрсөн хугацаанд хийгдсэн ажлыг товч дурдвал 2017 оноос эхлээд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хуучин нэршлээр хүүхдийн эсрэг хүчирхийллийг эцэслэх дэлхийн түншлэлд нэгдсэн. 2018 оноос **WeProtect**, **“Бид хамгаална”** гэсэн загварыг хэрэгжүүлж ажиллаж олон улсад нэгдэж ажиллаж байгаа.

2019 онд салбар дундын ажлын хэсэг байгуулж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд ахлан ажилласан. Энэ ажлын хүрээнд хүүхдийн 108 утасны үйлчилгээний төвийн программ хангамжийг шинэчилсэн.

2020-2021 онд утас, чат, мессежээр дуудлага хүлээн авах ийм боломжтой болгосон. Мөн салбар дундын ажлын хэсгийн хүрээнд түрүүн дурдсанчлан Харилцаа холбооны зохицуулах хорооны хэрэгжүүлж байгаа EKids.mn платформыг хамтран хөгжүүлэлтэд орж ажилласан. Уг платформд ч гэсэн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн ерөнхий газар болон тус яамнаас холбогдох мэдээллийг UPLOAD хийж ажиллаж байгаа. Мэдээллийг хүргүүлж ажиллаж байгаа.

Цахим орчны хамгаалалт, үүрэн холбооны оператор компаниудыг татан оролцуулж хүүхдийн эзэмшиж ашиглаж байгаа гар утасны дугаарыг бүртгэлжүүлсэн.

Эрх зүйн хувьд 2024 онд Хүүхэд хамгааллын тухай шинэчилсэн найруулга батлагдсан.

Энэ шинэчилсэн найруулга дээр тусгагдсан гол зохицуулалт маань бүх төрлийн хориотой хүүхдэд хортой агуулгаас хамгаалах зохицуулалтыг бий болгосон.

Энэ зохицуулалтын хүрээнд дөнгөж 03 дугаар сарын 28-ны өдөр 3 сайдын хамтарсан тушаалаар цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам батлагдсан. Уг журмыг нийтээр дагаж мөрдөх хууль зүйн журмын бүртгэлд хамрагдуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр хүргүүлж ажилласан байна. Цахим хөгжил, харилцаа холбоо, инновацын яамнаас.

Цаашид бид мөн нөлөөллийн ажлуудыг маш олон тоогоор зохион байгуулсан. Нөлөөллийн ажлуудыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын ерөнхий газраас зохион байгуулж байна. Тухайлбал, сургуулийн орчин дахь үе тэнгийн дээрэлдэхээс урьд хүчин сэргийлэх зорилгоор

- ▲ “Найз байя”,
- ▲ “Чи ганцаараа биш”,
- ▲ “Нууцтай байх эрх”,
- ▲ “Нэгдүгээрт хүүхэд зөв байя”,
- ▲ “Цахим орчинд эерэг байя”

гэх мэт арга хэмжээнд 148 мянган сурагч, 5 мянган багш, 50 мянган эцэг, эх, асран хамгаалагчийг хамруулсан байна.

Цаашид хэрэгжүүлэх ямар арга хэмжээ шаардлагатай байна вэ гэдэг дээр Хүүхэд хамгааллын тухай хууль, холбогдох журам, стандартыг сурталчлан таниулах хэрэгтэй байна. Шинээр бий болсон журмын хэрэглээг амьдралд

нэвтрүүлж хэрэгжүүлж эхлэх шаардлагатай байна. Үүнд хүүхдийн эрхийн улсын байцаагчийг сургаж чадваржуулах, мэргэжлийн байгууллагуудтай хамтран өргөн нэвтрүүлгийн телевизүүд болон үүрэн холбооны оператор компаниудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах, хүүхдийн эрх хамгааллын талаар мэдлэг, хандлага, ойлголтыг нэмэгдүүлэх, сургалт, нөлөөллийн ажил зэргийг зохион байгуулах.

Хамгийн чухал нь Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүд ажлын албыг чадавхжуулах ийм шаардлагатай байна гэж дүгнэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Л.Мөнхзул даргад баярлалаа.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Боловсролын яамнаас Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, сайдын зөвлөх Д.Гантулга, Боловсролын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Г.Энхтөр, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Л.Нямгэрэл, Шүүх шинжилгээний ерөнхий газрын Шүүх анагаах ухааны шинжилгээний газрын дарга А.Амгаланболд, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл боловсруулах хэлтсийн дарга Д.Жанчивдорж, Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Б.Мөнхбат, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Од, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Хуулийн хэлтсийн дарга Л.Нямдорж, Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын бодлого хэрэгжүүлэх газрын дарга Т.Батболд Харилцаа холбооны зохицуулах хорооны ажлын албаны дарга А.Лувсан-Очир, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын дарга Б.Баярсайхан Гэр бүлийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Цогтбаатар гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг энэ хуралдаанд оролцож байна.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан сайд, Төрийн нарийн бичгийн дарга нараас асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Асуулт шүү. М.Нарантуяа-Нара гишүүн. Тийм. Дараа нь үг тусдаа. М.Нарантуяа-Нара гишүүнийг оруулъя. Ингээд М.Нарантуяа-Нара гишүүнээр

тасаллаа. М.Нарантуяа-Нара гишүүнийх орохгүй байна. Манай техникийнхэн энэ дээр анхаараарай.

Ингээд О.Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Баярлалаа. Бүгдээрэнд нь өдрийн мэнд хүргэе.

Тэгээд яах вэ энэ асуудал маш чухал асуудал. Тэгээд тал талын яаманд маань оролцоод ийм ажлын хэсэг байгуулаад энэ дээр анхаарал хандуулаад далайцтай өргөн цар хүрээтэй ажиллая, уялдаа холбоогоо хангаж ажиллая гээд энэ санаачилга гарч байгаа дээр маш их баяртай байна.

Тэгээд манай Б.Баярсайхан дарга Улсын Их Хурлын гишүүн байхдаа энэ Цахим орчин дахь хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг санаачлаад явж байсан. Бид энэ хуулийг гаргаж ирээдүй хойч үе хамгаалж, эрүүл монгол хүүхдийг өсгөн бойжуулах тал дээр яалт ч үгүй анхаарах ёстой цаг нь болсон гэдгийг хэлж байна.

Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүний хувиар энэ тал дээр бүрэн дэмжиж ажиллана гээд. Энэ тал дээр их анхаарч судалгаа хийж байсан хүний хувьд гурван асуудлыг хөндмөөр байгаа. Сая мэдээлэл сонслоо.

Тэгээд хоёр долоо хоногийн өмнө Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн хөтөлбөрөөс YOUTH ONLINE SAFETY гээд залуучуудын цахим орчин дахь аюулгүй байдлын талаар нэлээн том сүүлийн үеийн судалгаа хийсэн байна лээ. 2024 онд.

Тэгээд сэтгэл өвдөм нэг асуудал бол 13 настай хүүхэд Facebook нээх боломжгүй. Facebook-ийн өөрийнхөө guide line-аар нээх боломжгүй байдаг. Гэтэл санал асуулгад орсон 13 хүртэлх 12 насны хүртэлх нийт хүүхдүүдийн 90 хувь нь Facebook хаягтай байсан.

Энэ юунаас болж байна гэхээр ерөөсөө сургуулийн багш нар гэрийн даалгавраа facebook групп чатаар өгчихдөг. Тэгээд үүнийг нь эцэг, эхчүүд яалт ч үгүй өөрт нь хаяг нээж өгөөд тэр гэрийн даалгаврыг нь хийх ёстой болдог.

Манай сургуулийн боловсролын салбарынхан маань facebook-ийг өөрсдийнхөө коммуникацыг гол платформ болгочихсон. Үүнийг ерөөсөө болих ёстой. Эндээ зохицсон өөр дараагийн коммуникацын платформыг Боловсролын юм анхаарч хийхгүй бол энэ өөрөө нэг дуртайдаа хийгээд байгаагаас илүүтэй систем өөрөө салбар маань ийшээ оруулчихсан юм байгаад байна.

Тэгэхээр энэ дээр анхаарч шийдэл гаргах хэрэгтэй байгаа шүү гэдгийг хэлмээр байна.

Хоёрдугаарт, П.Наранбаяр сайдын танилцуулга дээр Австрали Улсын хууль дурдагдаж байна.

Ер нь нэлээн олон улс энэ ONLINE SAFETY ACT буюу цахим орчин дахь хүүхдүүдийнхээ эрхийг хамгаалах хуулиудыг гаргасан. 2023 онд ч гэсэн Англи Улс гаргасан. Та бүхэн энэ хуулиудыг судалж байгаа байх.

Энэ хуулийг судлаад хамгийн гол хөшүүрэг байх вэ гэдэг дээр анхаараач ээ. Зөрчлийн хууль дээр зөрчил торгоно гээд явж байх шиг байна. Гэхдээ гол нөгөө online safety буюу энэ платформуудыг чинь хэн эзэмшиж байна гэхээр та бүхний тоо мэдээлэлд байгаа шүү дээ. Тийм ээ. Энэ Facebook байна, YouTube байна, TikTok байна гээд.

Энэ платформуудтайгаа бид хэл амаа ололцоод насанд хүрээгүй хүүхдүүдэд хортой контентыг гаргахгүй байх алгоритм дээр ажиллахгүй бол үүнийг дотооддоо ерөөсөө шийдэх боломжгүй.

Тэгэхээр энэ дээр Цахим хөгжлийн яам манлайлан оролцох ёстой. Энэ платформуудтай холбогдож Монгол Улсын хүүхдүүдийн хувьд ямар зохицуулалт бид хийх гэж байгаа юм. Энэ дээр нь платформууд тэр хууль дүрэм журам.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Нэмэлт өгье. О.Номинчимэг гишүүнд микрофон.

О.Номинчимэг: Тэгж харилцан холбоотой ажиллаж, тэр платформуудад үүрэгжүүлэхгүй бол энэ асуудал шийдэгдэхгүй юм билээ.

Тэгээд өдийг хүртэл яах вэ facebook-т монголчууд цөөхөн 3.5 сая хүнтэй цөөхүүлхнээ болохоор монгол хэлэн дээр өөрсдөө хөрөнгө оруулалт хийдэггүй. Англи хэлтэй ч юм уу, Англи, Австралиуд дээр тэр хортой контентыг шүүх шүүлтүүрүүдийг бүгдийг нь хийчихдэг. Хүн ажиллуулаад байдаг юм уу, дүрстэй. Монгол хэлэн дээр хийдэггүй.

Тэгэхээр энэ шаардлагаа тавиад монгол хэлээр хортой контентыг шүүдэг болгоё. Тэр 13-аас дээш юм уу, 16-аас дээш юм уу? Хүүхдүүд аккаунттай боллоо гэхэд энэ хүүхдүүдэд насанд хүрээгүй хүнд үзүүлэх юм хортой контентуудыг шүүлтүүрүүдийг нь хийх тэр үүргийг тэр платформуудад өгөөд, үүнийгээ олон улсын хэмжээнд энэ платформуудад DEAL хийж ярилцах ёстой. Энэ дээрээ үүргээ хийх ёстой. Үүнийг анхаараач ээ.

Гуравдугаарт, Цахим хөгжлийн яам YouTube гээд ярьж байна. YouTube ямар ч ийм хязгаарлалт байхгүй контентын асуудлууд байгаа. YouTube Kids гээд олон улсад яг.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Тэгэхдээ энэ чинь асуулт шүү дээ. Та хамтатгаад үг хэлчихлээ шүү дээ. Тийм ээ. Үгүй үгүй. Дараагийн юун дээр та үгээ гүйцээгээд хэлчих. Тэгж болохгүй. Боловсролын яам 8 дугаар микрофон.

П.Наранбаяр: Баярлалаа О.Номинчимэг гишүүний асуултад хариулъя.

Яг таны хэлээд байгаа үнэн. 90-ээд хувь нь Facebook ашиглаад явж байгаа. 13 хүрээгүй байж. Тэгээд түрүүн хэлж байна. 67 хувь нь шүү дээ. Бүр хоёр хаягтай.

Энэ дээр вэ гэхээр facebook-ийг сургуулийн орчинд хэрэглэхгүй байх боломж бүрэн байгаа юм. Одоо ингээд Монголын DIGITAL PROVIDER компаниуд яг энэ LMS, SMS гэж ярьдаг. School management system, Loan manager system. Үүнийг бүрэн оруулаад ирчихсэн байж байгаа.

Яг энэ платформ дээрээ суурилад л явах юм бол хүүхдэд ямар нэгэн фэйсбүүкийн мессенжерээр даалгавар өгөөд байх ямар ч шаардлагагүй болно.

Тэгэхээр энэ бодлого руугаа бид шахаад явна. Ерөөсөө ингэхгүй facebook-ийг ийм зохиомол байдлаар нэмэгдүүлээд байгаа нь яахын аргагүй сургууль өөрөө мөн. Тэрийг бид хүлээн зөвшөөрч байна.

Англи Улсын хуулийг давхар судлаач ээ гээд та ч гэсэн хэлж байсан. Энэ давхар судалъя. Австралийнх бол сайн хууль байсан. Англи Улсынхыг бид тодорхой хэмжээнд харсан.

Тэгээд энэ улсуудын хуульд байгаа тэр хөшүүргийн асуудлыг маш нарийн гаргаж ирж бид явуулна.

Тэгээд дахин дахин хэлэхэд энэ сайн хэлцүүлж, сайн шүүж ярилцаж, энэ хүүхдийн эрхийг нийгмийн сүлжээн дэх орчинд л хамгаалах асуудлыг бид илүү хүчтэй тавьж. Цахим орчин гэсэн үг хэрэглээд ирвэл энэ чинь бүр хязгааргүй болоод эхэлнэ. Энэ чинь бүр том ертөнц.

Нийгмийн сүлжээнд буюу энэ Facebook, TikTok, өөр бусад энэ Instagram гэх мэт нийгмийн сүлжээний хамгийн их хэрэглэгддэг энэ орчин дахь хүүхдийн харилцааг л зохицуулахад яваад байгаа шүү дээ. Зохицуулах асуудлыг.

Тэгэхээр энэ асуудлыг Та бүхэн ялгаж харах биз. Тэгээд бусад юун дээр нь манай Цахим хөгжлийн яамныхан хариулах байх. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Манайхан Англи Улс гэж. Их Британийн Английн. Өөрөөр хэлбэл орон нутгийн шинж чанартай засаг захиргааны гаргасан хуулийг яриад

байна уу? Их Британийн парламентын гаргаж байгаа хуулийг яриад байна уу? Энэ чинь парламент дээр бид ярьж байгаа учраас үүнийгээ ялгаж ярихгүй бол Англи Улс гээд яриад байх юм байна шүү. Англи Улс гэдэг бол Их Британийн бүрэлдэхүүн нэг хэсэг шүү дээ.

Тэгэхээр би Их Британи гэж ойлгоод байна. Зөв биз? Их Британийн хууль уу? Тийм ээ. Нэмж хариулах уу? О.Номинчимэг гишүүний асуултад. Цахим Цахим хөгжлийн яамнаас. YouTube, Facebook-тэй холбоотой асуулт асууж байсан. 1 дүгээр микрофон уу?

П.Алтан-Од: Харилцаа холбооны зохицуулах хороон дээр 4 төрлийн гол арга хэмжээг авч байгаа. Би өмнө нь цухас дурдсан.

Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчсөн контентыг нийтэлсэн тохиолдолд эрх бүхий байгууллагын шийдвэр, дүгнэлтээр хар жагсаалтад оруулах DNS[Domain Name System]-ийн бүртгэл дээр Монгол Улсын нутаг дэвсгэрээс хандах хандалтыг хязгаарлах гээд хязгаарлалттай холбоотойгоор Alphabet GOOGLE, META зэрэг компаниудтай шууд зөрчил үүслээ. Хүүхдэд хортой, хориотой контент ч гэдэг юм уу тодорхой хэмжээний зөрчил үүслээ гэх юм бол мэдээллийн дагуу шуурхай шугамаар таслан сэргийлэх арга хэмжээг авч ажиллаж байгаа.

П.Наранбаяр сайдын хэлж байгаа шиг цахим орчин дахь гэхээрээ нэлээн өргөн далайцтай, олон системүүд, платформууд явж байгаа.

Тэгээд нийгмийн сүлжээнд хязгаарлах асуудал дээр 3 сайдын баталсан журмаараа тодорхой хяналт тавих эрхүүд нь байж байгаа.

Иргэдээс болоод бусад.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээж хариулах уу? 1 дүгээр микрофон.

П.Алтан-Од: Хортой, хориотой контент юм уу, агуулгын хувьд зөрчилтэй асуудал байна гэж үзэх юм бол шууд мэдээлж, мэдээллийнхээ дагуу тэр ажлын алба нь Харилцаа, холбооны зохицуулах хороо руу шууд мэдээллийг нь таслан сэргийлэх, хүүхдийн эрсдэлд орсон түвшнийг нь үнэлээд агуулгуудыг нь зогсоох хүртэл арга хэмжээ авах ийм журмын зохицуулалт бий болсон байгаа. Монгол Улсад.

Тэгэхээр цаашид үүнийгээ хэрэгжүүлэх ажлын алба, бусад орон тоо, санхүү төсвийн асуудал дээр бид 2026 оны төсөв дээр санал оруулаад ингээд хэрэгжилтийг бүрэн хангаж явах ийм боломжтой нөхцөл үүссэн байгаа.

Д.Цогтбаатар: О.Номинчимэг гишүүн тодруулъя.

О.Номинчимэг: Яах вэ, тэгээд орон тоо төсөв гээд л хэрэгжүүлэх гээд л. Манайхан чинь тэгээд цахим орчин дээр энэ дээр шуурхай арга хэмжээ авахдаа их болхи шүү дээ. Цахим орчин дээр гэмт хэрэг гарахад ч гэсэн тэрийгээ хэзээ яаж мэдээлээд. Худлаа байдаг шүү дээ.

Тэгэхээр битгий нэг тийм юм хийчхээсэй. Тийм журмын дагуу хийнэ гэхээсээ шууд платформуудтайгаа одоогоос хэлэлцээрт ор оо, шаардлагаа тавь аа. Тэгээд YouTube гэхээр **YouTube Kids** гэдэг контентийн агуулга нь таарсан юмыг Монголд оруулъя гэхээр байдаггүй. Нөгөө хүүхдүүд нь YouTube дээр ямар ч филтергүй контент үзээд өртөөд байдаг асуудлууд байна.

Тэгэхээр энэ дээр Цахим, харилцаа холбооны яам маань гаднын платформуудтай өндөр түвшинд хэлэлцээр хийж, энэ дээрээ улс эх орныхоо ашгийг хамгаалах тал дээр маш сайн ажиллах ёстой шүү гэдгийг хэлмээр байна.

Д.Цогтбаатар: 8 дугаар микрофон. П.Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Баярлалаа. О.Номинчимэг гишүүний хэлээд байгаа энэ маш чухал санаа. Тэгээд яг тэр платформуудтай ер нь Монгол Улс хэлцэлд орох шаардлага гарна.

Тэгээд тэр чинь хилийн гадна байгаа. Монгол Улсад орж ирж байгаа нэвтрэлт хэсэг дээрээ жишээлбэл 16 наснаас дээш гэдэг өөрчлөлт оруулж ирэх ч юм уу, ийм маягаар хэлцэл хийх шаардлагатай.

Тэгэхээр зөвхөн 3 сайдын журмын хүрээнд биш асуудлыг бие даасан бараг ийм нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулиа гаргаж ирж, тусдаа гаргаж ирж ярих нь платформуудтай хэлцэлд ороход их хэрэгтэй гэж харж байгаа. Ийм учиртай. Баярлалаа.

Д.Цогтбаатар: М.Нарантуяа-Нара гишүүний микрофоныг өгье.

М.Нарантуяа-Нара: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгэхээр өнөөдөр 4 яам хамтарсан хуулийн төсөл хэлэлцүүлэх тухай асуудлыг дэвшүүлж байгаад маш талархалтай хандаж байна.

Ер нь манай улсад хүүхдийн зөрчигдсөн эрхийг сэргээх, учирсан хохирлыг тогтоох, хүүхдийн эсрэг зөрчил, гэмт хэрэг үйлдсэн хүн болоод хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуульд тусгасан байдаг. Боловсролын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Жендэрийн тухай хууль, Гэр бүлийн тухай хуулиудад хүүхдийн эрхийн талаар тусгасан байдаг.

Гэхдээ харамсалтай нь үе тэнгийнхний зүгээс дээрэлхэлт, дарамт, цахим орчин дахь хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой зүйл, заалт байхгүйгээс болоод одоо жишээлбэл энэ үе тэнгийнхний дээрэлхэлт, дарамт, хүчирхийллийг үйлдсэн болон хяналт тавих үүрэг бүхий этгээдүүдэд ногдуулах хариуцлагын систем тодорхой биш учраас хохирогч нь л давхар давхар хохироод яваад байдаг ийм үйлдлүүд байна.

Би жишээлбэл цахим яамны мэдээлэл дээр нэг зүйлийг жаахан гайхлаа. Жишээлбэл, цахим яамнаас гадаадад хэрэгжиж байгаа, гадаадын туршлагыг орчуулаад жишээлбэл тарааж байна гэсэн ийм юм ярьж байна л даа. Би гайхаж байна.

Монгол хүний, монгол хүүхдийн онцлог, монгол хүүхдийн авч байгаа боловсролын агуулга, монгол хүүхдийн хүмүүжлийн орчин, гэр бүлийн орчин, Монголын нийгмийн онцлогийг судлахгүйгээр шууд гадаадын юмыг бид орчуулаад түгээж тарааж байгаа чинь бүрэн оновчтой биш байгаа учраас өнөөдөр цахим орчинд жилийн дундаж өсөлт нь 62 хувьтай өндөр байгаагийн илрэл.

Өнгөрсөн маш их цаг хугацаанд маш их мөнгө зарцуулж, маш олон зүйл хийсэн ч гэсэн өнөөдөр ийм өсөлттэй байгаа чинь өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн энэ бүх бодлогууд төдийлөн оновчтой байгаагүй, байндаа хүрээгүй, үр дүн өгөөгүй гэсний л илэрхийлэл шүү дээ.

Тэгэхээр эндээс одоо жишээлбэл өнгөрсөн хугацаанд бид энэ Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль, Боловсролын тухай хууль, энэ салбар дундын хуулиудаар бид хүчирхийллийн эсрэг хууль журмын зохицуулалтууд нь үр өгөөжгүй байсан гэдэг ийм юм бид нарт гарч ирээд байна.

Тэгэхээр гадаадын юмыг судалъя гээд ярьж байна. Жишээлбэл, Америкийн Нэгдсэн Улсад **The No Child Left Behind** гээд нэг ч хүүхэд хохирохгүй байх тухай хууль. Бүхэл бүтэн 50 муж улсад нь **Bullying and State Law** гээд. Одоо жишээлбэл яг дээрэлхэлтийн эсрэг хуулиудыг хэрэгжүүлээд явж байна. Бид ингээд олон улсын сайн туршлагуудаас судалъя гэж байгаа нь сайн боловчиг бид өөрсдийнхөө онцлогийг судалж, өөрсдийнхөө онцлогт тохирсон Монгол хүний өгөгдөл, хүмүүжил, орчин нөхцөл, нийгмийн ахуй, эдийн засаг энэ бүх юмандаа.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Минут нэмж өгье. М.Нарантуяа-Нар гишүүнд.

М.Нарантуяа-Нара: Нийцсэн бодлого хэрэгжүүлэхгүй л юм бол бид мянган гадаадын супер хуулиудыг оруулж ирээд яахгүй.

Дээрээс нь Америкийн **The No Child Left Behind** чинь сургуулийн хүүхдийн хувьд үйлдэгдэж байгаа үе тэнгийн дээрэлхэлт, цахим орчны дээрэлхэлтүүдийг сургууль хүлээх журмуудыг өгч байгаа байхгүй юу. Тэгж байж сургуулийн үүрэг хариуцлагыг, сургуульд юун төлөө сэтгэл зүйч, нийгмийн ажилтан гээд багш нарыг хуваарилаад цалин тусад нь төсөвлөөд байгаа юм.

Тэгэхээр энэ хүмүүсийг хүмүүсийг үүрэгжүүлэх, хариуцлагажуулах энэ аж ахуйг хийх хэрэгтэй. Тэгэхгүйгээр бид зүгээр л байгаад байвал.

Тэгээд дээрээс нь цахим яамнаас энэ троллын эсрэг бодлогыг хэрэгжүүлэхгүй бол болохгүй нь. Яагаад гэвэл троллууд чинь зөвхөн олны танил бие даасан хүмүүс рүү харилцаад байгаа юм биш. Хамгийн гол нь эд нар чинь цахимаар хүүхдүүдийг урхидах.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Саяын ярьсан зүйлд хариулт, эсвэл тайлбар тодотгол хийх. Санал л байлаа л даа. Ажлын хэсэгт яах уу? 1 дүгээр микрофон. Дараа нь 5 дугаар микрофон өгье.

П.Алтан-Од: М.Нарантуяа-Нара гишүүний асуулт, санал дээр дурдагдаж байгаа тэр зөвлөмж, зааварчилгаа гэдэг дээр Олон улсын цахилгаан холбооны байгууллага. Манайх гишүүн орон. Нэлээн олон улсууд үүний гишүүн орноор ажилладаг.

Цахим орчин дахь хүүхэд хамгааллын чиглэлээр гишүүн орнууддаа зөвлөмж гаргадаг. Үүнийг зайлшгүй Монгол хэл дээр хөрвүүлэх үүрэгтэй. Үүнийг цаашид түгээх үүргийг гишүүн орны хувьд хүлээдэг.

Энэ зарчмаараа Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүүхдийн сантай хамтарч энэ зөвлөмжүүдийг орчуулж хөрвүүлсэн.

Цаашид гишүүн орны хувьд бодлогын бичиг баримтууд, хууль эрх зүй дээрээ цаашид анхаарах вэ гэдэг дээр нэлээн ач холбогдол бүхий зөвлөмжүүдийг ирүүлсэн байдаг.

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон.

Б.Баярсайхан: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амрыг эрье.

М.Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулъя. Өнөөдөр хууль эрх зүйн хувьд хүүхдүүдээ хамгаалах, хүүхэд хамгааллын тухай хуульд эцэг, эхчүүдэд хариуцлага хүлээлгэх, багш нар, сургуулийн орчинд хариуцлага алдсан төрийн албан хаагч нар хариуцлага хүлээх гээд. Энэ хууль эрх зүйн орчин маань бүрдчихсэн байгаа юм.

Хамгийн гол нь өнөөдөр 4 яамны танилцуулга дээр ч гэсэн ерөнхийдөө энэ асуудлын уг уршгийг нь төдийлөн дурдахгүй байна гэж харж байна.

Бид цахим орчинд хүүхдүүд хүмүүжилгүй байгаа нь өнөөдөр томчуудын цахим орчны соёлын асуудал хүүхдүүдэд маш буруу үлгэр дуурайлал үзүүлж байгаа. Томчуудын цахим орчинд бие биеэ дээрэлхэж байгаа, гадуурхаж байгаа, хэрэглэж байгаа үг соёл.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 5 микрофон гүйцээгээд өгье.

Б.Баярсайхан: Бидний хийсэн шалгалтаар хаалттай группүүд нээгээд ерөнхий боловсролын сургуулийн ахлах анги, өсвөр насны хүүхдүүдийн дунд “дэлхийгээс зайл”, “халтруудаас салъя” гэх мэтчилэн хаалттай группүүд нээгээд бие биеийгээ хөгжлийн бэрхшээл, аав, ээжийнх нь алдаа оноо, ямар нэгэн амьдралынх нь хэв маягаар доромжилж, гадуурхаж, дээрэлхэж байгаа ийм асуудал маш их байгааг бид илрүүлсэн.

Тэгэхээр цахим орчинд насанд хүрэгчдийн соёлын асуудлыг бид илүү их ярих шаардлагатай байгаа.

Өнөөдөр ямар ч насны хүүхэд facebook, сошиал орчинд нэвтрэх эрхтэй байгаа. Тэгээд томчуудын үлгэр дуурайлал өнөөдөр энэ дээр ямар ч хууль эрх зүйн асуудал хэрэггүй. Ерөөсөө монгол хүмүүсийн ёс суртахууны асуудал. Биднийг хүүхдүүд харж байгаа шүү, дуурайж байгаа шүү гэдэг энэ асуудлыг хүн болгон бодох ёс дуу болчихоод байгаа юм.

Хоёрдугаарт,.../минут дуусав/

Д.Цогтбаатар: С.Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье. М.Нарантуяа-Нара гишүүнд 1 минут өгье.

М.Нарантуяа-Нара: Түрүүн цахим яаман дээр хэлж байна л даа. Би түрүүн асуух гэж байсан асуултаа үргэлжлүүлээд асууя.

Хүүхдүүдийг жишээлбэл эцэг, эхчүүд нь өөрсдөө мэдээж хаяг нээж өгөхгүй. Гэтэл хүүхдүүд ямар нэгэн аргаар хаяг нээгээд. Энэ тролл хаягуудын. Мэдээж жишээлбэл бодит хүн хүүхдүүдийг ямар нэгэн байдлаар аливаа буруу зүйлд уриалаад урхихах, дээрэмдэх, дарамтлах, улмаар бүр садар самуунд уруу татах, бэлгийн хүчирхийлэл, аливаа нэгэн хүчирхийлэл үйлдэх юм хийхгүй шүү дээ.

Тэгэхээр энэ троллын эсрэг бодлого яаж баримтлах юм бэ гэдэг асуудал байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, 2025 онд гэхэд хүүхэд хамгааллын төсөвт 2.5 тэрбум орчим төгрөг төсөвлөсөн байгаа. Эндээс жишээлбэл яг энэ цахим орчинд хүүхдүүдийг хамгаалах бодлогод хэдэн төгрөг зарлагадаад, үр дүнг нь хэмжих боломжтой явж байна уу? Өнгөрсөн 2024 онд.../минут дууса/

Д.Цогтбаатар: 1 дүгээр микрофон.

П.Алтан-Од: М.Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулъя.

Эрх бүхий байгууллагын албан шийдвэр, дүгнэлтээр МЕТА компани руу хүсэлт явуулж, хуурамч хаягийг устгах. Тролл гэж хэлж байгаа. Хуурамч хаягийг устгах арга хэмжээ авагдаж байгаа.

2024 оны статистик судалгаагаар 967 хүсэлт ирүүлсний үндсэн дээр 5502 контент буюу цаана нь хуурамч хаяг, аккаунтууд явж байгаа. Устгуулах хүсэлтийг явуулснаас 3722 нь үндэслэлтэй бөгөөд контентыг устгах шийдвэрийг гаргаж, 68 хувийг нь устгаж байсан статистик тоон мэдээлэл байна.

Цаашид хуурамч хаяг, аккаунт гэдэг нь хувь хүний хэрэглээтэй холбоотой сошиал, нийгмийн харилцаатай холбоотой асуудал байдаг.

Тэгээд үүнийг таслан сэргийлэх тал дээр мэдээж бодлогын бичиг баримтууд, хууль эрх зүйн зөрчил, хариуцлага тооцох механизмууд нь тодорхой байдаг боловч маш их хэмжээний жилээс жилд тоогоос тоонд статистикууд мэдээллүүд өсөөд байгаа. Тантай санал нэг байна. Тэгээд үүнийг таслан сэргийлэх тал дээр бүх л түвшиндээ бодлогын чиглэлээр хамтран ажиллаж дэмжиж Улсын Их Хурал Засгийн газраар оруулах шийдвэрүүдийг ойрын үед төлөвлөж оруулахаар төлөвлөж байгаа.

Д.Цогтбаатар: Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье. С.Эрдэнэболд гишүүнийг түрүүн би хэлчхээд М.Нарантуяа-Нара гишүүн рүү шилжчихсэн болохлоор хасчихсан байна.

Ц.Сандаг-Очир гишүүний нэрийг үлдээгээд. Эндээс хасаж болохгүй. С.Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэболд: Баярлалаа.

Тэгэхээр хэдүүлээ асуудлаа ер нь цогцоор харах дээр их анхаармаар байгаа юм. Сая жишээлбэл Б.Баярсайхан даргын хэлж байгаа зөв.

Нэгдүгээрт нь, дарааллын хувьд нэр томьёон дээрээ яамд яг энэ тодорхой ингэж тогтож авмаар байгаа юм. Яагаад гэхээр энэ бол шинэ тутам

харилцаа бий болж байгаа. Энэ зөвхөн Монголын ч асуудал биш, дэлхийн асуудал болчихсон.

Тэр “сошиал медиа” гэдгийг “нийгмийн сүлжээ” гэж хэлээд байна. Тэгээд ер нь бүгдээрээ л их олон англи үг ашиглаж яриад байгаа ч гэсэн энэ нь цаанаа монголоор оновчлох юм бол одоо яг тодорхой зүйлийг л нэг ийм нэр томъёоны лавлагаа маягийн зүйлийг Төрийн хэлний зөвлөлтэй хамтарч байгаад хийх ёстой юм шиг байгаа юм. Цахим яам энэ дээр манлайлаад хийх ёстой юм шиг байгаа юм.

Тэгэхгүй болохоор, одоо жишээлбэл юу гэдэг юм, DEFAMATION, ABIUSTMENT гээд үгүүдийг монголоор яг яаж яаж жишээлбэл цахим орчинд тодорхойлох юм бэ. Заримдаа DIGITAL гээд л, заримдаа ЦАХИМ гээд л, заримдаа ONLINE гээд л заримдаа VIRTUAL гээд л янз бүрийн үгүүд байгаад байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ болгоныг оновчлоод хамгийн түгээмэл хэрэглэгддэг 100 хувийн ч гэдэг юм уу зүйлийг хийх ёстой.

Яагаад гэхээр дараа нь энд санкцын тухай асуудал яригдахаар шүүх дээр хэрэг очно гэсэн үг. Хэрэг очихоор ойлголт ямар байхтай холбогдуулаад эрх зүйн үр дагаврууд гарна гэсэн үг байхгүй юу.

Тэгээд тэр утгаараа энэ дээр ажлын хэсгээс түгээмэл хэрэглэгдэж байгаа нэр томъёонуудынхаа лавлагааг Төрийн хэлний зөвлөлтэй хамтраад тайлбар авбал сайн байна. Нэг.

Хоёрдугаарт, ер нь “Хиймэл оюун ухааны үндэсний стратеги”-ийг улс орнууд батлаад байгаа. Үүнийг манай улс яаравчлах зайлшгүй шаардлагатай байгаа. Цахим яам энэ дээр хариулмаар байгаа юм.

Дараагийн нэг чухал асуудал, түрүүн Боловсролын сайд хэлж байна лээ. Facebook, Instagram, TikTok мэтийн “нийгмийн сүлжээ” гэж хэлээд байгаа. Жишээлбэл, энэ GAMING буюу тоглоом чинь бас ийшээ орчихсон. Одоо ингээд онлайнаар буюу цахимаар тоглоод хоорондоо чатлаад явчхаж байгаа байхгүй юу. Энэ харилцааны нэг хэлбэрийг агуулаад байгаа юм л даа.

Тэгэхээр энэ мэтийн зүйлүүд дээрээ бид нухацтай авч үзмээр байна.

Судалгааны материалуудыг уншсан. Facebook гэж их яваад байгаа. Яг үнэн хэрэг дээрээ насанд хүрээгүй хүүхдүүдийн дунд Instagram маань хавь илүү харилцааны хэрэглүүр болчихсон байгаа шүү. TikTok эд нар нь.

Тэгэхээр хэдэн зүйл байгаа юм. Жишээлбэл, та нарын харьцуулаад байгаа энэ өндөр хөгжилтэй орнууд чинь нийгмийн дэд бүтцүүд шийдэгдчихсэн орнууд байгаа юм. Манай улсад болохоор нийгмийн дэд бүтэц шийдэгдээгүй байгаа юм. Жишээлбэл, замын хөдөлгөөний 2024 оны судалгааг харахаар 900 гаруй хүүхэд зам тээврийн осолд өртсөн байгаа юм. Нийт том зургаараа шүү.

Гэтэл яг өглөөний 7 цаг, өдрийн 1 цаг, оройны 5-аас 7 цаг буюу хичээл ордог, өглөөний ээлжийн хичээл ордог, өдрийн ээлжийн хичээл тардаг, ажил тардаг буюу оройн ээлжийн хичээл тардаг үеэр гэмт хэргийн гаралт огцом өсөж байгаа юм. Огцом өсөж байгаа юм. 5 сар, 9 сар, 10 саруудад гэмт хэргийн гаралт огцом өсөж байгаа юм. 1 минут сунгаад авчихъя. Асуултаа асуугаад байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Минутаа одоо авах юм уу? С.Эрдэнэболд гишүүнд 1 минут.

С.Эрдэнэболд: Тэгэхээр бид шууд ингээд хориглоод хаачхаар яг одоо жишээлбэл дунджаар өндөр хөгжилтэй орны хүүхдүүд 2 цагт цахим орчинд аялж байна гэж байнгуут Монгол хүүхдүүдийн хувьд шууд 4 цаг болоод 2 дахин их байгаа байхгүй юу. Тэгэнгүүт яг тэр цаг дээр чинь нөгөө 17 наснаас доош хаангуут тэр хүүхдүүд цагаа өөр юманд зарцуулах хэрэгтэй болно доо. Гэтэл яг тэр өөр юманд зарцуулах гэж байгаа цаг нь өөрөө асар эрсдэлтэй болчихоод байгаа байхгүй юу. Бас. Нөгөө талаасаа. Шууд эрсдэл рүү орж байгаа.

Тэгэхээр энэ чинь эргээд бид нэг асуудлыг хаахаасаа илүүтэйгээр нөгөө талд нь тэр цагийг яаж аюулгүй зөв боловсон өнгөрүүлэх вэ гэдэг хүртээмжтэй нийгмийн дэд бүтцийг нь давхар оруулж ирэх хэрэгтэй.

Түрүүн Б.Баярсайхан даргын хэлсэнчлэн бас тэр насанд хүрэгчдийн шууд болон шууд бус утгаараа нөлөөлж байгаа нөлөөлөл нь хэд юм?

Тэгэхээр одоо асууж байгаа асуулт Та нар энэ дээр төсөөтэй байдлын судалгаа буюу үр дүнгийн симуляц хийж үзсэн үү? Би симуляцыг асууя. Яамдаас.

Ц.Сандаг-Очир: С.Эрдэнэболд гишүүний асуултад хэн бэ? П.Наранбаяр сайд. Ажлын хэсгийн 8 дугаар микрофон. Дараа нь ажлын хэсгийн 1 дүгээр микрофон. Цахим хөгжлийн яамнаас.

Асуултад хариулаарай. Бэлдэж байгаарай. 8 дугаар микрофон.

П.Наранбаяр: Ойлголоо.

Тэгэхээр нэр томъёогоо цэгцэл гэдэг маш зүйтэй. Үнэхээрийн би таны хэлсэн тэр англиар хэлснүүдийг заримдаа “цахим” гэж буулгаад л, тэгээд л сав руу л бүх юмыг хийчхээд. Тэрийг өөр өөрийнхөөрөө ойлгоод явчихдаг.

Хиймэл оюун ухааны стратегийн тухай Цахим хөгжлийн яамнаас ярих байх. Энд бас нэг хэлэлцүүлэг хийгээд нэлээн ажил эхэлж байна гэж би хөндлөнгөөс харж харж байгаа.

Ер нь хиймэл оюун ухааныг заах ажлыг одоо нэгдүгээр ангиас нь эхлээд Компьютерын ухаан гэдэг хичээлийг оруулж ирэхээр хөтөлбөрийн шинэчлэлээр бид оруулж байгаа. Үүний нэг хэсэгт нь хиймэл оюун ухаан орж ирнэ.

Ер нь хиймэл оюун ухаангүйгээр өнөөдөр цаашаагаа нэгэнт л явахаа больчихсон ийм үед. Бид тэгэхдээ өөрөө аюулгүй байдлаа, хүний аюулгүй байдлыг, хүүхдийн эрхийг хэрхэн хангах вэ гэдэг дээр л сайн бодож байх ёстой гэж бодож байна.

Тэгээд таны хэлээд байгаа тэр Facebook, Instagram-аас гадна тэр цахим тоглоомоор дамжаад яг л энэ нөгөө SNS буюу тэр нийгмийн сүлжээний үүргийг тэнд гүйцэтгээд явчхаж байгаа.

Тэгэхээр бид тодорхойлолт дээрээ их нарийн ажиллах ёстой. Тодорхойлолтоо их сайн гаргаж ирж энэ хуулийнхаа төсөл дээр үзэл баримтлал дээрээ нарийн гаргаж ирж байгаад тус тусад нь хэрэгцээтэй арга хэмжээг авах ёстой гэж хэлж байна.

Хүүхэд бол гэр бүл. Тэгээд сургуулийн орчинд өсөхөөс гадна таны хэлсэнчлэн нийгмийн дэд бүтэц шаардагддаг. Нийгмийн орчинд өсдөг ийм хүмүүс.

Тэгэхээр энэ орчинд нь бэлтгэл байхгүй ордог юмыг нь хаагаад хаячихвал гэдэг юм. Тэгэхдээ зөндөө юм үлдэнэ. SNS-ээс гадна хүүхдийн хөгжилд зориулсан. Интернэт орчныг нь бүрэн хаагаагүй шүү дээ. Интернэт орчин нь байна. Тэгээд сургалтын янз янзын хүүхэд тоглох аргаар сурдаг янз янзын программ хангамжууд байж л байна. Ийм байгаа.

Хоёрдугаарт, ер нь хүүхдийн яг энэ хичээл сургуулийнхаа замд хөгжих боломжийг янз янзын хүүхдийн хөгжлийн орднууд байна. Мөн бичил номын өргөөнүүд байна. Хүүхдэд гэр бүлээр нь, гэрээр нь ном олгодог газрууд ч юм уу ийм зүйлүүдийг нэмэгдүүлэхээр Боловсролын яам ажиллаж байгаа.

Хүүхдэд гуравдагч орчин хэрэгтэй. Гадаа тоглодог тоглоомын талбай. Тоглож болдог сайхан газрууд, хүүхэд чөлөөт цагаа зөв өнгөрөөдөг газрууд нь

байж ингэж хэлдэг нь үнэн. Түүний зэрэгцээ гэр бүлийн их зөв хүмүүжил хүүхдэд өнөөдөр үнэхээрийн хэрэгтэй байна. Ийм нөхцөл байдалд байж байгаа.

Тэгэхээр бид энэ хуулийг гаргаж ирснээрээ хүүхдийн эрхийг хамгаалах юм байна. Дээр нь нэмээд жоохон хамжааргатай болж, үндэсний аюулгүй байдлын хувьд ч гэсэн энэ бэхжинэ гэж харж байгаа.

Дээр нь нэмээд энэ хууль ингэж хэрэгжиж эхэлснээрээ тролл буюу тэр хуурамч хаягаар орох боломжууд ер нь багасаж эхэлнэ. Ер нь багасна. Ер нь хумигдана гэж харж байгаа. Яагаад гэвэл энэ ID-ээр хүн орох хэрэгтэй болно. Хүүхэд гэдгээ нотлох. 16-аас дээш насны гэдгээ нотлох хэрэгтэй тул ард нь үүнийг нь шалгадаг программууд ажиллаж эхэлнэ гэж би харж байгаа.

Тэр симуляцын тухайд симуляцыг бид одоохондоо хийгээгүй байна. Гэхдээ зайлшгүй хуулийнхаа үзэл баримтлалыг боловсруулах явцдаа ийм симуляц.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье. Тэгвэл 1 номер. Ц.Сандаг-Очир гишүүнийг тэгвэл эндээс битгий хасаарай.

П.Алтан-Од: С.Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя.

Монгол Улс хиймэл оюун ухааны стратегиа батлах зайлшгүй шаардлага байгаа. Хиймэл оюун ухааны стратегийг шинэ Засгийн газар бүрдсэний дараагаар ажлын хэсэг гаргаж, манай яаман дээр анхны төслийг боловсруулаад 1 сард үндэсний хэмжээний хэлэлцүүлгийг өргөн хүрээтэй зохион байгуулж, Оксфордын их сургуулийн эрдэмтэд, холбогдох олон улсын экспертүүд ирж зөвлөмж өгч. Цаашид бид бүс нутгийн хэмжээнд Бүгд Найрамдах Солонгос Улс, Европоос бид Эстонийн сайн жишээ нутагшуулах, стратеги дээрээ ер нь ямар стратеги баримтлах юм гэдэг асуудлууд дээрээ ер нь зүг чиг луужингаа тодорхойлсон.

Одоо энэ хавартаа багтаагаад стратегиа батлуулахаар анхны драфт төслүүд бэлэн болсон байж байгаа.

Нийгмийн сүлжээнд энэ олон нэр томьёог хэрхэн цаашид ашиглах вэ гэдэг тал дээр бид.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээгээд хариулъя. 1 дүгээр микрофон.

П.Алтан-Од: Тийм. Төрийн хэлний зөвлөлтэй тодорхой түвшинд хамтарч ажиллаж байгаа. Жишээ нь, хамгийн наад зах нь сая дурдагдаж байгаа “хиймэл оюун ухаан” гэж бодлогын бичиг баримтууд, хуулиуд дээр нэр томьёод дурдсан

байдаг Төрийн хэлний зөвлөл сая 2 сард “хиймэл оюун” гэж явах нь зүйтэй юм гэж нэр томьёог нэг талд нь шийдвэрлэж байгаа.

Тэгэхээр цаашид шинэ тутамд үүсэж хөгжиж байгаа техник технологи, мэдээллийн технологийн нэр, томьёонуудыг нэг мөр гаргах асуудал дээр С.Эрдэнэболд гишүүний санаачилга маш зүйтэй санаачилга. Энэ дээр бид Төрийн хэлний зөвлөлтэйгөө нэлээн хамтарч ажиллаж шийдвэрлэх асуудлын нэг гэж үзэж байгаа.

Д.Цогтбаатар: Симуляц түрүүн П.Алтан-Од дарга хийгээгүй гээд тэгж байх шиг болсон. Тийм ээ. П.Наранбаяр сайд. Симуляц дээр хариулах хүн байна уу? 9 дүгээр микрофон.

Л.Мөнхзул: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул.

Яах вэ, яг симуляц гэж хийгээгүй. Тэгэхдээ  [digital intelligence or digital intelligence quotient (DQ)] /DQ Institute/ гээд олон улсын байгууллагаас нийтлэг гаргасан хүүхдийн цахим орчин дахь буюу онлайн гэж байгаа юм. Цахимыг болохоор онлайн. Онлайн орчин дахь аюулгүй байдлын индексийг гаргадаг.

Энэ индексийн түвшинд өөрөөр хэлбэл тухайн улс орнууд хэр зэрэг хүүхэд интернэтийн орчинд орсноор аюултай вэ гэдэг тэр түвшинг тогтоогоод үнэлдэг.

2023 оны үзүүлэлтүүдээс нь харахад үндсэндээ 6 агуулгын хүрээнд байх ёстой.

- Нэгдүгээрт, хүүхэд технологийг аюулгүйгээр эзэмших боломж байна уу. Хүүхдийн өөрийнх нь боломж.
- Хоёрдугаарт, хүүхдийг цахим орчинд аюулгүй байдлаар нэвтрэх боломж нь гэр бүлийн орчинд хангагдаж чадаж байна уу.
- Гуравдугаарт, сургуулийн орчин.
- Дөрөвдүгээрт, компаниуд болон цахим мэдээллийг хангаж байгаа, цахим мэдээлэл түгээж байгаа онлайн платформ.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 9 дүгээр микрофоныг гүйцээгээд өгье.

Л.Мөнхзул: Тавдугаарт, хамгийн гол нь Засгийн газрын бодлого, дүрэм журам хангалттай байна уу.

- Зургадугаарт, хүүхдийг он онлайн орчинд аюулгүй байх технологийн дэд бүтэц хангагдаж байна уу. Хязгаарлалтуудыг нэвтрүүлэхээр.

Тэгээд улс орнууд үндсэндээ Боловсролын яамнаас санаачилсан улс орнууд бусад арга хэмжээнүүд байж байгаа. Тухайлбал, түрүүн дурдагдсан Их Британи насны хязгаартай. Цахим орчны хэрэглээний хязгаарлалттай хуулийг 2019 онд хянасан байгаа.

Тэгэхээр энд ерөөсөө л насны хязгаарлалттайгаар цахим буюу онлайн орчинд байх. Энэ дээр компанийн хариуцлагын хүрээнд тодорхой бизнес эрхлэгчдэд хариуцлагыг ногдуулах байдлаар зохион байгуулсан. Нөгөө загвар нь институцийн буюу тодорхой комиссарууд гаргаад хяналт тавих загвараар явдаг ийм загварууд байна. Хүүхэд хамгааллын тухай хууль дээр энэ загварын өнгөц хэлбэрээр хэрэглэсэн. Журмын зохицуулалтаар одоогоос хэрэглээд явж байгаа.

Тэгэхээр цаашдаа бие даасан эрх зүйн орчин бүрдүүлээд зөвхөн нийгмийн сүлжээ төдийгүй.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Хариулт хангалттай юу? Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Энэ асуудал нэг их шинэ зүйл биш байгаа юм.

Яагаад гэхээр өнгөрсөн парламент дээр энэ асуудал яригдаад Нийгмийн бодлогын байнгын хороон дээр нэр бүхий 4 гишүүн. Одоо энд сууж байгаа Б.Баярсайхан гишүүн тухайн үед гишүүн байсан. Санаачилга гаргаад, тэгээд Ц.Мөнхцэцэг гишүүн, М.Оюунчимэг гишүүн билүү хэн билээ. Ингээд бид 4 санаачлаад өргөн барьж байсан.

Энэ хууль ер нь хаана явна вэ? Яг энэ Цахим орчинд хүүхэд хамгаалах тухай хуулийг өргөн барьсан. Одоо 4 яам хамтраад хуулийн төслийг оруулж ирэх юм байна гэж ойлголоо.

Тэгэхээр өргөн баригдсан хуультай концепцоороо яаж нийлж байгаа вэ? Үзэл баримтлалын хүрээнд өөрчлөгдөж байгаа нь вэ гээд. Нэгд.

Хоёрт, техникийн боломжийн хүрээнд ер нь яг ингээд насанд хүрээгүй насны хязгаар заах юм байна. Хаах бололцоо боломж байгаа юу?

Бид чинь ер нь л бас хүүхдийн нэг талаасаа эрхийг нь хязгаарлах гэж байгаа юм. Хязгаарлана гэдэг нөгөө талаасаа сөрөг үр дагаврыг авчирдаг. Тэр тусмаа бид чинь мэдээлэл технологи өндөр хөгжсөн нийгэмд амьдарч байна.

Одоо энэ хүүхдүүдийг гар утасгүйгээр, тэр яриад байгаа Facebook, тэр Instagram, TikTok-гүйгээр төсөөлөхийн аргагүй болчхоод байна шүү дээ. Энэ бол амьдралынх нь нэг хэсэг болчихсон байна. Хүүхдүүдийн.

Одоо энэ утасгүйгээр гэдэг юм уу, энэ аппликэйшнгүйгээр төсөөлөхийн аргагүй болчхоод байна шүү дээ. Яг үнэнийг хэлэхэд. Тэгээд үүнийг нь бид хязгаарлах гэж байна. Ингэхээр сөрөг үр дагавар гарах вэ гэдгийг Та бүхэн тооцож үзсэн юм байна уу, үгүй юу?

Магадгүй эерэг талаасаа зөндөө олон асуудлууд эерэг гарна. Хамгаалал талаасаа олон асуудлууд гарна. Тухайлбал, Хятад Улс гэдэг чинь урд хөрш маань “Эй Ай” гэдэг юмыг чинь, хиймэл оюун ухааны чинь сургалтынхаа хөтөлбөрт оруулж ирж байна шүү дээ. Сургалтын хөтөлбөрт бүр тусгайлан “Эй Ай”-ийн хичээлийг заах гэж байна. Тэгээд дэлхий нийт чинь өөрөө мэдээлэл технологиор бүр хол тасраад явчхаж байна.

Тэгэхээр бид энэ хуулийг гаргалаа гэхэд сөрөг үр дагавар гарах тэр эрсдэлийг тооцож үзсэн үү гэдэг, ийм тооцоо судалгаа хийсэн үү гэдэг.

Нөгөө талаас түрүүн О.Номинчимэг гишүүний асуусан асуулт дээр. Угаасаа энэ Facebook чинь анх тэр оюутнуудын л хичээл, даалгавраа хийхэд л зорилгоор л байгуулагдсан л юм байгаа шүү дээ. Аппликэйшн. Тэгээд сүүлдээ дэлхий нийтийн харилцааны юу болсон.

Тэгэхээр хичээл сургалтын үйл ажиллагаанд гар утас, facebook, messenger chat-ын оролцоо асар их байгаа шүү дээ. Түрүүн хэлж байсан. Үүнгүйгээр сургалтын үйл ажиллагаа явуулахад л бас хүндрэлтэй болно.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Нэмэх үү? Хэддүгээр микрофон? 8 дугаар микрофон. П.Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Тэгэхээрээ 2024 онд Ц.Сандаг-Очир гишүүн таныг Их Хурлын гишүүн байхад, Б.Баярсайхан гишүүн нар Улсын Их Хуралд өргөн барьсан хуулийн төсөл байдаг. Тэр нь Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах тухай гээд.

Энэ хуулийн төсөл бидний ойлгосноор Хүүхэд хамгааллын тухай хуулийнхаа 25 дугаар зүйлд нэлээн сайн тусаад, энэ 25 дугаар зүйл дотор нь цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах нэлээн олон заалтууд орсон байдаг.

Бидний гол юм нь яг энэ үзэл баримтлалтай харшилдах зүйл огт байхгүй. Эсрэгээрээ илүү тодорхой болгож эхэлж байгаа юм. Юуг нь хязгаарлах юм, яаж оролцоог нь зохицуулах юм. Хүүхдийн оролцоог ийм л асуудал.

Тэгэхээр бид бүрэн хааж байгаа юм биш. Тодорхой ийм сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй гэсэн SNS орчин дахь тодорхой юмыг хаахаас биш хүүхдийн интернэт орчин сурах эрхийг огт хөндөхгүй ээ.

Тэгэхээр өнөөдөр жишээлбэл Боловсролын яамнаас <https://eduten.com> гээд л математикийн сургалтын платформыг хэрэгжүүлж байна. Өнөөдөр бас энэ PEARSON гээд л хөтөлбөр байна. Бас л шууд дижитал хэлбэрээр суралцах боломжоор хангаж байна. Ийм зүйлүүд байна. <https://medle.mn> сургууль байна. 17 мянгын хичээл байна. Тэнд хүүхдүүд бүрэн өөрөө үзээд ороод явах боломжтой ийм зүйлүүд нь үлдэнэ.

Нөгөө талдаа дэлгэцийн донтолт гэх мэт сөрөг үр дагавруудыг харах ёстой. Тэгээд бид олон тал асуудлыг нь харах ёстой.

Тэгэхээрээ Ц.Сандаг-Очир гишүүн таны хэлсэнчлэн хэрвээ хязгаарлавал ямар сөрөг үр дүн гарч болох вэ гэдэг. Бас энэ сөрөг үр дүнгүүдийг тооцох л ёстой. Жишээлбэл, Facebook-тэй ямар хэлцэлд орох юм, Instagram-тай яах юм.

Мөн энэ асуудлаар олон улсад яаж зөвөөр ойлгуулах юм ч гэдэг юм уу.

Зүгээр бас нэг том соёл эргээд орж ирж байна л гэж ойлгох хэрэгтэй. Хүүхэд хамжааргатай ордог. Гар утасны хэрэглээ нь их хамжааргатай болдог ийм юм орж ирж байна. Тэр сургалтад “Эй Ай”-ийг сургах, заах, нэвтрүүлэхийг би бүрэн дэмжинэ. Энэ бол дэлхийн хандлага. Хятадад ороод ирчихсэн байна. Бид компьютерын ухаан гээд хөтөлбөр дээрээ хиймэл оюун ухааныг заах асуудлыг хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд ид яриад явж байна.

Интернэтийн цахим орчин дахь SNS буюу нийгмийн сүлжээнд хүүхдүүдийнхээ эрхийг хэрхэн хамгаалах вэ, хүүхдээ хэрхэн хамгаалах вэ, хэрхэн зөв оролцдог соёлыг бий болгох вэ л гэдэг байгаа.

Өнөөдөр ямар ч хамгаалалтгүй яваад байхаар тролл буюу хуурамч хаягаар ордог. Тэгээд бие бие рүүгээ дайрдаг. Өнөөдөр ямар сөрөг нөлөө үзүүлээд байгааг Цагдаагийн ерөнхий газрын мэдээллээс хэлж байгаа.

Тэгэхээр мэдээж хүүхдүүдийг гар утсаа хэрэглэх, тэр сурах орчиндоо интернэтийн зөв “Эй Ай” ашиглах энэ бүх эрх нь.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Б.Баярсайхан гишүүн хариулъя. 5 дугаар микрофон.

Б.Баярсайхан: Би энэ дээр нэг тодруулга хийчихье гэж бодож байна.

Өсвөр насанд хүүхдийг цахим орчинд хамгаалах гээд байгаа юм. Бид өсвөр нас гэж хязгаарлаж болохгүй байгаа юм. Ц.Сандаг-Очир гишүүн нарын өргөн барьж байсан хууль дээр бид хамгийн гол санаа зовж байсан юм бол хэлд ороогүй хүүхдүүдэд гар утсыг хэрэглүүлснээрээ бид хэлээ алдах гээд байна. Үүнийгээ дагаад соёлоо алдаж байна. Монгол хүүхдүүд дандаа гаднын контент үзэж байна. Хүүхдийн хэл насанд тохирсон, ялангуяа цэцэрлэгийн насны хүүхдүүд, хэлд ороогүй хүүхдүүдэд зориулсан монгол контент хийж өгөөч ээ гэдэг асуудлыг Соёлын яаманд олон жил тавьж байгаа.

Тэгэхээр энэ ажлын хэсэгт Соёлын яам орж ирэх ёстой байх гэж бодож байна.

Хэл, соёлын асуудал алдагдах юм бол Монгол Улсын тусгаар тогтнол алдагдана.

Дээрээс нь сая дурдагдаагүй асуудлууд энэ CyberTips гээд олон улсын байгууллагаас 12-оос 18 насны хүүхдүүдийн дунд хийсэн судалгаагаар 85 хувь нь цахим гадуурхалд өртөж байна.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофоныг гүйцээгээд өгье.

Б.Баярсайхан: Дэлхийн хэмжээнд 2019-2020 онд энэ төрлийн гэмт хэрэг дэлхийн хэмжээнд 28 хувиар өсөж байхад Монгол Улсад 132 хувиар өсөж байна гэсэн ийм судалгаа байгаа.

Дээрээс нь жилд амиа хорлож байгаа 500 хүний 25 хувь нь. Монгол хүмүүс шүү. 10-аас 25 насны хүүхэд, залуучууд байна гэсэн асуудал байгаа.

Тэгэхээр бид цахим орчин гэхээр зүгээр нэг гар утасны хэрэглээ төдий бус. Энэ хүүхдүүдийнхээ сэтгэл санааны байдал гаднаас нь харахад харагдахгүй мөртлөө дотроо сэмэрсэн зүрхтэй, өөртөө итгэлгүй эмзэг насандаа зах хязгааргүй интернэт орчинд доромжлуулж байгаа, гадуурхагдаж байгаа, барьцаалагдаж байгаа хүүхдүүдийн асуудал.

Түрүүн би М.Нарантуяа-Нара гишүүний асуултад микрофон хаагдчихлаа. Тэр гэр бүлийн орчинд эцэг, эхчүүд өөрсдөө хүүхдүүдийнхээ хэнтэй найзалж нөхөрлөж байгааг харах асуудал, энэ дээр эцэг, эхийн.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофоныг гүйцээгээд өгье. 5 дугаар микрофон гүйцээгээд өгье.

Б.Баярсайхан: Тэгэхээр цахим орчны асуудал. Дээрээс нь дахиад манай Цахим харилцааны яам маань бүр “Эй ай” технологи, стратеги янз бүрийн юм ярьж байна л даа.

Гэтэл Монгол Улсад өнөөдөр Хүүхдийн хөгжлийн бодлого, хүнээ, хүүхдээ хөгжүүлэх бодлого, хүүхдээ цахим орчинд хамгаалах бодлого нь ерөөсөө байхгүй байгаа юм.

Тэгтэл улс орнууд техник, технологийг өндөр хөгжүүлэхийн хажуугаар яаж улс үндэстнийхээ хүмүүсийг тэр үндэстэн байх, тэр хэлээр нь, соёлоор нь, зан чанараар нь, ёс суртахуунаар нь хамгаалах вэ, мэдлэг боловсролоор нь хамгаалах вэ гэдэг бодлого зэрэг явж байж техник, технологийн асуудал хажууд нь явагдаж байгаа шүү.

Монгол Улсад болохоор хүний хөгжлийн бодлого, хүүхдийн хөгжлийн бодлого.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон гүйцээгээд өгчихье. Ахиж би өгөхгүй шүү. Б.Баярсайхан дарга аа.

Б.Баярсайхан: Баярлалаа. Тэгээд энэ ажлын хэсэгт Соёлын яамыг оруулж өгч, бас хуучин энэ хуулийг өргөн барьж байсан, одоо байгаа Их Хурлын гишүүд нь анхаарч, ялангуяа Хууль зүйн байнгын хорооны гишүүд ч гэсэн онцгой анхаарч өгөөч ээ.

Энэ бол зөвхөн өсвөр насны асуудал биш, боловсролын асуудал биш, хэл соёлоо алдах гээд байгаа асуудал. Хүүхдүүд маань сэтгэцийн өвчтэй болж байгаа асуудал. Гар үзэхгүй бол хоол идэхгүй болж байгаа асуудал, зан чанарын хүмүүжил төлөвшлийн тийм алдаанд орж байгаа хөгжлийн асуудал байгаад байгаа шүү гэдгийг нэмж хэлье. Баярлалаа.

Д.Цогтбаатар: П.Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Баярлалаа. Чухал асуудал хэлэлцэж байна. Сайд нар нь алга.

Нэг Засгийн газар бол нэг сайд яг нэг мэдээлэл хийх ёстой. Бусад сайдууд нь хариулаад дэмжлэг үзүүлээд явах ёстой. Гэтэл өнөөдөр П.Наранбаяр сайдаас гадна 3 Төрийн нарийн бичгийн дарга.

Засгийн газрын нэгдсэн мэдээлэл орж ирэх ёстой. Түүнээс биш 3 байгууллага нь Улсын Их Хурлын харьяа байгууллагын тухай ч юм уу, эсвэл олон улсын байгууллагын судлаачдын байр суурь бид сонсгоогүй байхгүй юу.

Тэгээд ерөөсөө энэ хэлэлцэхээс эхлээд оруулж ирж байгаа байдал энэ тэр бол ерөөсөө тийм сонин байна. Засгийн газар яг хүүхдийн асуудлыг хэн манлайлах ёстой юм, цахим орчин дахь хүүхдийн эрхийг хамгаалах асуудал

хэний асуудал юм гэх юм бол одоо яг тэр сайдаараа толгойлуулаад бусдууд нь ажлын хэсгээр орж ирэх ёстой.

Ганцхан П.Наранбаяр сайдын асуудал биш шүү дээ. П.Наранбаяр сайд ажлаа зохицуулаад ирж болж байхад нөгөө 3 сайд. Магадгүй энэ хүүхдийн асуудал ярихад Сангийн яам, Соёлын яам ч юм уу байх ёстой. Тэгээд ийм байдалтайгаар асуудалд хандахаар наадах чинь доороо очоод ерөөсөө эвлэхгүй.

Тэгээд П.Наранбаяр сайд нэг хуулийн төсөл танилцуулж байна л даа. Нэг ийм юм хийх гэж байгаа гээд.

Тэгэхээр энэ дээрээ анхаараач ээ гэдэг зүйлийг зүгээр хэлмээр байна.

Хоёрдугаарт, хуулийн төслийн үзэл баримтлалыг харлаа, зохицуулах харилцааг харлаа. 16-аас доош насны хүүхдүүдийг ерөөсөө сошиал медиаг хэрэглэхийг хориглоно л гэж байна. Тэгэхдээ их л хуурай сонсогдож байна.

Ер нь бид чинь үндэстэн дамнасан компанитай харьцах гэж байгаа гэдгээ бид хэд ойлгож байна уу, үгүй юу? Ер нь тэр нөхдүүдийн тавьдаг шаардлага дотоодын хууль тогтоомжоо гаргачихвал бид судалъя, төлөөлөгчийн газраа байгуулах эсэхээ шийдье гэдэг. Түүнээс биш ингээд бид хэд бүх юмыг болох гэж байгаа юм шиг л нэг ийм хуурай хууль хийгээд байх юм. Би жоохон ойлгохгүй байна.

Хоёрдугаарт, ерөөсөө гол асуудал маань хүүхдийн эрхийг цахим орчинд хязгаарлах гэхээсээ илүүтэйгээр тэр хүүхэд рүү хууль бус зүйл гэдэг юм уу, янз бүрийн байдлаар зүй бус харилцаа үүсгэж байгаа хэрэглэгчийг таних. Ерөөсөө энэ анхнаасаа хүүхэд байна уу, насанд хүрсэн хүн байна уу, цахим орчинд хэрэглэгчийг таних. Юугаар баталгаажуулж цаашдаа сошиал медиад орох юм бэ гэдэг зүйлийг л бид тодорхой болгох ёстой. Цахим гарын үсгээрээ юм уу, утасны дугаараараа юм уу, эсвэл тэр бид хэд 12 оронтой тоо байгаа шүү дээ. Иргэний бүртгэлийн дугаар. Үүгээрээ байх юм уу гэдгээ бид тодорхой болгох ёстой. Хэрэглэгчийг таньж байж дараа нь танина. Түүнээс биш зөвхөн гэдэг юм насанд хүрсэн эсэх асуудлыг л шийдэх хуулийг ярина гэх юм бол зохицуулалт нь хэцүү л байх. Яах вэ тэгээд оролдоод үзэх хэрэгтэй. Хүүхдийн асуудал чухал байна. Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах асуудал чухал байна. Энэ зүйлийг анхаараач гэж хүсэж байгаа юм.

Тэгээд гол хэлэх гэж байгаа санаа маань ерөөсөө нийгмийн дэд бүтцийн асуудал л даа. Түрүүн С.Эрдэнэболд гишүүн хэлчхэв үү дээ. Энэ асуудлыг шийдэхгүйгээр цахим орчны хязгаарлалтыг тавина гэдэг хэцүү.

Өөрөөр хэлэх юм бол хүүхэд.../минут дуусав/

Д.Цогтбаатар: П.Сайнзориг гишүүнд 1 минут нэмж өгье.

П.Сайнзориг: Цахимаас гараад COMMUNITY CENTER ороод үнэгүй секц дугуйланд орох бололцоо байна уу? Наад захын сургуулийн барилга, байгууламжийн стандартаас эхлээд бүх юмыг үзнэ, өөрчилнэ гэсэн үг.

Тэгээд өнөөдөр бүгдээрээ хүүхдийн парк дээр очоод үзээрэй. Та хэд бүгд хүүхэдтэй байх. Яг ингээд ажиллахад тэр ZIPLINE гээд ганцхан тоглоом хүүхдүүдийг соёлд сургаж байгаа шүү дээ. Очерлодог.

Бид хэд өнөөдөр байрны гадаа хүүхдүүдийн тоглоом дээр болохоор зүгээр нэг ийм гулсуур тавьж байгаа юм. Тэр ZIPLINE буюу хүүхдүүдийн сонирхлыг татдаг, бие бялдрыг хөгжүүлэхээс гадна том жижиггүй очерлож сурч байгаа, бие биетэйгээ нөхөрсөг харьцаж сурч байгаа. Тэгэхээр бид хэд хүүхдийн тоглоомын стандартаасаа эхлээд ингэж бодож хийх ёс байгаа юм.

Тэгээд ерөнхийдөө энэ соёлын бүтээлч үйл ажиллагааны тухай хуулийн тавьсан 18.3-ыг бүгдээрээ унагаасан шүү дээ. Яг төсөв хэлэлцэж байхад. Уг нь энэ чинь цахим орчинд биш хүүхдүүд спортын танхимд, соёлын байгууллага дээр байж илүү их гэдэг юм нийгэмших, бие биетэйгээ интернэт бус тэр орчинд хүмүүжих тэр зүйл рүү явсан юм.

Тэгэхээр энэ бодлогыг.../минут дуусав/

Д.Цогтбаатар: П.Наранбаяр сайд эхлээд хариулъя. 8 дугаар микрофон.

П.Наранбаяр: Тэгэхээр Засгийн газар өчигдөр Архангайд хуралдаан болоод, тэгээд зарим сайд нар нь яг энэ Хархорин төсөлтэй холбоотойгоор Ерөнхий сайдтай цуг Хархоринд ажиллах шаардлага гараад нэг ийм юм болсон.

Тэгэхээр өнөөдөр яах вэ энэ асуудал дээр яг энэ ажлууд нь давхацсан зарим нэгэн сайд нар хараахан хүрэлцэн ирж амжаагүй байх аа.

Юуны хувьд бид ойлгож байна. Энэ асуудлыг эртхэн ярилцаад, хоорондоо ярилцаад, нийгэмтэйгээ хэлэлцээд явах нь шаардлагатай.

Тэгэхээр П.Сайнзориг гишүүнд хандаж уриалахад Та энэ хуулийг орж ирэх. Мэдээж ердийн журмаараа хэлэлцээд явах үед нь сайхан дэмжээд яваарай. Дэмжээд явах байх гэж найдаж байна.

Үнэхээр таны санаа зовниж байгаа үнэн. Үндэстэн дамнасан корпорацтай бид харьцана. Энэ асуудлыг хэрхэн ойлгуулах вэ, хэрвээ тийм хязгаарлалтад орж ирвэл тэрийг хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлэх вэ гэдэг асуудал байгаа.

Жишээлбэл, Их Британийн хууль жишээлэх юм бол тэр хүүхдийн LOCATION-ыг харагдуулахгүй болгодог. Тэгж байж хүүхдээ хамгаалдаг гээд заалтууд нь нэлээн нарийн байдаг юм билээ.

Тэгэхээр таны хэлээд байгаачлан, Ц.Сандаг-Очир гишүүн ч хөндөж байсан. Нийгмийн дэд бүтцийн орчин, хүүхэд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх газруудын хувьд ч гэсэн. Тэгээд түүн дээрээ нийгмийн амьдралд оролцож зөв хүмүүжлийг өөр дээрээ авдаг ийм зүйлүүдийг ч гэсэн бид бүрдүүлэх тал дээр илүү анхаарах нь зүйтэй.

Тэгээд түрүүн би хэлж байсан. Ер нь номын сангийн үйлчилгээ манайд ер нь уначихсан шүү дээ. Тэгээд очоод суувал суудаг, эсвэл гэрээр нь ном олгодог номын сан их ховор.

Тэгэхээр ийм номын сангуудыг ч гэсэн нэмэгдүүлэх л шаардлагатай байгаа. Хүүхдэд гэр, тэгээд сургуулийн хооронд гуравдагч орчин зайлшгүй хэрэгтэй. Энэ асуудлыг ч гэсэн бид давхард нь шийдээд явах ёстой. Гол нь энэ дэлгэцийн айхтар донтолт. Түрүүн Б.Баярсайхан дарга хэлж байна. Эх хэлээрээ ярихгүй, YouTube үзсээр байгаад нэг эрлийз хэлтэй болчихсон хүүхдүүд ч байгаа шүү дээ. Өнөөдөр ээж, аав нь ч хэлээд байгааг нь ойлгохгүй. Иймэрхүү нөхцөл байдалд байгаа үед бид соёлоо хэрхэн хамгаалах юм, монгол хүүхдийг ядахдаа эрүүл нүдтэй яаж өсгөж хүмүүжих юм гэдэг л асуудал. Энэ дэлгэцийн донтол үнэхээрийн айхтар хэмжээнд хүрсэн шүү. Хүрсэн. Анхаарал төвлөрөл суларчихсан. Хүүхдүүд гэнэтхэн их уурладаг. Өөрийнхөө сэтгэлийн EQ[Emotional quotient] буюу сэтгэлийн хөдөлгөөнийг удирдаж чаддаггүй гээд л иймэрхүү нөхцөл байдал үүсээд байгаа нь дэлгэцийн энэ айхтар хамаарал тодорхой хэмжээнд хамаарч байгаа гэж боддог.

Ийм учраас энэ хуулийг гаргаж ирж, тодорхой заалтуудтай ийм хуулийг гаргаж ирж бид хүүхдийн эрхийг цахим орчинд хамгаалах SNS буюу нийгмийн сүлжээнд хамгаалах шаардлагатай байна гэж харж байгаа. Баярлалаа. Танд.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс өөр хариулах хүн байна уу? Хариулт хангалттай байна уу? П.Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Тэгэхээр хэдүүлээ энэ хот төлөвлөлтөөсөө эхлээд COMMUNITY CENTER-тэй болох, эргээд ногоон байгууламжтай болох, сургуулийн барилга байгууламжийн стандартыг зөвхөн хичээллэх танхим биш тийм цаг өнгөрүүлэх, дугуйлан хичээллэх, яг чөлөөтэй тэр ширээн дээрээ биш хүүхдүүд бие биетэйгээ тэр харилцаанд орж явах тийм анги танхим бий болгох асуудал дээр өөрчлөхгүй бол наадах чинь ерөөсөө ингээд мод шиг суулгаж байгаад хичээл хонх дуугарлаа. Гараад явдаг ийм танхим чинь хүүхдүүд бие биетэйгээ дугуйлан секцэд суухад хэцүү.

Тэгээд энэ Соёлын бүтээлч үйл ажиллагааны тухай хуульд байсан. Тэр бодлогыг уг нь зөв болгож оруулж ирмээр байгаа юм. Хүүхдүүд дугуйлан секц, спортоор хичээллэж байж л энэ цахим орчноос холдоно.

Хоёрдугаарт, хөдөлмөрийн бодлогоор ч бас өөрчилдөг. 3 нас хүртэлх хүүхдүүдтэй эцэг, эхчүүд ажиллавал илүү цагаар ажиллуулахгүй байх. Магадгүй юу гэдэг гэдэг юм гэр бүлдээ илүү их цаг зав гарцуулах үүднээс хагас, бүтэн сайнд ажилладаггүй байх ч юм уу. Төр бид ч гэсэн өөрсдөөсөө эхлэх байхгүй юу. Хагас, бүтэн сайнгүй хуралдаж байна шүү дээ.

Тэгээд тэнд байгаа хүмүүсийн хандлага.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Үг хэлэхээсээ 1 минут аваад явж болно. Хэн хариулах вэ? Гүйцээж. Ж.Алдаржавхлан гишүүний микрофоныг өгье.

Ж.Алдаржавхлан: Би ч нэг их олон юм асуухгүй ээ.

П.Наранбаяр сайд ээ, ер нь Монголд шийдэхгүй асуудлыг л энд яриад байгаа юм л даа. Бид хэчнээн их хууль гаргаад, хэчнээн том том хориг тавиад асуудлыг нь нөгөө том платформ эзэмшдэг компаниуд л шийднэ. Тийм ээ.

Тэгэхээр Та бүгд маань Цахим хөгжлийн яам энэ компаниудтай яг хэр харьцдаг юм бэ? Тэд нар ер нь та нартай хэр хамтын ажиллагаатай байдаг юм? Ер нь тоодог юм уу, үгүй юм уу? Энэ Facebook, энэ YouTube, энэ TikTok. Эд нар ер нь та бүгдтэй яг яаж харилцаж байна? Надад нэг тодорхой тийм юуг хэлж өгөөч гэж нэг дэх асуулт нь ийм байгаа юм.

Хоёрдугаарт нь, Facebook гэж хүүхдийн ч асуудал биш болчихсон. Монголын асуудал болчихсон. Дуртай нь Facebook дээр LIVE хийдэг, дуртай нь юм зардаг, дуртай нь хүнийг доромжилдог ийм том хэрэгсэл болсон. Тэгээд цахим орчинд хүүхдүүдийг гэмт хэргээс хамгаалах энэ Facebook-ийн асуудал их хүнд байгаа.

Зүгээр надад ийм нэг санаа байгаа юм. Би буруу ч хэлж байж магадгүй шүү. Ерөөсөө энэ Facebook-ийг 3 сар хааж үзвэл яадаг юм, Монголд. Тэр эффектийг нь харвал яасан юм. Гэмт хэрэг нь хаашаа шилжих юм, ямар платформ руу шилжиж байна. Facebook-гүйгээр амьдарч болно шүү дээ. Ер нь бол. Өмнө нь амьдарч болж байсан.

Тэгэхээр сар ч юм уу, 3 сар ч юм уу хаах тийм санаачилга гаргаж болохгүй юу?

Ерөөсөө бүхий л муу муухай бүх зүйл Facebook дээр явж байгаа шүү дээ. Энэ дээр нэг тийм тодорхой санал сайд хэлээч. Би сар юм уу, 3 сар хаачхаад

олон асуудал цэгцэрнэ дээ. Олон юмнууд харагдана даа. Гэмт хэргийн нөхцөл байдал үүнтэй холбоотой юм уу, үгүй юм уу гэдэг нь ч ойлгомжтой болж эхэлнэ.

Одоо бид П.Сайнзоригийн хэлдэг шиг хуурай тоо ярьж явж байгаа. Одоо гадаа гардаг хүүхэд байхгүй болсон. Бүгдээрээ мэдэж байгаа. Тийм ээ. iPad юм уу, гар утастай л гэртээ байгаа. Яаж гадаа гаргадаг болгох вэ, яаж нийгэмтэй харьцуулдаг болгох вэ? Энэ чиглэлээр Боловсролын яам, Засгийн газар ер бодож байна вэ? Энэ гурван асуултыг эхлээд асуучихъя. Тэгээд хариултаа авъя.

Д.Цогтбаатар: П.Наранбаяр гишүүний микрофоныг өгье. 8 дугаар микрофон.

П.Наранбаяр: Баярлалаа. Тийм би таны сүүлийнх нь асуултад хариулъя. Ажлын хэсгийг одоохондоо ахалж байгаа манай Д.Гантулга зөвлөх хариулаад явна. Тэр Австрали юутай холбоотой юмнуудыг.

Тэгэхээр маш сонирхолтой санал байна. Та их сонирхолтой тийм саналууд ярьдаг, их тийм шинэлэг ийм юм.

Би төсөөлөөд бодоод үзлээ л дээ. Би өөрөө 101 мянган дагагчтай ийм хүн. Тэгээд 6 сар хэрвээ Facebook-гүй болчихвол бидний мэдээлэл яаж хүрэх вэ, манай медиа буюу манай хэвлэл мэдээлэл өөрөө яах вэ. Тийм ээ. Нэг ийм их л сонирхолтой л орчин үүсэх юм байна.

Ковидын үед хил хаагдана гэж хэн ч бодохгүй байж байгаад л хил хааж үзсэн. Facebook-гүйгээр орчин үеийн нийгэм, SNS-гүйгээр 6 сар байгаад үзвэл яах гээд ингэх юм бол их л сонирхолтой л байна.

Зүгээр симуляц дээр хийж үзэж болох юм. Симуляц дээр. Тийм ээ. Симуляц дээр. Түүнээс биш яг үүнийг шууд хаавал гээд ингэх юм бол энэ оролцоонд суурилсан ардчилал, ардчиллын хүн өөрөө өөрийнхөө үзэл бодлыг чөлөөтэй дэлгэдэг талбар. Хэн ч гэсэн өөрөө сэтгүүлч шиг юм бичээд олон хүнд уншуулдаг боломж гээд л олон юмнууд байгаа.

Тэгэхээр зэрэг ийм зүйл нь хүний хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй шууд холбогдож магадгүй учраас бид болгоомжтой хандах ёстой гэж бодож байна.

Бид 16 нас хүртэлх хүүхдийг, өөрөөр хэлбэл Иргэний хуулийн 15.2 дээр байдаг тэр эрх зүйн бүрэн чадамжтай болтол нь л тэр хүүхдийг хамгаалаад, хязгаарлалт оруулаад оролцоог нь зохицуулаад явъя л гэсэн ийм л юм байгаа. Түүнээс биш яг энэ нийгмийн сүлжээний орчны чөлөөт байдлыг хадгалж явах ёстой л гэж бодож байна.

Тэгэхдээ таны энэ санал маш их сонирхолтой байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: 7 дугаар микрофон.

Д.Гантулга: Хууль зүйн байнгын хорооны эрхэм гишүүдийн оройн мэндийг эрье.

Боловсролын яаман дээр санаачилсан...

Д.Цогтбаатар: Уучлаарай. Өөрийгөө танилцуулаарай.

Д.Гантулга: Д.Гантулга Боловсролын сайдын зөвлөх. Ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж байгаа юм.

Ер нь маш товчоор хэлэх юм бол дэлгэцийн донтолт гээд байгаа нь хүмүүс өөрсдөө архины хамааралтай болдог, сүүлийн үед хар тамхины хамааралтай болж байна.

Хүүхдүүд дэлгэцийн хамааралтай болчихсон яг тархинд нь яг адилхан бодисын ялгараад явж байхад бид бүхэн харж чадахгүй байгаа. Энэ ганцхан Монголын асуудал биш энэ дэлхий даяар нүүрлэчихсэн асуудалдаа л түрүүлж үүнийг барьж явъя гэдэг ийм санаачилгыг Боловсролын яаман дээр яригдаж эхэлсэн.

Тэр олон улсын компаниуд, үндэстэн дамнасан том компаниудтай тулна. Одоо Австралийн хууль дээр хэрвээ 16-аас доош насны хүүхдэд аккаунт нээчихсэн байх юм бол.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 7 дугаар микрофон. Саяынхыг гүйцээгээд хариулаарай. Санкц нарынхаа тухай.

Д.Ганхуяг: Австрали тухайлбал Facebook дээр хүүхдүүд аккаунт нээсэн байх юм 30 мянган австрали долларын торгууль тавьдаг юм билээ.

Одоо METAVERSE-өөс Боловсролын яамтай энэ асуудлаар харилцъя. Бид ер нь дэмжиж байгаа гэдэг ийм байр сууриа илэрхийлсэн. Тэр 3 network-ээс, TikTok-оос бусад нь Австралид ч гэсэн ер нь дэмжээд хамтраад ажиллаж байгаа юм билээ.

Та бүхэнд сонирхуулвал дөнгөж өнөөдөр “Asia News Network” дээр бид бүгдийн санаачилж байгаа ажлын мэдээ гарсан байна лээ. Монгол Улс яг энэ хүүхдүүдээ цахим орчинд хамгаалах тал дээр санаачилгатай ажиллаж байна. Их Хурал дээрээ энэ асуудлаа ярилцаж байна гэсэн байдлаар мэдээ гарсан байна лээ.

Тэгэхээр бид бүгд нэг эхлүүлсэн ажлаа бариад хийх юм бол хүүхдүүддээ маш эерэг үр дүнтэй, ирээдүй хойчдоо хэрэгтэй зүйл болно байх гэж бодож байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Цахим хөгжлийн яам. 1 дүгээр микрофон.

П.Алтан-Од: Гишүүний асуултад хариулъя.

- 2019 оноос хойш “Meta”,
- 2020 онд “YouTube”,
- 2024 оноос “TikTok”, “X”

платформуудтай манай Харилцаа холбооны зохицуулах хороо шууд хамтын ажиллагаа өргөжүүлж ажиллаж байгаа.

Азийн бүс хариуцсан байгууллагатайгаа шууд мэдээлэл солилцох, тодорхой нөхцөл байдлууд дээр таслан сэргийлэх асуудлууд дээр шууд бодлогын түвшинд хамтарч ажилладаг.

YouTube Kids-ийн асуудлыг өмнөх гишүүн хөндөж байсан. YouTube Kids аппыг Монголд ашиглах боломжтой эсэх талаар, цаашид ашиглах, хөгжүүлэх, нэвтрүүлэх тал дээр манайхаас хүсэлт хүргүүлсэн ажиллаж байгаа.

Д.Цогтбаатар: Ж.Алдаржавхлан гишүүн тодруулъя.

Ж.Алдаржавхлан: П.Наранбаяр сайд аа, хоёулаа олон жил хамт ажиллаж байсан.

Гэхдээ миний санал. Зүгээр та хэд нэг туршаад үзээсэй л гэж бодож байгаа юм. Нэг сар ч юм уу. Заавал хүмүүсийн хэвлэн нийтлэх эрх чөлөөг хаах гээгүй эффектийг нь хармаар байгаа юм. Ер нь бол.

Энэ дээрээс та хэд Засгийн газрын гишүүний хувьд нэг анхааралдаа тавьж үзээч ээ гэж.

Хоёрдугаарт, сая Цахим хөгжлийн газрын хүн бид ингээд бичиг явуулчихсан байгаа гэж. Ер нь та нартай яг яаж харилцаад байна. Ингээд асуулт тавихад чинь маш хурдтай хариуг чинь өгч байна уу? Эсвэл удаашруулаад. Та хэд хүлээлтийн байдалтай байдаг юм уу? Тэр том корпорац ер нь Та бүгдтэй, Монгол Улстай хэрхэн харилцдаг юм? Тэрийг надад нэг хэлээд өгөөч.

Д.Цогтбаатар: 1 дүгээр микрофон. Өөрийгөө танилцуулаарай.

Т.Батболд: Харилцаа холбооны зохицуулах хороо Зохицуулалтын газрын дарга Т.Батболд. Ж.Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя.

Харилцаа холбооны зохицуулгах хороо нь 2019 оноос хойш Meta компанитай хамтын ажиллагаа эхлүүлээд явж байгаа. Meta компанийн хамтын ажиллагааны хүрээнд хууль бус контентыг Meta платформоос устгуулах хүрээнд хамтын ажиллагаа явдаг.

Холбогдож ажиллаж байгаа төв нь Ази, Номхон далай хариуцсан төв буюу Сингапурт байрлаж байгаа Meta компанийн оффистой харилцдаг. Meta компанийн оффист бид хэд оффисын Монгол болон Төв Ази, Непал, Шри-Ланкийг хариуцдаг мэргэжилтэнтэй нь шууд холбогдож ажиллаж байгаа.

Бид хэдийн хүсэлт тавьсан хариултад ер нь боломжит хугацаанд хариу өгдөг. Ялангуяа хүүхэдтэй холбоотой, хүүхдийг ялангуяа бэлгийн хүчирхийлэлд уруу татсан.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 1 дүгээр микрофон. Гүйцээгээд хариулъя.

Т.Батболд: Хүсэлтэд хурдан хариу өгдөг. Тийм. Хурдан хариу өгдөг.

Хүүхэдтэй холбоотой асуудал дээр 1-ээс 2 хоногийн дотор хариу өгдөг.

Д.Цогтбаатар: П.Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Тэгэхээр Ж.Алдаржавхлан гишүүн яг хэлж байна. Нэг үзээд алдвал гээд.

Тэгэхээр зарим нэг сургууль дээр бид үзье. Тийм ээ. Тэртээ тэргүй харилцах платформууд нь бэлэн сургуулиуд олон байдаг. Тэгээд тэнд хааж үзээд, тэгээд зөвхөн тэр платформуороо харилцаад, бас нэг туршиж үзэх боломж байна гэж харлаа. Баярлалаа.

Д.Цогтбаатар: А.Ариунзаяа гишүүний микрофоныг өгье. А.Ариунзаяа гишүүнд талархал илэрхийлмээр байна.

Манай Байнгын хороон дээр чухал асуудал хэлэлцэхэд тэвчээртэйгээр хүрч ирж сууж, асуудалд анхаарал хандуулж, идэвхтэй оролцож байгаад талархал илэрхийлж байна. Микрофоныг нь өгье.

А.Ариунзаяа: Хууль зүйн байнгын хорооны гишүүн биш учраас намайг тэвчээртэй сууж байгаад талархал дэвшүүлж байгаа шүү. Та бүхэн маань ойлгоорой.

Цахим орчин дахь өсвөр үеийн үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтын талаар мэдээллийг зөвхөн Хууль зүйн байнгын хороо бус бусад бүх Байнгын хороогоор сонсох хэрэгцээ шаардлага байна. Үүнийг ч гэсэн даргын дэргэдэх зөвлөл дээр хэлж өгөөрэй гэж Байнгын хорооны даргад хүсэж байна. Энэ бол хууль гэхээсээ илүүтэй яг энэ мэдээллийг сонсох нь зүйтэй. Хуулийг орж ирэхэд нь тухайн үед нь мэдээж дэмжээд явна.

Би өнгөрсөн жил Колумбын Засгийн газрын болон НҮБ-ын Хүүхдийн сангийн урилгаар Колумбад дэлхийн шийдвэр гаргагчид яг энэ хүүхэд хамгааллын бодлогын талаар олон улсын хуралд оролцсон.

Тэнд яг л энэ дээрэлхэлтийн талаар, цахим дээрэлхэлтийн талаар ярьсан. Тэгээд хамгийн гол асуудал нь юм бэ гэхээр цахим дээрэлхэлт нь өөрөө, цахим ялгаварлан гадуурхалт нь өөрөө хүүхдүүдийг амиа хорлоход хүргээд байна. Өөрөө өөрсдийгөө хамгаалж чадахгүй байгаа тэр субъектийг яаж хамгаалах вэ гэдгийг яриад байгаа байхгүй юу.

Тэгэхээр манай Монгол Улс ч гэсэн амиа хорлолтоороо дэлхийд 3-т орж бүс нутагтаа тэргүүлдэг. Яагаад хүн ам цөөнтэй мөртлөөсөө тэргүүлээд байна вэ гэхээр тухайн хүн амын бүлэгт нь эзлэх индексээр тооцдог байхгүй юу.

2023 оны датаг авч үзэхэд жилд 502 хүн амиа хорлосон. Сард 40 хүн гэсэн үг.

- 5-аас 9 насны 1 хүүхэд,
- 10-аас 14 насны 11 хүүхэд,
- 15-аас 19 насны 35 хүүхэд амиа хорлосон.

Сүүлийн 5 жилийн дата. 2019-2023 онд нийт 19 нас хүртэлх 253 хүүхэд амиа хорлосон байна.

Яагаад гэдэг учир шалтгааныг бид мэдэх үү? Мэдэхгүй шүү дээ. Бид нарт зүгээр амиа хорлосон гэдэг л дата байна. Энэ дээр хэн ч ажиллахгүй байгаа. Энэ дээр ажиллах боломж байгаа юу?

509 хүн, сард 40 хүн амиа хорлож байхад учир шалтгааныг нь мэдэх бүртгэх боломж байгаа юу? Хэн үүнийг хариуцах вэ? Үе тэнгийн дээрэлхэлтийн улмаас амиа хорлосон яах вэ? Яг тухайн асуудалд хүргэсэн хүүхдэд ямар асуудал бид дэвшүүлж болох вэ? Зөвхөн цахимд орохыг хязгаарлаад үе тэнгийн дээрэлхэлт болино гэсэн үг огтоос биш шүү, эрхэмүүд ээ.

Тэгэхээр яг үүн дээр томчууд бид яалт ч үгүй хүүхдүүд томчуудын толь гэдэг энэ үгтэй би санал нийлж байна. Б.Баярсайхан даргын хэлж байгаа, олон жил ажилласны үр дүн мөн.

Яг энэ цахим дээрэлхэлттэй холбоотой ямар хариуцлага байдаг вэ? Ер нь. Яг өнөөдөр асуудалд орсон байгаа хүн хаана хандах вэ? Хүүхэд хэнд хандах вэ?

Д.Цогтбаатар: Гүйцээж авах уу? Микрофон. Энэ дээр П.Наранбаяр сайд хариулах уу? Цахим хөгжлийн яам хариулах ёстой болов уу гэж бодож байна.

Тэгээд мэдээжийн хэрэг цагдаагаас энд хүн байж байгаа. Тийм ээ. Яг энэ асуудалтай цагдаагийнхан яг нүүр тулж байгаа. Тэгээд учир шалтгааныг мэдээж сонирхож судалсан байх ёстой. Гурван газар хариулах нь зөв гэж бодож байна. П.Наранбаяр сайдын микрофоныг өгье. 8 дугаар микрофон.

П.Наранбаяр: Үнэхээр энэ их сэтгэл зовоосон, үнэхээрийн хүнийг их юм бодуулахад хүргэсэн ийм тоо баримтыг эрхэм гишүүн А.Ариунзаяа та дурдаж байна.

Үнэхээрийн өнөөдрийн нийгмийн бухимдал, өнөөдрийн цахим орчин дахь дээрэлхэлт бол хүүхдийг маш их сэтгэл санааны гүнзгий хямралд оруулж, улмаар амиа хорлоход хүргэж байгаа тохиолдол ч гарсан тохиолдлуудыг би хэд хэдийг мэдэх юм байна.

Тэгэхээр ер нь бид анхаарч харж байхгүй бол. Та бүхэн мэдэж байгаа. **“Blue Whale”** гээд нэг айхтар сайт, challenge яваад хүүхдүүд амиа хорлосон тохиолдлуудаас гарч байсан. Нэлээн хэдэн жилийн өмнө. Ингэж энэ дээр анхаарах ёстой.

Тэгэхээр нарийн тоо баримтын хувьд манай Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан хариулах байх гэж бодож байна.

Ер нь цахим дээрэлхэлт их урхагтай. Сургуулийн орчинд хоёр хүүхдийн хооронд асуудал үүсвэл тэндээ явчихна. Гэтэл цахим дээрэлхэлт бол хүн болгон мэддэг. Энэ их эвгүй. Ийм учраас энэ асуудлыг шийдвэрлэхэд нэг талаараа бидний энэ яриад байгаа зохицуулах тухай хууль хувь нэмрээ оруулна гэж бодож байна.

Гэхдээ таны хэлдэгчлэн зөвхөн үүнийг шийдсэнээрээ асуудлыг бүрэн шийдвэрлэхэж байгаа ерөөсөө биш. Ерөөсөө биш. Зөв соёлыг хэрхэн бүрдүүлэх вэ. Эцэг, эхийн оролцоо, тэр сургууль дээр байгаа нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн, ялангуяа анги удирдсан багшийн оролцоонуудыг хэрхэн хангаж явах вэ гэдэг туйлын чухал.

Хүүхэд хамгаалыг хариуцсан ажилтнууд хороон дээр байгаа. Энэ хүмүүсийг ч гэсэн татан оруулах. Ингээд эрсдэлтэй гэр бүл дээр хамгаалалтын үйл ажиллагааг явуулах гээд нэлээн ажлууд хийгддэг юм билээ.

Энэ талаар тодруулж хариулна уу гэж урьж байна.

Д.Цогтбаатар: Хэн хариулах вэ? 9 дүгээр микрофон.

Л.Мөнхзул: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын харьяа Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн ерөнхий газар улсын хэмжээнд 21 аймаг, 9 дүүрэгт салбар нэгжүүдтэй. Улсын хэмжээнд 34 хүүхдийн эрхийн улсын байцаагч ажиллаж байгаа.

Аливаа хүүхдийн амиа хорлосон хэрэгт цагдаагийн байгууллагаас дуудлага өгсөн тохиолдолд очдог. Хүүхдийн эрхийн улсын байцаагч очиж кэйс дээр ажилладаг.

Ихэвчлэн мөрдөн шалгах ажиллагааны нууц гэдэг үндэслэлээр хүүхдийн эрхийн байцаагчийг ажиллуулах тийм боломж хязгаарлагдмал байдаг. Харин сургуулийн орчинд, ялангуяа хүүхдийн амьдрах дотуур байранд ийм харамсалтай тохиолдол гарсан тохиолдолд хүүхдийн эрхийн улсын байцаагч очиж хамтран ажиллаж, нөхцөл байдлын дүн шинжилгээг хийх, асран хамгаалагчтай нь уулзаж ярилцах, анхан шатын наад захын дүгнэлтүүдийг хийх л боломж байдаг.

Түүнээс яг энэ гэмт хэргийн шинж чанартай үйлдэлд байсан уу, эсвэл ямар учир шалтгаантай гэдгийг яг цагдаагийн байгууллага.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээж хариулах уу? 9 дүгээр микрофон. Цагдаагийн байгууллага. Цагдаагийн байгууллагаас Б.Батзориг дарга байсаг уу? 2 дугаар микрофон өгье. 2 дугаар микрофон.

Б.Мөнхбат: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье.

Мөрдөн байцаах албаны Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийн дарга, хурандаа Б.Мөнхбат байна.

Цагдаагийн байгууллага гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч шалгадаг. Хүүхэд хамгааллын тухай хуульд үе тэнгийн дээрэлхэлтийн хэлбэрүүдийг нь тодорхой зааж өгсөн байдаг.

Үе тэнгийн дээрэлхэлтийн улмаас магадгүй амь насаа хорлосон үндэслэл тогтоогдох юм бол холбогдох насанд хүрээгүй этгээд эрүүгийн хариуцлагад

татагдах, субъектийн насанд хамаарсан эсэхээс хамаараад эрүүгийн хариуцлагад цааш нь үргэлжлүүлэн шалгах эсэх асуудлыг шийдвэрлэдэг.

Цагдаагийн байгууллага гэмт хэрэг зөрчлийг шалгахдаа үйлдэгдэх болсон шалтгаан, нөхцөлийг тогтоож, үүнээс тодорхой урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгуулдаг.

Д.Цогтбаатар: Тэгэхдээ Б.Мөнхбат дарга аа, нэг ийм юм асууж байх шиг байна шүү дээ. Би А.Ариунзаяа гишүүний өмнөөс тодруулаад асуучихъя.

Яг хэдэн хувь нь. Сард 40 гэсэн байх аа. Тийм ээ. Ингэхэд цахимтай хэдэн хувь нь яг холбоотой байна вэ? Ийм тоо баримт байна уу л гэж асууж байх шиг байна шүү дээ.

Б.Баярсайхан дарга аа, та үүнийг хариулж болохгүй шүү дээ. Та тэрийг мэдэхгүй биз дээ.

Тэгэхээр үүнийг чинь 2 дугаар микрофон хариулъя.

Б.Мөнхбат: Тийм тодорхой тоо байхгүй.

Д.Цогтбаатар: А.Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Би тийм мэдээ байхгүй гэдгийг мэдэж байгаа учраас байгаа гэж асууж байгаа юм.

Энэ асуултаараа би юуг хэлэх гээд байна вэ гэхээр бид учир шалтгаантай тэмцэх ёстой байхгүй юу. Яагаад сард 40 хүн амиа хорлоод байгаа юм бэ. Би зөвхөн хүүхэд яриагүй. Яагаад жилдээ 500 хүн Монгол Улсад амиа хорлоод байгаа юм бэ. Учир шалтгааныг нь бид мэдэж чадах юм бол түүнийгээ арилгахын төлөө бид бодлого дэвшүүлж чадна.

Цахим дээрэлхэлттэй холбоотой олон улсын тэр хурал дээр яаж байна вэ гэхээр дөнгөж хайр дурлал эхэлж байгаа ч юм уу, хүүхдүүдтэй харилцаад шалдан зургаар харилцдаг ч юм уу. Тийм ээ. Тэгээд ийм эмзэг зургийг чинь би дэлгэнэ шүү. Би үүнийг чинь SCREENSHOT-ыг нь олон нийтэд тавина шүү гэж айлган сүрдүүлж мөнгө төгрөг нэхдэг, дээрэлхдэг, эсвэл зургийг нь аваад тавьдаг. Яаж хамгаалах вэ?

Д.Цогтбаатар: Энэ бол 2 дугаар микрофон хариулах байх.

Б.Мөнхбат: Таны хэлсэн саналуудыг ойлгож авлаа. Цаашдаа амиа хорлоход хүргэж байгаа шалтгаан нөхцөлийг зайлшгүй тогтоох нь зүй ёсны хэрэг. Үүнийг ойлголоо.

Д.Цогтбаатар: 1 минут. А.Ариунзаяа гишүүний микрофоныг өгье.

А.Ариунзаяа: Дэгээрээ угаасаа 1 минут тодруулаад, хангалтгүй гэж үзвэл дахиад 1 минут тодруулж болно гэсэн дэгтэй байгаа учраас үлдсэн 50 секундээ зүгээр нэг захиас хэлэх гэсэн юм.

Яг энэ хүүхдийн цахим дээрэлхэлтийн асуудал ер нь хүний хөгжлийн л асуудал. Б.Баярсайхан гишүүн бид хоёр өнгөрсөн 4 жилийн хугацаанд яг үүнийг маш их олон ярьж байлаа. Бид хоёр байр л солигдсон болохоос биш сэдэв нь хэвээрээ л байгаа юм.

Тэгэхээр энэ бол өөрөө хүний хөгжлийн асуудал юм. Энэ бол зөвхөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ч юм уу, Боловсролын яам ч юм уу, Цагдаагийн газар ч юм уу асуудал огтоос биш ээ.

Тэгэхээр энэ дээр бүх нийтээрээ анхаарах ёстой. Хүнийг дээрэлхэж угаасаа болохгүй. Том хүн ч бай, жоохон хүүхэд ч бай.

Тэгэхээр хариуцлагыг нь тодорхой болгох хэрэгтэй. Хуулиудаа хэрэгжүүлэх хэрэгтэй. Хүнээ хөгжүүлэх хэрэгтэй. Бүх Байнгын хороодоор энэ асуудлуудаа ярьж яваарай.

Д.Цогтбаатар: Гишүүд асуулт асууж дууслаа. Би нэг хэдэн асуулт асуугаадахъя.

Нэгдүгээрт, П.Наранбаяр сайдаас ийм зүйл асуумаар байна. Одоо энэ ингээд бусад орнуудын хуулийг дурдаад ярьж байна л даа. Тэгээд энд хамгийн сайн жишиг болсон BEST PRACTICES буюу энэ хуулиудыг бид авч үзэх нь зөв л гэж байх шиг байна.

Тэгэхээр сая бүгдээрээ ярихдаа их эергээр, энэ хууль яаж аягүй зөв үйлчилсэн тухай ярьж байна шүү дээ.

Тэгсэн энэ хуулийг дагаад энэ best practices-уудын чинь хэрэглээний явцад гарсан сөрөг үр дагаврын тийм тэмдэглэл ажиглалт байна уу? Өөрөөр хэлбэл үүнийг далимдуулаад үг хэлэх эрх чөлөө. Би хүүхдийн асуудлыг 100 хувь дэмжиж байна шүү дээ. Тэгсэн хүүхдийн асуудлаар далимдуулаад бусад хэвлэл мэдээллийн байгууллагууд буюу интернэт дээр зүгээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд, аж ахуйн нэгжийн эрх чөлөө рүү халдах тийм цонх, үүд хаалга нээгдсэн тийм сөрөг жишээ байна уу? Үүнийг яг нэг тодорхой хариулмаар байна.

Яагаад гэвэл энэ хуулиуд харьцангуй шинэ байгаа болохоор гүйцэд прецидентүүд гараагүй ч байж болно. Тэгэхдээ надад юу байна. Энэ талаар. Тэр сөрөг талын судалгаа хийж үзэв үү?

Хоёр дахь юм нь энэ ингээд цахим орчинд. П.Наранбаяр сайд сая ярьж байхдаа нэг ийм юм яриад байна шүү. Хууль гаргах гэж байгаа. Дэмжиж өгөөрэй гээд манай Байнгын хорооны гишүүд рүү та шууд уриалах маягтай ярьж байна.

Хууль санаачлах эрх Засгийн газарт, таны хувьд, гишүүний хувьд чинь байгаа. Гэхдээ өнөөдөр яг хууль гаргах тухай бид яриагүй. Зөвхөн энэ асуудал ямар хэмжээнд хүрчихсэн байна. Бид тоо баримттай би гишүүдийгээ танилцуулах үүднээс энэ хуралд оруулж ирж ярьж байгаа болохоор шууд нэг хууль хэлэлцэх гээд байгаа юм шиг ийм байдлаар бас яривал буруу ойлгогдоно шүү. Асуудалтайгаа эхлээд танилцаж байж дараа нь хуулийн асуудал яригдана.

Тэгэхээр би үүнтэй холбогдуулаад. Сая А.Ариунзаяа гишүүн ч яг асууж байгаа. Ерөөсөө ялгаварлан гадуурхах, BULLYING буюу үе тэнгийнхний дээрэлхэлт чинь өөрөө хуулиараа хориотой байгаа шүү дээ. Өнөөдөр.

Тэгээд түүн дотроо бүр цахим дээрэлхэлтийг өөрөө хорьчихсон заалт Хүүхэд хамгааллын тухай хуульд тодорхой орсон байгаа. Өнөөдөр энэ хууль чинь байхад яагаад нэмж хууль оруулах тухай яриа, санал сэдэл гараад байна вэ?

Тэгэхээр одоо байгаа хууль чинь хэрэв ажиллахгүй байгаа юм бол шинэ хууль гаргаад одоо байгаагаасаа юугаараа сайжрах вэ?

Ер нь хуулийн дагуу үе тэнгийн дээрэлхэлт чинь өөрөө угаасаа л хориотой байж байгаа шүү дээ. Хүний эрхийн ноцтой зөрчил.

Тэгэхээр үүнд надад нэг хариулт өгөөч. Одоо байгаа хууль нь нь болохгүй болоод байгаа учраас энэ цахим дээрэлхэлтийн тухай асуудлыг оруулж ирэх гээд байна. Тэгээд цахим дээрэлхэлт гэдгээрээ бүр хуульд тодорхой заагдаад орсон байгаа. Ийм хоёр асуултад хариулт өгөөч.

П.Наранбаяр сайд эхлээд хариулъя. Дараа нь би цагдаагийн байгууллагаас 2 дугаар микрофонд. Одоогийн хуульчны яг нь болохгүй байгаад байгаа юм бэ? Тэнд хариулж өгөөч.

П.Наранбаяр: Баярлалаа.

Тэгэхээрээ ер нь яг үр дүн нь энэ байна гээд л тэр лүүгээ бүх зүйлийг нийлүүлэх гээд яваад байгаа ийм хэрэг огт биш. Таны хэлсэнчлэн бид сөрөг үр дагаврыг нь ч харж байх ёстой, үг хэлэх эрх чөлөө рүү халдах ямар нэгэн юм

гарахыг хэзээ ч зөвшөөрч болохгүй. Тийм нэг үүд, сиймхий л гаргах юм бол майхны үүдээр хөөрхөн туулайны хамар ороод ирлээ гэсэн ч араас нь тэмээ ороод ирээд гэдэг шиг юм болгож ерөөсөө болохгүй. Энэ дээр би яг тантай яг 100 хувь санал нэг байна.

Австралид бидний судалсан хүрээнд Австралийн хууль 2025 оны 12 дугаар сараас эхэлж хэрэгжихээр байгаа юм. Энэ хооронд хуулийнхаа бэлтгэлийг бүрэн хангана гээд.

Тэгээд энэ өөрөө их тийм бидний хувьд шинэлэг хууль байгаа. Цаашдаа бид энэ хуулийг. Өнөөдөр зөвхөн танилцуулж, хууль гэхээсээ илүүтэй асуудал ийм байна шүү гэдэг ийм хүрээнд л өнөөдөр ярьж байгаа.

Тэгээд ер нь би түрүүнд яриад байгаа. Яг ингээд ердийн горимоороо хэлэлцэнэ. Яаралтай журмаар ерөөсөө биш. Ннийгэмд энэ чинь хэлцэл хийгдэж байж, санаа оноогоо тусгаж байж, зөв үү буруугаа ялгаж байж явахгүй бол янз янзын засгаас барьж байгаа нь тэр гээд л яаралтай журмаар орох юм бол энэ чинь өөрөө тун аюултай үзэгдэл учраас үүнийг бид тэгж огт бодохгүй байгаа. Өнөөдөр зүгээр мэдээлэл солилцох журмаар байгаа.

Тэгээд энэ үүднээсээ идэвхтэй оролцож байгаа эрхэм гишүүддээ би талархал илэрхийлье.

Тэр угаасаа Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль гэж байгаад сүүлдээ Хүүхэд хамгааллын тухай хууль гээд гарсан. 25 дугаар зүйл дээр энэ заалтууд нь үнэхээрийн байгаа.

Гэхдээ үүнийг амьдрал дээр бодитой хэрэгжүүлбэ гэхээр нэлээн тийм бүрхэгдүү заалтууд. Ер нь ингэж болохгүй, тэгж болохгүй гэсэн заалт байгаа болохоос биш энэ болгоныг шууд тэр PROVIDER буюу хийж байгаа компанитай нь ярилцаад ер нь 16 нас хүртэл нь хүүхдэд тохиромжгүй SNS буюу нийгмийн сүлжээн дэх орчинд нь зохицуулалт хэрэгтэй юм байна гэсэн ийм байдлаар зохицуулаагүйд байгаа.

Тэгээд үүнийг тусад нь хууль гаргаснаараа Австралийн гаргасан жишээ шиг. Өөрөөр хэлэх юм бол тухайн provider, энэ үйлчилгээг үзүүлж байгаа томоохон компаниуд ер нь Монгол Улсад тааруулж өөрсдийнхөө үйлчилгээг өөрчлөх, 13 наснаас эхэлдэг байсан бол 16 болгох.

Түүнээс гадна ер нь хүүхдийг хамгаалах гэдэг үүднээс ID буюу энэ чинь тролл биш, хуурамч хаяг биш байна гэдгийг бас магадлах гээд ийм ажлууд нэлээн явагдаж эхлэх болов уу гэж харж байгаа юм.

Гэхдээ хэлэлцүүлэг явж байна. Маш олон төрлийн хүмүүсийн дуу хоолойнууд орж ирнэ. Тэгээд ярилцаж явсаар байгаад тэгээд Монгол хүний мэргэн ухаан.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 2 дугаар микрофон.

Б.Мөнхбат: Мөрдөн байцаах албаны хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийн дарга, хурандаа Б.Мөнхбат байна.

Сүүлийн 5 жилийн байдлаар 2158 иргэн амиа хорлосон. Үүнээс 201 хүүхэд амиа хорлосон.

Үе тэнгийн дээрлэлтийн улмаас сүүлийн 5 жилийн байдлаар амиа хорлосон хүүхдийн тохиолдол бүртгэгдээгүй. Амиа хорлох гэдэг маань Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.4 дүгээр зүйлд заасан хэсэг байгаа. Жишээ ярих юм бол үе тэнгийн дээрлэлтийн улмаас, тэр нь тогтоогдсон тохиолдолд 10.4 гэсэн зүйл, хэсгээр зүйлчлэгдэж шалгагдахаар байгаа.

Өнөөдрийн байдлаар яг энэ үе тэнгийн дээрэлтээс болж амиа хорлосон гэдэг бодит нөхцөл байдал тогтоогдоогүй.

Д.Цогтбаатар: Тэгэхээр та нар энэ дээр бодох хэрэгтэй болчхож байна шүү дээ. Орж ирээд ярихлаараа амиа хорлолт гээд л яриад байдаг. Олон нийт болохоороо цахимаас болчхоод байгаа юм байна гээд. Ялангуяа хүүхдийн тухай ярихаар энэ чинь үүнтэй шууд шалтгаант холбоо байхгүй байгаа юм байна шүү дээ. Өнөөдөр бүртгэгдсэн байхгүй байна гэсэн үг.

Тэгээд энэ чинь олон нийт харж байгаа болохоор шууд холбоогүй шалтгааныг ярьж, иймэрхүү юм цаашаа үргэлжлүүлж бид ярих юм бол үүгээр халхавчилж нөгөө үг хэлэх эрх чөлөө рүү чинь халдах гээд байна уу, үгүй юу гэдэг л хүмүүсийн болгоомжлол явна шүү дээ.

Тийм учраас асуудлаа яривал холбоотой холбоотой юугаар нь. Тэгэхгүй айхтар том том ноцтой тоонууд яриад хүмүүсийг айлгаад байдаг. Яг шалтгаант холбоог нь асуухаар өнөөдөр тогтоогдсон юм байхгүй байна шүү дээ.

Ингээд гишүүд асуулт асууж дууслаа. Одоо хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү.

А.Ариунзаяа гишүүнээр тасаллаа. С.Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэболд: Нэг талаасаа бид “үндэсний дархлаатай монгол хүн”, “дэлхийд өрсөлдөх чадвартай монгол хүн”-ийг л яаж тэнцүү, өв тэгш хүмүүжих тухай, бий болгох тухай л яриад байгаа юм л даа.

Тэгэхээр “хаана”, “хорино”, “хориглоно”, “хязгаарлана” гэдэг асуудлаа ярихдаа саяын Д.Цогтбаатар даргын ярьж байгаа шиг их болгоомжтой, бодолтой хандахгүй бол beyond a reasonable doubt гэж хөдөлшгүй нотлох баримт гэж байдаг.

Тийм аргумент дээр суурилж л асуудлуудаа ярихгүй бол. Одоо жишээлбэл шүүх хурал дээр энэ хэрэг хийчихсэн болов уу гэж сэжиглээд байгаа хэрнээсээ нотлох баримт олдохгүй тэр хүнийг шууд ялгачхаж болдоггүйтэй л адилхан шийдвэр гаргалтдаа бид тэгж долоо хэмжиж, нэг огтлох ёстой болчихоод байгаа юм.

Хуулийн энэ үзэл санааг анхааралтай уншихаар

- ▷ Нэгдүгээрт, эрүүл мэнд,
- ▷ Хоёрдугаарт, оюун санаа,
- ▷ Гуравдугаарт, хүмүүжил,
- ▷ Дөрөвдүгээрт, төлөвшил.

Энэ 4 зүйл дээр сөрөг нөлөөлөл учруулж байгаа тэр барометрийг бууруулна гэсэн зорилт байгаа байхгүй юу. Тэгвэл энэ чинь өөрөө хэмжигдэх нэгжтэй байх ёстой. Энэ нь сөрөг нөлөө учруулж байгаа зүй тогтол нь түрүүний тэр Б.Баярсайхан даргын хэлээд байгаа шиг зөвхөн цахим орчин биш, маш олон төрлийн COMPREHENSIVE гэж хэлдэг. Олон талт зүйлээс бүрдээд байгаа юм.

Тэгэхээр үүнийгээ бид өвчнийг анагаахын тулд оношилж байж эм өгөхгүй бол багцаагаар багцаалдаад явахаар саяын Дамдины Цогтбаатар гишүүний хэлээд байгаа шиг энэ дээр далимдуулж өөр хүний эрхийн зөрчил үүсэх вий дээ гэсэн болгоомжлол байгаа юм. Нэг.

Хоёрт, “гэмт хэрэг”, “зөрчил”, “халдлагаас сэргийлэх” гэж байгаа юм. Тэгвэл яг “ямар гэмт хэргүүд”, “ямар зөрчлүүд”, “ямар төрлийн халдлага”-ууд гэдгээ тодорхой бөгөөд. Түрүүн би нэхээд байгаа симуляц гэдэг бол энэ хуулийн зохицуулалт бий болсноор нийгэмд ямар үр өгөөж авчрах юм бэ гэж. Тэгэнгүүт үзэл баримтлалын арыг нь уншихаар ерөнхий ийм романтик юмнууд биччихсэн байгаа байхгүй юу? Буурна гэж.

Тэгэхээр ирж байгаа шинэ тутам үүссэн нийгмийн харилцааны асуудлыг бид хуучин арга барилаар шийдэх боломж үгүй юм.

Тийм учраас энэ дээрээ сайн анзаараарай гэж хэлмээр байгаа юм.

О.Номинчимэг гишүүний хэлээд байгаа Facebook-ийг орлох. Жишээлбэл, сургуулийн орчинд багш нар даалгавар өгөх. Би ч гэсэн 3 хүүхэдтэй. Багш нар нь тэгдэг байхгүй юу. Групп нээчихдэг. Тэгээд тэр групп дээр нь даалгавруудыг нь тавьчихдаг. Орохоос өөр аргагүй болдог.

Ялангуяа КОВИД-оос хойшоогоо энэ бол дэлхий нийтийн хэмжээнд технологийн хурд 12 жилийн хурдаар урагшилчихсан байгаа юм.

- ▶ Дэлхийн II дайны 4 жилд технологи 35 жилийн хурдаар.
- ▶ Сая КОВИД-ын 2 жилд технологийн хурд 12 жилээр урагшилсан.

Үүний дам нөлөөнд нь болсон бэ гэхээрээ энэ интернэтийн хэрэглээ нэлээн өндөр түвшинд болсон юм. Тэгэхээр энэ дээрээ Та бүхэн бодооч.

Та бүхний танилцуулж байгаа бичиг баримт дээр үг, үсгийн алдаанууд байж байх жишээтэй. 4 яам гээд 4 сайдын нэртэй. Тэгээд үг, үсгийн алдаатай. Адаглаад наад зах нь бид жишээлбэл албан ёсны хэрэглээндээ WORD-ын ч юм уу, монгол хэлээр бичдэг, алдаагүй бичдэг зүйлийг ашиглаж чадахгүй байгаа шүү дээ. Нөгөө худалдаж авч чадахгүй байгаа. Бүгдээрээ. Тэгээд л алдаатай юмнууд оруулж ирдэг.

01 сарын 01-нээс монгол бичгийн хууль хэрэгжсэн. Тэгээд хаана байгаа юм. Нөгөө нэг хэрэгжсэн юм нь. Тэгээд цахимаар бид одоо хүртэл онлайнаар монгол бичгээр алдаагүй зөв бичдэг программ нэвтрүүлнэ гээд чадаагүй л байх жишээтэй.

Анхны үсэг буюу сууриа бид тавьж амжаагүй байж дараа дараагийн хуулийг хэрэгжих, хэрэгжихгүй нь баталгаатай биш, найдвартай биш. Тэр төсөөтэй байдлын судалгаа, үр дүнгийн урьдчилсан таамаглалыг шинжлэх ухааны аргачлалаар хийгээгүй юмнууд орж ирээд байгаа байхгүй юу.

Хуулийн үзэл санааг дэмжээд байгаа юм.

Гэхдээ түрүүн П.Наранбаяр сайд та асуудалд бөөрөнхийлөхгүй шууд хандах ёстой. Бүхэл бүтэн ардчиллын эсрэг зарчим ярьж байхад “Та их сонирхолтой санал гаргалаа. Ер нь хаачихвал яадаг юм бол” гээд ийм бөөрөнхий байр суурьтай байж болохгүй. Тодорхой том улсын хөгжлийн маш том боловсрол гэдэг салбар. Энэ чинь салбар гэхээсээ илүүтэйгээр суурь асуудлыг та авч явж байгаа хүн шүү дээ.

Тэгэхээр түрүүний хэлээд байгаа тэр 7 зүйл. Тэр эрүүл мэндээс өгсүүлээд “төлөвшил”, “хүмүүжил”, “оюун санаа” гэдэг эдгээр зүйл маань өөрсдөө зөвхөн энэ зүйлээс хамаарахгүй. Шалтгаан.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Тодруулах минут өгье. С.Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Бүх юмыг сагс руу хийхээс илүүтэйгээр яг энэ асуудлыг бид хуульчлаад хэм хэмжээ тогтоочих юм бол энэ түвшинд хүлээлттэй байж болно. Энэ түвшинд нийгэмд өөрчлөлт гарна гэдэг.

Дээрээс нь Б.Баярсайхан даргын хэлээд байгаа шиг жишээлбэл тэр “оюун санаа”, “хүмүүжил”, “төлөвшил” гэдэг чинь эцэг эх, сургууль, олон нийтийн байгууллага, боловсролын бодлогын асуудал, нийгмийн орчин гээд олон талт зүйлээс хамааралтай гэдгийг нь бид нухацтай авч үзэх ёстой л болчихоод байна л даа.

Тэгээд дээрээс нь тэр YouTube бид оруулчихсан. **YouTuber** гэдэг чинь бараг мэргэжлийн түвшинд хүрчихлээ шүү дээ. SILVER PLAY BUTTON буюу 100 мянган дагагчтай, дээрээс нь сая дагагчидтай Монголд олон YouTuber-үүд бий болчихлоо.

Энэ чинь дэлхий нийтийн ирээдүйн мэргэжлийн нэг хувилбар болчихсон байгаа байхгүй юу. Бид ирж яваа цагийнхаа аясыг харах ёстой, хандлагыг тодорхойлох ёстой. 90 гаруй триллион доллар дэлхийн эдийн засаг эргэлдэж байна. 2050 он гэхэд 250 их наяд долларт хүрнэ. Энэ дотор цахим платформуос үүдэлтэй бизнес гэдэг чинь өөрөө асар том зах зээл болчихсон байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ мэтийгээ бүрэн тооцоод симуляцаа гарга.../минут дуусав/

Д.Цогтбаатар: А.Ариунзаяа гишүүний микрофоныг өгье.

А.Ариунзаяа: Монгол Улс хүний эрхийн мэдрэмж үнэхээр өндөр.

Тэгээд яг одоо энэ хүний эрхийн мэдрэмж гэдэг дээр суурилаад Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар болон Хүний эрхийн дэд хорооны дарга С.Эрдэнэболд нар хүүхдийн хөгжих, хоорондоо харилцах эрхийг хөндчих вий дээ гэдэг агуулгаар цахим дээрэлхэлтийг өнөөгийн байгаа хуулийн зохицуулалтаараа зохицуулж чадахгүй байгаа учраас зүгээр шууд хорих гээд байна уу гэдэг асуултыг тавиад байна. Энэ зөв асуулт.

Хүүхдүүд ч гэсэн миний хөгжих, эрхийг хязгаарлалаа гэдэг байдлаар, эцэг эхчүүд ч гэсэн маш олон эцэг эхчүүд миний хүүхдийн хөгжих эрхэд халдлаа гэдэг байдлаар хандах магадлалтай. Маш өндөр магадлалтай.

Тэгэхээр хууль процессоороо явна биз. Тухайн үедээ болох вэ. Зүгээр үүн дээрээ суурилад, одоо байгаа нөхцөл байдал дээрээ суурилад яагаад цахим дээрэлхэлтийг бид зогсоож чадахгүй байна вэ гэдэгтэй дүгнэлт хийх хэрэгтэй. Хуулиар хэн хэн ямар үүрэг хүлээсэн юм. Түүнийгээ хэн хэн яаж хэрэгжүүлж байгаа юм гэдэг дээрээ суурилад явах юм бол сахилга хариуцлагын арга хэмжээнүүдээ сайн явуулж чадах байх.

Хууль тогтоомж байгаа хэдий ч бид түүнийгээ сурталчилдаггүй, мөрддөггүй, хариуцлага тооцож чаддаггүй.

Би түрүүн асуусан. Хүүхэд хаана хандах вэ. Яг өнөөдөр дарамтад орчихсон байгаа. Би чиний чатыг чинь дэлгэнэ шүү. Би чиний тийм бичлэгийг чинь тавина шүү гэж дарамтад орчихсон байгаа хүүхэд хаана хандах вэ. Ийм гарц гаргалгаа байгаа юу. Ээж, аавдаа хэлэхээс ичиж байна. Багшдаа хэлэх үү, нийгмийн ажилтандаа хэлэх үү, хаана хандах вэ гэдэг ийм том асуулт байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээрээ ч гэсэн бид суурилад өнөөдөр хүүхдүүд дээрээ аян явуулах уу, яах вэ. Олон нийтийн анхаарлын төвд оруулж ирэхэд бид зөвхөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам гэж харж болохгүй, Боловсролын яам гэж харж болохгүй.

Дахиад хэлэхэд энэ Засгийн газрын түвшинд томоор яригдах ёстой. Нийгмийн асуудал гэхээр зүгээр л эмэгтэйчүүдийн л ярьдаг асуудал гэдэг шиг чуулган дээр хүртэл Хүүхэд хамгааллын хууль орж ирэхэд цөөхөн хэдэн эмэгтэйчүүд л сууж байдаг шүү дээ.

Гэтэл энэ чинь манай хүний асуудал. Монгол Улсын хөгжлийн асуудал. Тийм ээ. Тэгээд энэ дээр томчууд ч гэсэн өөрсдөө үлгэр дуурайлалтай байх ёстой. Хүүхдийнхээ дэргэд ямар үг хэрэглэх вэ, хүүхэдтэйгээ байхдаа ямар авир гаргах вэ. Хүүхдүүд ч гэсэн цахим орчинд томчуудыг харж л байгаа шүү дээ. Ингэж болдог юм байна гэдэг байдлаар л хандаж байгаа юм. Хариуцлага байхгүй бол энэ явдал зогсохгүй. Хэвээрээ л байна.

Тэгэхээр төр төмөр нүүрээ хаана үзүүлж чаддаг юм үзүүлэх газартаа үзүүлдэг байгаасай гэж хүсэж байгаа юм.

Амиа хорлолтын асуудлыг бид том түвшинд анхаарч ярих цаг нь болсон. Сард 40 хүн гэдэг бол маш харамсалтай. Үүн дээр тодорхой учир шалтгаанууд байдаг бол түүнийгээ хуваалцахыг хүсэж байна.

Тэгээд түүн дээрээ суурилад бодлогуудыг, хөтөлбөрүүдийг тусгайлж гаргаж олон нийтэд мэдээлэхгүй ч гэсэн төрийн байгууллагууд зайлшгүй хамтарч ажиллах хэрэгцээ шаардлага байна гэж үзэж байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Би ганц хоёр зүйл хэлье гэж бодож байна.

Нэгдүгээрт, нэг зүйлийг хэдүүлээ тал талдаа ойлгох хэрэгтэй. Энэ сошиал орчин гэдэг бол хүн төрөлхтний маш том ололт. Хүүхэд ч байна уу, том хүн ч байна уу мэдлэгийн цараа, мэдээллийн хүрээг урьд өмнө байгаагүй хэмжээнд тэлж өгсөн.

Тийм учраас хүүхэд маш хурдан мэдээлэл авч, хичээл номдоо үүнийг дараа нь ашиглах. Тэр тархи нь өөрөө хөгжөөд ирэхээрээ ердийн эрдмийн хичээлдээ ч гэсэн сурахад нь энэ эергээр нөлөөлж байгаа юмнууд бас бий.

Тэгэхээр үүнд бид өгөөж нь хэр байгаа билээ. Тэгэхээр сөрөг талыг нь яаж тэр өгөөжид хор болохгүйгээр үүнийг зохицуулах вэ гэдэг юмаа бид ярих ёстой. Тэр утгаараа би хүүхдийн эрхийн асуудлыг онцгой анхаарч ажиллана.

Тийм ч учраас П.Наранбаяр сайдыг энэ талаар мэдээлэл хийе гэхэд би дуртайгаар хүлээж авч Байнгын хороон дээрээ энэ мэдээллийг сонсож байна.

Мэдээлэл сонсоно гэдэг чинь ёстой арав дахин хэмжиж байж нэг удаа огтлох тухай л, долоо дахин хэмжиж байж нэг удаа огтлох тухай л асуудал яригдаж байгаа юм.

Төр гэдэг монстерт нэг л эрх өгөхөд, миллиметр өгөхөд дараа нь метр зайны нөлөө гаргана гэж бодох ёстой. Улс төр судлаачид угаасаа NECESSARY EVIL гэж. Зайлшгүй чөтгөр гэж нэрлэдэг шүү дээ. Би хэлээд байгаа юм биш. Угаасаа улс төр судлал дээр, ялангуяа энэ ардчилсан орнуудын зүй тогтол дээр иргэдийнхээ эрх чөлөөг хамгаалахын үүднээс ингэж ойлгож ирдэг. Өөрөө төрийн хүн байж төрдөө дургүй гээд байгаа биш.

Тэгэхдээ төр өөрөө өөрийнхөө хэм хэмжээг мэдэж, ойлгож, би чинь бас буруу юм хийчих том эрсдэлтэй этгээд шүү гэдгээ өөрөө л ухамсарлаж байхгүй бол нэг мэдэхэд л иргэдийн эрх чөлөө рүү халдаад орох эрсдэлтэй. Тэрийгээ бид сайн бодолцох ёстой. Тэгээд өгөөж тал чинь маш их байгаа шүү.

Одоо сүүлийн үед үүнийг эмзэглэж, сөргөөр ярих хандлага аягүй их болоод байна. Тэрийг нь бид өөгшүүлж дэвэргэх юм наадах чинь буруу тийшээ явчих үнэхээр том эрсдэлтэй.

Тэгэхээр үүнийгээ сайн бодох ёстой. Дүгнэж, цэгнэж хандах ёстой.

П.Наранбаяр сайдад хандаад нэг зүйл хэлчихье. Цахим хөгжлийн яам ч гэсэн энэ дээр бодолцоорой. Том том хэвлэл мэдээллийн сошиал компаниудтай

харьцахад хэр хурдан хариу өгч байна, яаж байна ийж байна гээд асуугаад байна шүү дээ.

Тэгэхээр яг энэ хүүхдийн эрх хамгаалах тал дээрээ харин НҮБ-ын тогтоолын төсөл санал болгоод явах нь зөв. Ингээд олон улсын түвшинд эрх зүйн, өөрөө НҮБ-ын тогтоолын төсөл гэдэг бол бусад орнууд үүнтэйгээ нийцүүлээд хуулиа гаргах олон улсын хуулийн эх сурвалж нь болоод өгнө.

Энэ дээрээ тэр яг зөв санаануудаа бүгдийг нь оруулж өгөөд холбогдох том байгууллагууд энэ үзэл санааны хүрээнд бусад орнуудтай ажиллаж байх ёстой. Ялангуяа жижиг орнуудын засаг захиргаатай тавьж байгаа зүй ёсны шаардлагад нь хариулаад хамтраад ажиллах ёстой шүү гэдэг ийм агуулгатай тогтоолын төсөл санаачлаад явахад энэ маш эрүүл үзэгдэл.

Тэгэхээр үүнийгээ харин боловсруулах дээр би туслаад, төсөл боловсруулахад нь хамтраад ажиллаад өгч болно. Тэгээд үүнийг тал талдаа хэдүүлээ НҮБ-тэйгээ яриад үүнийг ажиллуулж болно шүү. Ингэх цаг нь ч болсон байгаа байх.

Тэгэхээр үүнийг бид бодоод үзэх юм дараа нь харин энэ суурин дээрээ үндэслээд бусад орнууд хуулиа ч илүү боловсронгуй болгож болно, нөгөө байгууллагуудтай харьцах олон улсын эрх зүйн үндэс бүрдчихэж байгаа байхгүй юу. Тэгээд үүнийг бодолцож ажиллана биз гэж бодож байна.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. /алх цохив/

Өнөөдөр цахим орчин дахь өсвөр үеийнхний үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт, сэтгэл санааны хүчирхийлэл, түүний хор уршгийн талаарх Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсролын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонслоо.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье. Гишүүддээ баярлалаа. Ажлын хэсгийнхэнд баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 4 цаг 00 минут үргэлжилж, 18 цаг 45 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД